

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-4
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	5-56

1.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан	5-46
---	------

2.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах хүрээнд суралцагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх, хооллох зөв дадал төлөвшүүлэх, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	46-56
--	-------

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Өргөдлийн байнгын хорооны
05 дугаар сарын 27-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Өргөдлийн байнгын хорооны дарга О.Номинчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 21 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 25 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: С.Ганбаатар, Ц.Идэрбат;
Чөлөөтэй: Ж.Золжаргал;
Тасалсан: Б.Пунсалмаа.

**Нэг.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл,
үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн
үнэлгээний тайлан**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, мөн яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга Л.Ганбат, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Батшагай, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Отгонжаргал, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, мөн газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Б.Оролзодмаа, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн боловсролын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Б.Болормаа, мөн хэлтсийн Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Өлзийбаяр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Дэнсмаа, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Баттөр, мөн төвийн Хоол тэжээлийн нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан Эрдэм шинжилгээний ажилтан Ж.Баясгалан, Хэт боловсруулсан болон баяжуулсан хүнсний асуудал хариуцсан Эрдэм шинжилгээний ажилтан Д.Дэлгэрмаа, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, мөн холбооны Судалгааны төвийн эрхлэгч Г.Оюунболд, судлаач О.Энххүслэн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Шим тэжээл судлалын тэнхимийн эрхлэгч Б.Лувсанлхүндэв, Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн захирал В.Хоролгарав, Нийслэлийн Баянгол дүүргийн Боловсролын хэлтсийн хоол зүйч Г.Амаржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат, мөн газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Нямсүрэн, өргөдөл, гомдол хариуцсан ажилтан Д.Оюун, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Ж.Сайнхишиг, мөн газрын референт Г.Нямдэлгэр, Ч.Сарантуяа, Ц.Элбэгзаяа нар байлцав.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг Боловсролын яамны Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, хуулийн хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ, судалгааг Монголын хуульчдын холбооны судлаач О.Энххүслэн, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганмаа нар тус тус танилцуулав.

Тайлан болон судалгаатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Д.Рэгдэл, О.Саранчулуун, Б.Бат-Эрдэнэ, О.Номинчимэг, Ж.Батсуурь, П.Сайнзориг нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, мөн яамны Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Монголын хуульчдын холбооны судлаач О.Энххүслэн, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Дэнсмаа, Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн захирал В.Хоролгарав нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, О.Саранчулуун, П.Сайнзориг, П.Мөнхтулга, О.Номинчимэг нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг хэлэлцлээ.

Уг асуудлыг 16 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг хэлэлцэх асуудлын дарааллын хоёрдугаар асуудал болох Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах хүрээнд суралцагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх, хооллох зөв дадал төлөвшүүлэх, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт, гуравдугаар асуудал болох “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг нэгтгэн хэлэлцэх горимын санал гаргав.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 8
Бүгд: 17

52.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул дээрх асуудлуудыг нэгтгэн хэлэлцэхээр тогтов.

Хоёр.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах хүрээнд суралцагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх, хооллох зөв дадал төлөвшүүлэх, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир, мөн яамны Ерөнхий боловсролын бодлого зохицуулалтын газрын дарга Л.Ганбат, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Т.Түмэнжаргал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, мөн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Батшагай, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Отгонжаргал, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Эрдэнэбаяр, мөн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Б.Цэцэгсайхан, мөн газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Б.Оролзодмаа, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин, Нийслэлийн боловсролын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Б.Болормаа, мөн хэлтсийн Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Өлзийбаяр, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Дэнсмаа, Жижиг, дунд үйлдвэрийн газрын дарга Я.Эрдэнэсайхан, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Л.Баттөр, мөн төвийн Хоол тэжээлийн нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан Эрдэм шинжилгээний ажилтан Ж.Баясгалан, Хэт боловсруулсан болон баяжуулсан хүнсний асуудал хариуцсан Эрдэм шинжилгээний ажилтан Д.Дэлгэрмаа, Монголын хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, мөн холбооны Судалгааны төвийн эрхлэгч Г.Оюунболд, судлаач О.Энххүслэн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Шим тэжээл судлалын тэнхимийн эрхлэгч Б.Лувсанлхүндэв, Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн захирал В.Хоролгарав, Нийслэлийн Баянгол дүүргийн Боловсролын хэлтсийн хоол зүйч Г.Амаржаргал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Г.Эрдэнэбат, мөн газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Өргөдлийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Нямсүрэн, өргөдөл, гомдол хариуцсан ажилтан Д.Оюун, Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Ж.Сайнхишиг, мөн газрын референт Г.Нямдэлгэр, Ч.Сарантуяа, Ц.Элбэгзаяа нар байлцав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон тогтоолын төслийн талаар ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал танилцуулав.

Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл, О.Номинчимэг нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Ням-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэл “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хавсралтгүйгээр буюу шалгуур үзүүлэлтгүйгээр баталъя гэсэн горимын санал гаргав.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын гишүүн Д.Рэгдэлийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 2
Татгалзсан: 15
Бүгд: 17
11.8 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

О.Номинчимэг: “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг редакцын утга, агуулга өөрчлөхгүй, нэр томъёоллыг илүү тодорхой болгох редакцын засвартайгаар чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 7
Бүгд: 17
58.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 17 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 58 минут үргэлжилж, ирвэл зохих 21 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 81.0 хувийн ирцтэйгээр 17 цаг 23 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ

ДАРГА

О.НОМИНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
14 цаг 25 минут.

**ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

О.Номинчимэг: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Нийт 21 гишүүнээс 12 гишүүн одоогоор ирсэн байна. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн, Халтмаагийн Баттулга гишүүн, Хажекберийн Жангабыл гишүүн, Дүгэрийн Рэгдэл гишүүн, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн, Жанчивын Галбадрах гишүүн, Сонгабайн Замира гишүүн, Отгоны Саранчулуун, гишүүн, Жамбын Батсуурь гишүүн, Даваасамбуугийн Ганмаа гишүүн, Мягмардашийн Сарнай гишүүн, Одсүрэнгийн Номинчимэг нар хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдөр 3 асуудал хэлэлцэхээр байна.

1 дүгээр, Ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг сонсоно.

2 дугаарт, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах хүрээнд суралцагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх, хооллох зөв дадал төлөвшүүлэх, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлтийг сонсоно.

3 дугаарт, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэхээр байна. Энэ 3 дугаар дахь төсөл маань 2 дугаарт хэлэлцэх ажлын хэсгийн санал, дүгнэлт дээр үндэслэн боловсруулж орж ирсэн тогтоолын төсөл байгаа.

Энэ өнөөдөр бол 05 сарын 27-ны өдөр Улсын Их Хурлын даргаас бас 5 сарын сүүлийн 7 хоногийг бид хүүхдийн эрхийг хангах чиглэлд илүү анхаарч ажиллах энэ санаачилгын хүрээнд бидний өмнө нь ч гэсэн Байнгын хороон дээрээс ажлын хэсэг байгуулж, өвөл 12 сард бас санаачилга гаргаж хэрэгжилтийн тайланг сонсъё гээд Хяналт шалгалтын газар бол үнэлгээ хийлгэсэн байгаа. Тэгэхээр энэ үнэлгээгээ сонсоод ажлын хэсгийн санал, дүгнэлтээ сонсоод тогтоолын төсөл хэлэлцэхээр Байнгын хорооны өнөөдрийн тов дараалал хэлэлцэх асуудалд орсон байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс саналтай гишүүн байна уу?

Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё. Ажлын хэсгийг оруулаарай.

1 дүгээрт, хэлэлцэх асуудал буюу Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт туссаны дагуу ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.8-д холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлаас хийсэн хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг хүлээн авснаас хойш 1 сарын дотор хэлэлцэнэ гэж, 13.9-д шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хороо нь Засгийн газар төрийн бусад байгууллагын хийсэн хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг сонсож хэлэлцэнэ гэж заасны дагуу Боловсролын яамнаас хийсэн үр дагаврын үнэлгээний тайлан болон Өргөдлийн байнгын хорооны саналаар Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хянан шалгалтын цаглаварт тусгагдсан, тусгагдан хийлгэсэн үр дагаврын үнэлгээний тайланг хамтатган хэлэлцэх гэж байна.

Энэ манай Өргөдлийн байнгын хорооны гишүүн Галбадрах гишүүн, Саранчулуун гишүүн маань яг энэ хоол үйлдвэрлэл, тэр дундаа ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн хоол үйлдвэрлэл, чанар аюулгүй байдлын асуудал дээр хэрэгжилтийн үнэлгээ хийлгэх захиалгыг өгч, Тамгын газраас бас захиалагч энэ үнэлгээ хийсэн байгаа.

Түүнтэй зэрэгцүүлээд Боловсролын яам бас энэ үнэлгээг өмнө нь хийлгэсэн байгаа. Тэгээд 2 үнэлгээний тайлан байгаа учраас өнөөдөр бас нэгтгээд бид сонсоод үнэлгээний тайланг бас харах юм бол ялгаатай өөр 2 өнцгөөс харсан асуудлууд байгаа учраас нэгтгэж хэлэлцэх гэж байна.

Хоёуланг нь сонсоно. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Улсын Их Хурлын Тамгын газраас Улсын Их Хурлын Тамгын газрын дэд дарга Ганбатын Эрдэнэбат, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын дарга Жамбалдоржийн Сайнхишиг, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт Цэрэнбалжирын Элбэгзаяа, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээний газрын референт Чулуунбатын Сарантуяа нар оролцож байна.

Холбогдох яамнуудаас Төрийн нарийн бичгийн дарга нар буюу Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Төмөр-Очирын Ням-Очир. Ням-Очир дарга Эдийн засгийн байнгын хороон дээр 27 оны юу асуугдаад ороод ирэх юм байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн яа үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга яасан Жамбалцэрэн? Хүнсний яамныхан Төрийн нарийнаа дуудаарай. Хүнс, хөдөө аж ахуйн яам хамгийн чухал. Ерөөсөө энэ яам бодлогын хүрээнд оролцож ирээгүйгээс болоод бид нар энэ хэрэгжилтийн үр дүнд гарч байгаа үр дагаврыг харж байгаа шүү. Алтаншагай дарга Төрийн нарийнаа

дуудаарай. Одоо шууд орж ир гэж хэлээрэй. Ойрхон байгаа байлгүй дээ. Ирнэ гэж уг нь хэлсэн юм байна шүү дээ. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Намжилын Эрдэнэбаяр бас ирнэ. Эдийн засгийн байнгын хороон дээр Хөгжлийн төлөвлөгөө дээр асуугдаад дуусахаараа ирэх юм байна.

Боловсролын яамнаас Боловсролын яамны Санхүүгийн хэлтсийн дарга Адьяасүрэн, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Төмөрбаатарын Түмэнжаргал нар ирсэн байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга Даваасүрэнгийн Довчинсүрэн ирсэн байна. Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Баясгалангийн Батшагай дарга. Түрүүн Алтаншагай гээд хэлчхэж уучлаарай. Довчинсүрэн дарга Төрийн нарийнаа дуудаарай. Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Дамирангийн Отгонжаргал нар ирсэн байна.

Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Батмөнхийн Цэцэгсайхан, Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газрын Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Баасанхүүгийн Оролзодмаа нар оролцож байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийн газраас Жижиг, дунд үйлдвэрлэлийн газрын дарга Ядамсүрэнгийн Эрдэнэсайхан хаачсан Эрдэнэсайхан?Эрдэнэсайхан дарга харагдаж байна.

Нийслэлээс Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдол асуудал хариуцсан орлогч Амгаланбаярын Амартүвшин ирсэн байна. Нийслэлийн боловсролын газраас бодлого хэрэгжилтийн газрын дарга ...-гийн Болормаа ирсэн байна. Нийслэлийн боловсролын газраас Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Хүүхдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Баасанжавын Өлзийбаяр ирсэн байна. Мөн Нийслэлийн эрүүл мэндийн үндэсний төвөөс Нийслэлийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал Лхагваагийн Баттөр ирсэн байна. Хоол тэжээлийн нийгмийн эрүүл мэндийн асуудал хариуцсан эрдэм шинжилгээний ажилтай Жамбалдоржийн Баясгалан ирсэн байна. Хэт боловсруулсан болон баяжуулсан хүнсний асуудал хариуцсан эрдэм шинжилгээний ажилтай Дашзэвэгийн Дэлгэрмаа нар ирсэн байна.

Сангийн яамнаас Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Будрагчаагийн Дэнсмаа ирсэн байна. Монголын Хуульчдын холбооноос бас оролцож байгаа юм байна үнэлгээ хийсэн хүмүүс байгаа байх. Хуульчдын холбооны Тамгын газрын дарга ... Жолбарс ирсэн байна. Монголын Хуульчдын холбооны Судалгааны төвийн эрхлэгч Ганчулууны Оюунболд ирсэн байна. Судлаач Очбадрахын Энххүслэн ирсэн байна.

Эрдэмтэн судлаач, сургуулийн төлөөллөөс Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Шим тэжээл судлалын тэнхимийн эрхлэгч Болдсайханы Лувсанлхүндэв ирсэн байна. Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн захирал Ванганы Хоролгарав ирсэн байна. Нийслэлийн Баянгол дүүргийн боловсролын хэлтсийн хоол зүйч Гомбын Амаржаргал ирсэн байна.

Тэгээд бид бас энэ Байнгын хороогоор хуулийн хэрэгжилтийн үнэлгээ бол бид нар ингээд цаасаар гаргаад цаасан суурьтай энэ хэрэгжилтийн үнэлгээнээсээ дараагийн хууль боловсруулах шат руу ингэж явдаг жишиг байсан. Гэхдээ энэ удаа бид бас энэ хэрэгжилтийн үнэлгээг олон талаас нь Байнгын хороогоороо заавал нээлттэй хэлэлцэж олон оролцогч талуудыгаа оролцуулж, хэлэлцэж, энэ дээрээсээ бодлогын асуудал шийдлүүд нь цаашаа юу байх юм гэдгийг бол илүү тодорхой нээлттэй бас ярилцдаг болъё гэсэн энэ зорилгын хүрээнд бас энэ 2 хэрэгжилтийн үнэлгээг бол сонсож байгаа гэдгийг хэлмээр байна.

Ингээд 3 танилцуулга байгаа учраас танилцуулгадаа оръё. Эхний танилцуулгыг Боловсролын яамнаас хийсэн үр дагаврын үнэлгээний тайланг Боловсролын яамны Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга Түмэнжаргал танилцуулна. 1 дүгээр микрофон дээр 15 минутад билүү. 15 минутад багтаагаад Түмэнжаргал дарга үнэлгээний тайлангийн гол үр дагаварт хийсэн үнэлгээнийхээ гол асуудлуудыг танилцуулна уу хэмээн урьж байна. 1 номерын микрофон.

Т.Түмэнжаргал: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд миний бие энэ Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг товчхон танилцуулъя. Яагаад гэвэл гишүүний хэлсэнчлэн үнэлгээний тайланг бол бид нар бол урьдчилаад хүргүүлчихсэн байгаа.

Ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль бол 2019 онд батлагдаад 20 оноос хэрэгжиж эхэлсэн. Одоо 6 дахь жилдээ орж байна.

Мэдээж хуулийн маань гол зорилго, хамрах хүрээ бол бүх 1-12 дугаар ангийн бүх сурагчдыг үдийн хоол хөтөлбөрт хамруулах. Гэхдээ яг энэ хүүхдүүдэд зориулсан шим тэжээлийн тэнцвэртэй хоол, хүнсээр үйлчлэх, мэдээж энэ хуулийн хүрээнд үндэсний болон орон нутгийн хүнс үйлдвэрлэлийг дэмжих, мөн нийгмийн халамжийн буюу өрхийн амьжиргааны түвшнийг дэмжих гэсэн ийм гол агуулгаар энэ хуулийн маань гол 4 концепц ингэж явдаг байгаа.

Хуулийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд бид нар 20 оноос хууль маань хэрэгжээд 21 оны 9 сарын 1-нээс 1-5 дугаар ангийн 380 гаруй мянган хүүхдэд үдийн хоол хөтөлбөрийг хамруулсан. Энэ хүрээндээ бол хуулийн хэрэгжилтийн хүрээнд Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, хуульд заасан дүрэм, журам, стандарт гээд ингээд үндсэндээ 30 гаруй баримт бичиг, эрх зүйн баримт бичгүүд бол энэ 6 жилийн хугацаанд батлагдсан байна.

25-26 оны хичээлийн жилд бол боловсролын салбарт бол төрийн өмчийн 717 сургуульд нийт бол 740 орчим мянган 1-12 дугаар ангийн хүүхдүүд сурдаг. Үүний бол 42 хувь буюу түрүүний миний хэлсэнчлэн 1-5 дугаар ангийн 340 гаруй мянган хүүхэд бол яг үдийн хоолны үйлчилгээнд хамрагдаж байна.

Тэгэхээр энэ дээр бид нар юу гэж хэлэх вэ гэхээр хуулийн хэрэгжилтийн хүрээнд бид нар хуулийг хэрэгжүүлэх 53 дугаар тогтоол мөн гарсан байгаа. Үүгээр бол 23-24 оны хичээлийн жилд 6-12 дугаар ангийн бүх хүүхдүүдийг бид нар үдийн хоол хөтөлбөрт хамруулах ёстой байсан. Гэсэн хэдий ч бид нарт бол хойшлуулж явсаар байгаад өдийг болтлоо бид нар бол зөвхөн 1-5 дугаар ангийн хүүхдийгээ бол үдийн хоол хөтөлбөрт хамруулж байна гэдгийг бас онцолж хэлмээр байна.

Их Хурлын 36 дугаар тогтоол гээд 22 онд батлагдсан. Энэ тогтоолын хүрээнд бол энэ Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хангамжийн хэсэгт өөрчлөлт оруулаач гэдэг ийм заалт орсон учраас энэ хүрээндээ бид нар өнөөдрийн танилцуулах гэж байгаа энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг бол бид нар хийсэн байгаа.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг бас яг энэ хуулийн төслийг боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулахад бол зөвхөн манай яам биш Хүнс, хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яам гээд 3 яам хамтарч хийхээр орсон байгаа. Энэ хүрээндээ бол Хөдөө аж ахуйн яам бас яг энэ хангамжийн хүрээнд бас хуулийн үр дагаврын үнэлгээ хийлгэсэн байгаа.

2025 онд буюу өнгөрсөн жил Боловсролын яамны зүгээс бол энэ хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхэд бол хуулийн хэрэгжилт маань 34.6 хувьтай гарсан байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар бас нэг онцолж хэлэхэд энэ Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль бол юуны зөвхөн сургуулийн хоол үйлдвэр, үйлчилгээтэй холбоотой биш яг Хүнсний тухай хууль болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хууль гэсэн малгай хуулийнхаа салбар хууль гарч явдаг учраас тухайн хуулийн хэрэгжилттэй шууд холбоотой. Тийм учраас бас хуулийн хэрэгжилт маань бас харьцангуй бага үнэлгээтэй ингэж гарсан болов уу гэж ингэж дүгнэж байгаа.

Хуулийн хэрэгжилтийн үнэлгээг бол ерөнхийдөө бол бас яг Хууль тогтоомжийнх нь тухай хуульд заасны дагуу хийсэн байгаа. Энэ дээр бол оролцогч байгууллагуудын түрүүний миний хэлдэг 34.6 хувь дээр бол зөвхөн Боловсролын яам гэхгүй бусад төрийн байгууллагууд, аймаг орон нутгийн Засаг дарга, сургуулийн захирал, Сангийн яам гээд ингээд бүх байгууллагууд оролцогч талууд энэ хуулийн хэрэгжилтэд орж байгаа. Тэгэхээр эдгээр оролцогч талуудын бол хуулийн хэрэгжилтийн үнэлгээг бол нэг бүрчлэн ингэж гаргасан байгаа.

Энэ дээр би бас нэг юмыг тодруулж хэлэхэд түрүүн миний хэлсэнчлэн хууль дагаж гарсан эрх зүйн баримт бичиг, тогтоол шийдвэрүүд бол хангалттай гарсан. Хамгийн гол нь энийг хэрэгжүүлэх үе шат дээр бол оновчтой буюу бол бас тодорхой үр дүн гаргаж хэрэгжээгүй гэдгийг бас би энд цохон тэмдэглэж хэлмээр байна.

Мэдээж энэ хуулийн хэрэгжилтийг хийхдээ бид нар яг түрүүний хэлсэнчлэн Засгийн газрын тогтоолд заасны дагуу яг арга, аргачлалын дагуу бэлэн мэдээ, мэдээллийг цуглуулах, тухайн сургуулиуд дээр очих, хэрэгжүүлж байгаа төрийн байгууллагууд дээр очиж уулзалт хийх гэдэг ийм байдлаар энэ үр дагаврын үнэлгээг хийсэн байгаа.

Ерөнхийдөө би нөгөө цаг товчлох үүднээс саяын тэр 34.6 хувь дээр гарсан энэ задаргаануудыг бас ингээд харуулж байна. Тэгэхээр энэ дээр бас яг онцолж бага гарсан энэ заалтууд дээрээ би бас ганц 2 тодорхой үр дүнгүүдийг хэлээд ингээд явна.

Хуулийн хэрэгжилтийн үр дүнгүүд бол ингэж гарсан байгаа. Энэ дээр бол хуулийн хэрэгжилт дээр бас бага гарсан нэг үзүүлэлтийн нэг бол сургуулийн хоол, үйлдвэр үйлчилгээ, гал тогоо, хүний нөөцийн асуудал ингээд байж байгаа. Тэгэхээр 2020 онд хууль хэрэгжихдээ бол түрээсийн сургуулиуд буюу сургууль, аж

ахуйн нэгжид түрээсэлдэг 100 гаран сургууль улсын хэмжээнд байсан. Одоо энэ 25-26 оны хичээлийн жилд бол 42 сургууль болж буурсан байгаа.

Тэгэхээр энэний цаана юу вэ гэхээр төр өөрөө хуулийн зарчим нь төр өөрөө гал тогоогоо ажиллуулах үүрэгтэй. Энэ хүрээндээ энэ түрээсийн гал тогоог гаргахад тэн дээр ажиллах хүний нөөц, тоног төхөөрөмжийн хангалтуудыг бид нар үе шаттай ингээд тавьж явсан учраас яг ийм бага хэрэгжилттэй ингэж гарсан гэж ингэж үзэж байгаа.

Цаашдаа мэдээж 6-12 дугаар ангийн хүүхдүүдийг хоолонд оруулах юм бол яг энэ гал тогоо, хүний нөөцийн асуудал бас бид нарт тулгамдсан асуудал ингээд болж байгаа.

Дээр нь сая миний хэлсэн бас хүний нөөцийн асуудал гээд би ярьсан. Энэ дээр бол сургуулийн хоол зүйчийн асуудал байгаа. Тэгэхээр хоол зүйч гэдэг дээр би бас яг тодруулж хэлмээр байна. Энэ бол хууль дээрээ бол сургууль болгонд хоол зүйч ажиллана гээд заачихсан байгаа.

Тэгэхээр энэ хуулийн гол хэрэгжилтийн амин сүнс бол өөрөө хоол зүйч байдаг. Тэгэхээр энэ сургууль дээр хоол зүйчийг хангах асуудал бол цаашдаа бид нар хуулийнхаа хэрэгжилтийн хүрээнд хангуулаад явна.

2020 онд бол 6 сургууль хоол зүйчтэй байсан бол одоо 300 гаруй сургууль ингээд хоол зүйчийн удирдлага доор бол хоол үйлдвэрлэлээ ингээд явуулж байгаа.

Бид нарын дараагийн хамгийн бас нэг том тулгамдсан энэ хуулийн хэрэгжилтэд нөлөөлсөн үйл ажиллагаа бол хүнсний хангамжийн асуудал байгаа. Тэгэхээр өнөөдөр хүнсний хангамжийн асуудал дээр бол сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны хэрэгцээ бол 10.9 мянган тонн байдаг. Энэ бол хүн амын хэрэгцээнд бэлтгэж байгаа хүнсний бол 10 хүрэхгүй хувийг энэ гол нэрийн энэ 6 нэр төрлийн бүтээгдэхүүнүүд бол эзэлдэг байгаа.

Тэгэхээр энэ дээр бид нар бас тусгайлсан хүүхдэдээ зориулсан энэ хамгийн нэн чухал энэ хоол үйлдвэр, үйлчилгээнд бол энэ бага хэрэгцээ мөртөө цаанаа маш олон хүүхдэд үр дүнгээ өгч байгаа энэ хангамжийн асуудал дээр бол онцгойлон, тусгайлсан ийм зохицуулсан бодлого дэмжлэг хэрэгтэй байна гэдгийг би бас хэлж байгаа юм.

Энэ дээр бол яг өнөөдрийн байдлаар ханган нийлүүлэлтийн ажил ер нь сургууль, цэцэрлэгт яаж явагдаж байгаа вэ гэдэг ийг бол товчлон харуулсан байгаа. Тэгэхээр энэ дээр онцолж хэлэх нэг юм бол зах худалдааны төвөөс шууд худалдан авалтыг хийж байгаа. Энэ дээр бол ялангуяа орон нутагт та бүхэн мэдэж байгаа байх сургууль, цэцэрлэгийн тендерт оролцох аж ахуйн нэгж байдаггүй, тендерийн босгыг давдаггүй. Тэр утгаараа тендер амжилтгүй болоход зах худалдааны төвөөс худалдан авалтыг хийж байна.

Тэгэхээр энэ маань өөрөө яг хоол хүнсний баталгаат хордлого, халдвар, аюулгүй байдлыг хангуулахад бас эрсдэл учруулж байгаа нэг том жишээ байгаа. Яах вэ сүүлийн үед бол нийслэл дээр бид нар ерөнхий гэрээ буюу Төрийн худалдан авах ажиллагааны газар Хүнс, аж ахуйн яамтай хамтраад цахим дэлгүүрийн үйл ажиллагааг явуулсан байгаа. Энэ дээр бол хагас боловсруулсан

байдлаар хүнсний бүтээгдэхүүнийг аж ахуйн нэгжээс авах ийм үйл ажиллагаа эхлээд ингээд явж байгаа. Тэгэхдээ энийг бол цаашдаа сайжруулах өргөжүүлэх ийм шаардлагатай байгаа.

3 дугаар хамгийн том энэ хуулийн хэрэгжилтийн үр дүнд нөлөөлсөн асуудал бол санхүүжилт, төсвийн асуудал байж байгаа. Тэгэхээр энэ дээр бол боловсролын салбарт байгаа сургууль, цэцэрлэг, дотуур байр гээд ингээд сая гаруй хүүхдэд бол жилдээ 331 тэрбум төгрөг батлагддаг.

Тэгэхээр энэ 331 тэрбум төгрөгийг бид нар яг түрүүний хуулийн гол зарчим болох үндэсний үйлдвэрлэлээ дэмжих, аж ахуйн нэгжээ дэмжих, ханган нийлүүлэх, бас нэг ханган нийлүүлэлтийг дэмжих бас нэг том бодлого, боломж энд явж байгаа юм шүү гэдгийг би бас хэлмээр байна.

Тэгэхээр энэ маань өөрөө яг 1 хүүхэд дээр очихоороо өнөөдөр бас сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал бол хангалтгүй хэмжээнд байгаа. Сургууль дээр 2500, цэцэрлэг дээр 3-4 мянган төгрөг явж байгаа нь авах ёстой илчлэг, шим тэжээлийнхээ 60-70 хувийг л авч байгаа. Тэгэхээр бид нар өнөөдөр хүүхдүүддээ дутуу шим тэжээлтэй хоол ингээд өгч байна гэж үзэж байгаа.

Дээр нь бид нар энэ дээр бол энэ хүүхдийн хоолны зардлыг зөвхөн түүхий эдийн зардал, тогоочийн зардал гэж яахгүй. Яг энэ хоол үйлдвэр, үйлчилгээ гэдэг бол бүхэл бүтэн дэд бүтэц, процесс байдаг. Тийм учраас цаашдаа ер нь энэ Сангийн яамтайгаа ярьж байгаад энэ сургуулийн хүүхдийн хоолны зардлыг өртөг буюу яг 1 хүүхдэд зориулагдсан тэр өртгөөр нь санхүүжүүлэх нь хүүхэд бүрд тэгш үйлчилгээг хүргэнэ. Дээр нь яг нөгөө санхүүжилт, төсвийн хувьд бас цаашдаа оновчтой хэлбэр болох юм гэж ингэж үзэж байгаа.

Дээр нь энэ дээр бол ер нь бол бусад улс орнууд бол яг энэ 1 хүүхдийн хоолны зардлыг ингэж тусад нь түүхий эд, хүний нөөц гэхгүйгээр тэр үйлчилгээг бүхэл бүтэн явуулахад ямар зардал гарах вэ? Тэр өртгөөр нь ингэж санхүүжүүлдэг ийм улс орнууд ийм жишигтэй байгаа. Тэгэхээр цаашдаа бол энийг хэрвээ үр дүнтэй болгоё гэвэл яг 1 хүүхдийн бүрэн өртгөөр нь санхүүжүүлж явах нь зүйтэй гэсэн ийм шийдэл, саналыг бас энд хэлж байгаа юм.

Ингээд ерөнхийдөө би мэдээллээ ингээд дуусгая. Ер нь бол яг энэ хуулийн хэрэгжилтийг хангуулахад хамгийн гол нь бид нарт батлагдсан төсвөөс гадна энэ салбар дундын оролцоо, хамтын ажиллагаа, бодлого, шийдлүүд бас маш чухал байгаа. Тийм учраас бас яг энэ чиглэлээр маань бас яг энэ Өргөдлийн байнгын хороо харж үзээд, яг авч үзээд манай энэ асуудлыг бас ингэж хэлэлцэж тогтоол шийдвэр гаргах гэж байгаад бол салбарын яамны зүгээс бол маш их баяртай байгаа.

Дээр нь би энэ дээр нэг ганцхан жишээ хэлчихье. Яагаад энэ дунд, ахлах ангийн хүүхдүүдийг хоолонд оруулах гээд нэн шаардлагатай вэ гэдгийг хүн болгон л мэдэж байгаа. Түрүүний миний хэлдгээр хуулийн хугацаа бол болчихсон. Энэ дээр бол бид нар НҮБ-ын Хүүхдийн сан болон ахлах, дунд ангийн хүүхдүүд өөрсдөө оролцсон ийм судалгааг хийсэн байгаа.

Тэгэхээр энэ судалгааны дүнд бол нийт 600 гаруй сурагчид оролцсон байгаа гэж байгаа. Энэ дээр бол 210 нь бага, 400 гаруй сурга хүүхэд нь бол ихэнх нь бид нарын яриад байгаа дунд, ахлах ангийн хүүхдүүд байгаа. Тэгэхээр энэ дээр бол

эдгээр хүүхдүүд маань ерөнхийдөө бол бага ангийн сурагчид бол 2100 төгрөгийг өдөртөө эцэг эхээсээ авдаг.

Дунд ангийн сурагчид бол ерөнхийдөө бараг 20 мянга хүртэлх төгрөгийг эцэг эхээсээ авч явж ингэж хоол авч иддэг гэсэн байгаа. Тэгэхээр энэ дээр бид нар сургуулиас хоол нэгдсэн журмаар өгөхгүйгээс шалтгаалаад ямар асуудал үүсэж байна гэхээр сургуулийн орчинд бол маш хүнсний эрсдэлтэй, эрүүл ахуйн шаардлага хангахгүй дандаа шарсан, хуурсан, нөгөө чихэрлэг бүтээгдэхүүнүүд чинь худалдаалагдаж байгаа учраас энэнээс түрүүний хүүхдүүд маань эцэг эхээсээ авсан мөнгөөрөө худалдан авалтыг хийж байна.

Тэгэхээр энэ дээрээс бол зөвхөн сургуулийн хоолыг чанартай болгоод зогсохгүй сургуулийн орчин дахь энэ хүнсний бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдалд хяналт тавихгүй бол эрсдэл маань учрах нь гэдгийг би бас дунд, ахлах ангийн хүүхдүүдээ хоолонд оруулах нэн тулгамдсан асуудал байгаа учраас энэ судалгааны дүнг бас тодруулж хэллээ. Баярлалаа.

О.Номинчимэг: Баярлалаа Түмэнжаргал даргад баярлалаа. Дараагийн танилцуулгыг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгагдан хийгдсэн үр дагаврын үнэлгээний тайланг Монголын Хуульчдын холбооноос манай Улсын Их Хурлын Тамгын газрын Парламент судалгааны хүрээлэнгээс захиалан хийлгэсэн байна. Байнгын хорооны захиалгын дагуу. Тэгээд Хуульчдын холбооны судлаач Энххүслэн танилцуулгаа хийнэ үү гэж урьж байна. 15 минутын дотор. 2 номерын микрофон уу, 1 үү? 2 чинь ойрхон биш үү? 2 номерын микрофон Энххүслэн судлаач. 15 минут.

О.Энххүслэн: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Би болохоор Хуульчдын холбооны хуульч, судлаач Энххүслэн байна. Тэгээд манай судалгааны баг болохлоороо О.Энххүслэн, Болор-Эрдэнэ, Сэлэнгэ гэсэн 3 хуульч, судлаачийн бүрэлдэхүүнтэйгээр энэ ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн байгаа.

Ерөнхийдөө агуулгын хувьд авч үзэхлээр бид нар 4 шалгуур үзүүлэлтийн хэмжээнд 5 хамрах хүрээг авч асуудлыг ер нь судалсан байгаа. Тэгээд удиртгал төслийн тухайд болохоор ерөнхийдөө энэ хууль маань 7 дахь жилдээ хэрэгжиж байгаа буюу 2019 оноос хойш хойш хэрэгжиж байгаа. Нийтдээ 717 төрийн өмчит, 900 төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль байгаа. Тэгээд 819 мянга гаруй суралцагчид одоо суралцаж байгаа.

Сүүлийн жилүүдэд бол хоолны аюулгүй байдал, шим тэжээл болон нөхцөл бусад нөхцөл байдалтай холбоотой олон асуудал үүссэний улмаас энэхүү хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг түүнээс гадна Хууль тогтоомжийн тухай хуульд энэхүү хуульд 5 жил тутамд үнэлгээ хийнэ гэсэн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу энэхүү судалгааг хийсэн байгаа.

Цаг хэмнэх үүднээс энэ шалгуур үзүүлэлтүүдийг алгасаад яг гол 5 хамрах хүрээнийхээ хэмжээнд аваад үзчихье. Эхнийх нь болохлоороо энэ ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлд оролцож байгаа төрийн байгууллага болон бусад этгээдүүдийн эрх, үүргийн талаар гэж байгаа юм.

Эрх, үүргийн хувьд болохлоороо Засгийн газар, Боловсролын яам, аймаг, дүүргийн Засаг дарга, сургуулийн захирал, хяналтын зөвлөл, хоол зүйч гэх мэтчилэн голлох субъектүүд. Түүнээс гадна болохлоороо Төрийн худалдан авах ажиллагааны газар, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв гэх мэтчилэн ийм газрууд өөрсдийн хууль тогтоомжоор хэрэгжүүлэх чиг үүргийнхээ хэмжээнд хэрэгжүүлээд ажиллаж байгаа. т

Бид судалгааны хүрээнд ямар асуудлууд тулгарсан бэ гэхлээр эхнийх нь Засгийн газрын хэмжээнд энэ нормативыг жил болгон батална гэсэн байгаад байгаа. Тэгтэл хамгийн сүүлийн норматив баталсан нь болохоор 2024 оны 12 сарын 30-д. Тэгэхлээр энэ жил болгон батална гэсэн хуулийн зүйл заалт нь өөрөө хэрэгжихгүй байгаа юм болов уу гэдэг эхний нэг дүгнэлт гарсан.

Хоёрт нь болохлоороо энэ сургуулийн хоол зүйч буюу хоол зүйч нь нийтдээ 900 сургуульд 319 хоол зүйч байгаа буюу хоол зүйчийг томилох тэр сургуулийн захирлын чиг үүрэг бас ингээд хэрэгжихгүй байна уу гэдэг асуудал.

Түүнээс гадна хориглосон хоол хүнсний бүтээгдэхүүний талаар журмын хэрэгжилт буюу 150 метрийн дотор хоол, хүнс зарж байгаа тийм тохиолдлууд. Үүний дараа нь ярих болохлоороо тийм нөхцөл байдал илэрч байгаа. Түүнээс гадна сургалт, сурталчилгааг болохоороо хууль дээр зөв хооллолтын талаар сургалт, сурталчилгааг хэрэгжүүлнэ гэсэн мөртөө яг тэр яаж хэрэгжүүлэх талаар тэр нарийн зохицуулалт нь Хууль тогтоомжийн хууль дээрээ болохоороо байхгүй болохлоор энийг хуулиараа нарийвчилж авч үзсэн нь зүйтэй юм болов уу гэдэг нэг тийм.

Эдгээрийг дүгнэлтийг яаж гарсан бэ гэхлээр бид Бүгд Найрамдах Солонгос Улс болон Япон Улсыг харьцуулаад судалчихсан байгаа Монгол улсын нөхцөл байдалтай. Тэгээд Солонгос улсын хувьд болохоороо Хотын боловсролын газрын дарга, дарга нь өөрөө сургуулийн Хоол үйлчилгээний хороо гэдэг зүйлийг байгуулдаг юм байна лээ. Тэгээд үүнээс гадна хариуцлагын механизм буюу хууль тогтоомжийн хяналтын механизм нь болохоороо энэ Япон, Солонгост илүү тодорхой байдаг.

Мөн Япон, Солонгосын хувьд авч үзэхлээр орон нутгийн захиргаа, жишээ нь төр болон орон нутгийн захиргаанд нь энэ сургуулийн Хоол үйлчилгээний хороо гэх мэт байгууллагууд байгуулагдаад энэ орон нутгийн байгууллагууд илүү оролцож байгаа тийм хандлага ажиглагдаж байгаа.

Дараачийнх нь шалгуур үзүүлэлт нь болохлоороо энэ төсөв ба санхүүжилт гэж байгаа юм. Санхүүжилт нь болохоор 2024 оны 12 сарын 30-нд 1 хүүхдэд ноогдох нормативыг ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол 2500 төгрөг, тусгай хэрэгцээт хүүхэд дээр 3400, дотуур байранд дунд, ахлах, бага дээр 6300, 6000 гэх мэтчилэн ингэж энэ нь 9 дэх удаагийн өөрчлөлт байгаа гэсэн үг. 9 удаа ингэж нормативыг батлаад хамгийн сүүлд нь 2500 төгрөг болгож өөрчилсөн байна.

Үдийн хоолны төсөвт болохоороо нийтдээ 141.3 тэрбумыг 26 оны төсөвт суулгасан. Харин дотуур байрны хоолны төсөвт 60.2 тэрбумыг суулгасан. Худалдан авах ажиллагааны хувьд болохлоороо нийтдээ 60.5 буюу 425 сургууль нь нээлттэй тендер шалгаруулалтаар 39.5 буюу 227 сургууль нь болохлоороо хувь хүн, бусад этгээдээс энэхүү бараа, бүтээгдэхүүнийг худалдаж авдаг гэсэн.

Санхүүжилтийн асуудал дээр гол үүсээд байгаа асуудал нь нөгөө миний түрүүний ярьдаг тэр жил болгон нормативыг батал гэсэн. Тэгэхдээ энэ жил болгон батлагдах нь одоо энэ 24 оны өмнөх нь болохлоороо 21 оны тийм журам байгаа. Тэгэхлээр энэ жил болгон энэ нормативыг батлах тэр хуулийн хэрэгжилт нь өөрөө хэрэгжихгүй байна гээд.

Түүнээс гадна төсөв дээр энэ гадаадын олон улсын байгууллагын тийм тусламж, дэмжлэгтэй донор байгууллагуудын энэ төслүүд их хэрэгжиж байгаа. Жишээ нь Боловсролын дэлхийн түншлэл олон улсын байгууллагаас 5 сая ам.долларын санхүүжилттэй төсөл, түүнчлэн “KOICA”-гаас болохлоороо 8 сая долларын төсөл, “ЖАЙКА”-аас гэх мэтчилэн ийм төслүүд хэрэгжиж байгаа.

Тэгээд үүн дээр болохоор Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэлийн тухай хууль дээр нэг гол асуудал нь юу вэ гэхлээр санхүүжилтийн зохицуулалт буюу тусдаа зүйл, заалт ерөөсөө байхгүй юм байна лээ. Тэгээд тэр зүйл, заалт буюу тэр санхүүжилтийн эх үүсвэр ч юм уу тэрийг ингэж батлах нь зүйтэй юм болов уу гэсэн тийм судалгааны дүгнэлт гарсан байгаад байгаа.

Дараагийн шалгуур үзүүлэлт нь болохоор энэ хяналтын тогтолцоо буюу хуульд тогтоосон хяналтын тогтолцоо. Хяналтын тогтолцоог манай судалгааны багаас үүнд дүгнэж үзээд ер нь хяналтын журмыг 2024 он, 21 онд дотоод хяналтын болон хөндлөнгийн хяналтын журмуудыг бүгдийг нь биш хөндлөнгийн хяналтын журмыг баталсан. Мөн Хяналтын зөвлөлийн бас журмыг баталсан байгаад байгаа.

Тэгэхлээр энэ хуулийн хэрэгжилт ерөнхийдөө хэрэгжиж байна гэдэг үүднээс. Гэхдээ энэ хяналтын байгууллагуудын чиг үүргийн давхардал байна гэж. Жишээ нь Хяналтын зөвлөл болон Боловсролын яам, Боловсролын газраас тухайн хоол үйлдвэрлэлийн хэрэгжилтэд хяналт тавина гэсэн мөртөө тэр нь болохлоороо хяналтын журмаараа илүү задаргаатай байдаг. Энэ нь болохоороо байнгын, тогтмол давтагдах процессын шинжтэй зохицуулалт учраас энэ хяналтын зохицуулалт нь ер нь хуульдаа нарийвчлагдаж ингэж орсон нь зүйтэй юм болов уу гэдэг бид нарын судалгааны багийн гол дүгнэлт ерөнхийдөө байгаад байгаа.

Хяналтын журмаар болохлоороо дараах байгууллагууд дараах чиг үүргийн хэрэгжүүлж оролцоно гээд. Түүнээс гадна ерөнхий боловсролын сургуулийн сургуулийн дотоод хяналт буюу сургууль өөртөө тавих хяналт дээр 2025 онд Боловсролын яамнаас төсөл явж байгаа. Тэр нь батлагдаагүй байгаа. Тэр нь батлагдчих юм бол тэр сургууль өөрөө дотооддоо хяналт тавих тэр нөхцөл, бололцоо, эрх зүйн зохицуулалт нь бий болох юм болов уу гэдэг тийм хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ гарсан.

4 дэх нь болохоороо энэ шим тэжээл, илчлэгийн байдал дээр дүгнэлт хийсэн байгаа. Энэ Ерөнхий боловсролын хоол, үйлдвэрлэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл дээр болохоороо сурагчийг эрүүл, аюулгүй шим тэжээллэг хоол, хүнсээр хангана гэж байгаа юм. Үүний хүрээнд болохлоороо 2020 оны 3 сайдын хамтарсан тушаалаар 1 хүүхдэд ноогдох, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдэд ноогдох илчлэгийн үдийн хоолноос авах илчлэгийн хэмжээ нь 35 хувь буюу гэж авч үзсэн байдаг.

Тэгээд энийг нь болохлоороо 2024 оноос Сангийн яамнаас хийсэн судалгаагаар ерөнхийд нь авч үзэхлээр 603 килокалори байдаг. Түүнээс гадна ерөнхийдөө 603-610-ын хооронд килокалори байна гээд. Тэгэнгүүт тухайн үеийн

тэр сүүлийн 24 оны тэр судалгаагаар авч үзсэн дундаж килокалори авч байгаа нь болохоор 461 килокалори авч байгаа буюу энэ нь байх ёстой түвшнээсээ 147 килокалори буюу 27 хувиар тэр килокалорийг илүү бага авч байна гээд.

Тэгээд бид бүхэн яг фокус ярилцлагын судалгаа хийгээд ингээд бас сургууль болон мэргэжилтнүүд нь уулзаад үзэхлээр бүр тэрнээс бага буюу 340 хавьцаа килокалоритой ийм хоол хүнс яг одоо бодит байдал дээр үдийн хоол нь өгч байна гэдэг тийм ерөнхийдөө судалгаа гараад. Тэгээд энэ хоол тэжээлийн килокалорийг ерөнхийдөө яг тэр хууль болон журамд заасанд хүргэх нь зүйтэй гээд.

Түүнээс гадна энэ жишиг цэсийг бас энэ гарын авлага болгоод 66 хоолны цэс дээр гарсан байгаа. Энэний дундаж килокалори нь 665.6 килокалори байдаг гээд. Тэгэхээр энэ нь болохоороо 38 хувийг эзлээд тэгээд ерөнхийдөө энэ хуулийн зохицуулалтад юу нэмбэл энэ килокалорийг илүү баримтлах боломжтой вэ гэж би судалгааны багаас зүгээс үзэж байгаа. Хоолны цэс гэдэг зохицуулалтыг тусад нь гаргаж ирээд тэрийгээ ингэж байнгын, тогтмол хангуулснаар энэ килокалорийг ингэж илүү хангах, тэгээд тухайн хүүхдийг эрүүл, шим тэжээллэг хоолоор хангах тэр хуулийн маань зорилго өөрөө биелж байгаа юм болов уу гээд.

Үүнийг болохоор болохоор бас мөн Япон, Солонгос болон Финлянд улсын хуулийн зохицуулалттай харьцуулж үзсэн. Японы хувьд болохоор 530-780 килокалори, Солонгост болохлоороо 507-670, Финландад болохоороо 550-770 килокалори ерөнхийдөө илчлэгийн хэмжээтэй тийм үдийн хоолонд өгдөг гэж байгаа.

Монголын хэмжээнд болохоор түрүүний 603 килокалори гэдэг нь ерөнхийдөө энэ түвшинтэй ойролцоо хэдий ч яг бодит байдал, практик дээр болохлоороо энэ нь яг хэрэгжилт нь тэрнээсээ бага байгаад байгаа гэдэг тийм үзүүлэлт гараад байгаа.

Дараагийн, сүүлийн ярих асуудал нь болохлоороо энэ хүртээмж ба тэгш байдал гэж байгаа. Ерөнхий боловсролын сургуулийн энэ 21 оноос 25 оны нөхцөл байдлын шинжилгээг хийхэд болохлоор жишээ нь шаардлага хангасан хоолны газар нь 357-479 болсон буюу сайжирсан. Тэгээд хоол зүйчийн тоо нь 5 байсан нь 319 болсон. Үдийн хоолоор үйлчилдэг сургууль нь 93.9-99 болтлоо дээшилсэн. Бага ангийн үдийн хоолны норматив 1500-2000, дотуур байрных 4000-6000 гэх мэтчилэн ийм хүртээмжийн хувьд иймэрхүү эерэг үзүүлэлтүүд их ажиглагдсан байгаа боловч бас түүний хажуугаар практик хэрэгжилтийн байдал дээр сөрөг нөхцөл байдлууд бас илэрч байгаа.

Жишээ нь шаардлага хангаагүй хоолны газар 34.1 хувь, ус цэвэршүүлэгчтэй, төхөөрөмжтэй сургууль 83.6 хувьтай. Үүнээс гадна 81 хүүхдэд 1 ус цэвэршүүлэгч ноогдож байна гэсэн тийм судалгааг бас хийсэн байдаг. Түүнээс гадна илэрсэн зөрчил 1787 гэх мэтчилэн иймэрхүү асуудлууд үүссэн байгаа.

Хүртээмжийн асуудал дээр мөн дунд, ахлах сургуулийн үдийн хоол буюу асуудлыг шийдвэрлэх энэ дээр болохлоороо дунд, ахлах сургуулийн сурагчдаас санал асуулга авахад 83 хувь нь үнэ төлбөргүй хоол ер нь үдийн хоол идэх хүсэлтэй байгаа гэдгээ илэрхийлсэн. Түүнээс гадна тухайн хүүхдийн яг өдрийн хоолны тэр зохицуулалт нь хэрхэн зохицуулж байгаа вэ гэхлээр 32.2 нь

худалдааны хоол авч иддэг. Тэгээд 22.5 нь болохоор гэрээсээ хоол авчирдаг гэх мэтчилэн.

Тэр худалдааны хоол нь болохоороо түрүүн хэлсэнчлэн 150 метрт хоол хүнс зарж байгаа, хориотой хоол, хүнс зарж байгаа нь болохоороо 83.7 хувь дээр нь болохоороо тийм төрлийн зөрчил 19 сургууль дээр хийхэд илэрсэн байгаад байгаа юм гэх мэтчилэн.

Түүнээс гадна сургуулийн хоолны газруудаас, 372 сургуулийн хоолны газраас ер нь судалгаа авахад 187 нь иж бүрэн тоног төхөөрөмж хэрэгтэй, 185 нь нэмэлт тоног төхөөрөмж хэрэгтэй гэх мэтчилэн энэ сургуулийн хоолны тоног төхөөрөмж болон сургуулийн хүүхдүүдийн үдийн хоолны тэр тэгш хүртээмж нь дээрх байдлаар хангагдах нь зүйтэй гэдэг байдлаар ерөнхийдөө судалгаа.

Дүгнэлтийн тухайд болохлоороо яг дээртэй ижилхэн зохион байгуулалт, үүрэг дээр болохлоороо хуульд хяналт тавих үүргийн давхардалтай холбоотой асуудлыг шийдвэрлэх. Түүнээс гадна хоол зүйч, тогоочийн орон тооны, давтан сургалт гэх мэтчилэн зүйлийг зохицуулах.

Төсөв, санхүүжилтийн хувьд болохлоороо нормативыг дахин батлах. Түүнээс гадна хуулийн зохицуулалт, санхүүжилтийн талаар тусгах.

Хяналт дээр болохлоороо хяналтыг хуульд илүү нарийвчилж тусгаж өгөх зохицуулалт хэрэгтэй.

Чанар, шим тэжээл дээр болохлоороо шим тэжээлийг яг байх ёстой стандартад нь хэрэгжүүлэх нь зүйтэй.

Хүртээмж, тэгш байдал дээр болохлоороо одоо байгаа хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа илүү эрчимжүүлж, тэр хүүхдүүдийн болон дунд, ахлах сургуулийн хүүхдүүдийн үдийн хоолыг шийдвэрлэх асуудал гэх мэтчилэн иймэрхүү судалгааны дүгнэлт, зөвлөмж гарсан байгаа.

Цаг бага байгаагийн үүднээс товчхондоо ер нь 5 гол асуудлын хүрээнд иймэрхүү асуудал, дүгнэлт, зөвлөмжийг өгөөд явсан байгаа. Баярлалаа.

О.Номинчимэг: Баярлалаа. Хуульчдын холбооны судлаач Энххүслэн хуулийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийснээ танилцууллаа.

Энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан бас өмнө нь хийгдэж байсан судалгаа байгаа. Манай Өргөдлийн байнгын хорооны гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Даваасамбуугийн Ганмаа гишүүн бас эндээс судалгаа хийгдэж, энэний дагуу бас бодлогын арга хэмжээнүүдийг зөвлөмж гаргаж байсан. Тэгээд энэ асуудлыг бас таныг танилцуулна уу хэмээн урьж байна. Юугаа өгчихсөн байгаа юу power point-оо. Болно 10 минутад багтаагаад Ганмаа гишүүний судалгааг танилцуулъя. Ганмаа гишүүний микрофоныг.

Д.Ганмаа: Сайн байцгаана уу? Энэ 10 минутад багтаах юм бол эхний хэдэн хэсгүүдийг өшөө больчихъё слайдуудыг. Эхний 3 байна уу 4 слайдыг өнгөрөөгөөд үз дээ хаана. Дараачийнх нь 4 дэх байна уу 3 дахь слайдаас шууд эхэлчихье. Энэ эхний 3, 4 слайд бол ер нь энэ хүүхдийн эрүүл мэнд өсөж бойжихтой холбоотой

хаана ямар хууль байдаг вэ зүйл, заалт. Тэгээд олон улсын конвенц дээр бас юу гэж туссан талаар ихэвчлэн дурссан юмнууд байгаа. Баярлалаа.

Ер нь энийг саяхан бас Дэлхийн эрүүл мэндийн байгууллагынхан хүрч ирж бид нарт нөгөө танилцуулга хийсэн эрүүл хооллолт дээр. Монголд энэ бол миний судалгаа биш энэ олон улсын судалгаа. Минийх би анх 2015 онд энийг гаргаж тавьж байсан. Тэд нар эртээд орж ирэхдээ 2013 оныг 2023 онтой харьцуулаад үндсэн юу гэсэн үг вэ гэхээр зэрэг бид нар ингээд хоолны буруу хоол, тэнцвэргүй хоол, болохгүй хооллолтоос болоод бүх өвчлөлүүдийн дарамт гэж байдаг тэрийг хэмждэг арга энэ. Түрүүгээрээ Монгол улс бол ерөөсөө 1-д байгаад байна. Хоол унд чинь болохгүй байна гэдгийг л үзүүлж байгаа ийм олон улсын судалгааны үр дүн.

Энэ яагаад гэдэг нь бас Монгол улсад хамгийн их өвчлөлд хүртээж байгаа асуудал нь бас л хоол тэжээлийн буруу байдал гээд яг тэр байгууллагууд нь бас хийсэн судалгаа.

Яагаад гэдэг тусдаа асуудал. Би 10 минутдаа багтахын тулд ерөнхийдөө нэлээн товчлох юм байна. Энэ хоол хүнсний шим тэжээл дээр бид нар ер нь яагаад баяжуулсан хоол хүнсийг төрийн худалдан авалтдаа оруулах шаардлагатай вэ гэдэг дээр би хэд хэдэн хийсэн судалгаануудаа танилцуулъя гэж бодсон юм. Энэ бүүр анх “Үдийн цай” хөтөлбөрийг хийж, “Үдийн цай” гэж хөтөлбөр эхлэх гэж байхад бид нар энэ судалгааг хийж байсан.

Тэгэхдээ үр дүнг нь хэвлүүлэх нь бол 2005 онд хэвлүүлж байсан. Энэ захын нэг сургуулиудад хийгдсэн судалгаагаар ерөөсөө хүүхдэд витамин Д буюу цусан дахь витамин Д-г хэмжиж байгаа. Ер нь витамин Д чинь хоол хүнснээс авч байгаа витамин Д-ийн нэг хэмжээ. Тэгээд цусанд хэмжиж байгаа витамин Д гэж байгаа. Энэ бол яг цусан дахь нь.

Юу гэсэн үг вэ гэхээр судалгаа эхлэхээс өмнө Монгол хүүхдүүдийн дундаж витамин Д-гийн дундаж маш бага. Ихэнх нь буюу бараг 80 хувь нь 20 нанограмм миллилитр буюу хэвийн байх ёстой хэмжээндээ хүрэхгүй байна. Хэвийн хамгийн бага хэмжээ байхгүй юу 20 нанограмм миллилитр гэдэг нь. Тэгээд энийг ерөөсөө 28-хан хоног дээр баяжуулсан сүүг уухад энэ хэвийн хэмжээ дөнгөж 7 хувь руугаа буурчихсан ийм асуудал гарсан юм. Тэгэхлээр энэ маш хурдтайгаар энэ асуудлыг шийдэх боломжтой гэдгийг л үзүүлэх гээд байгаа санаа.

Тэр мэдээж Д-тэй сүү өгсөн юм чинь цусан дахь Д ихэснэ гэдэг бол бараг ойлгомжтой. Тэгэхдээ vitami-D иссэнээрээ яг яасан юм бэ гэхээр хүүхдийн өсөлт, хөгжлийг бид нар үзсэн. Бид нар мэдэж байгаа. Саяхан гарсан судалгааны үр дүнгээр бас л хүүхдийн өсөлтийн хоцрогдол байгаа гээд байгаа. Америк, Монгол хүүхдүүдийн 10 настай охидыг 10 настай хөвгүүдтэй харьцуулсан судалгаа Энэ Си Ди Си-гийн ийм өсөлтийн график байдаг.

Ингээд харах юм бол Монгол “М” үсэгтэй нь Монгол, “Х” гэдэг нь Америк хүүхдүүдийн дундаж 10 настай хүүхдийг харахаар бид нар 1 жилийн өсөлтийн дутагдалтай байгаад байгаа байхгүй юу гээд хөвгүүд мөн адилхан. Яг адилхан. Энэ цэнхэр нь хөвгүүдийнх. Бас л 1 жилийн өсөлтийн хоцрогдолтой өндрийн хувьд.

Тэгэнгүүт яасан бэ гэхээр бид нар түрүүн ярьсан хорин 28-хан хоног витамин Д-гээр баяжуулсан сүүг энэ хүүхдүүдэд өгөхөд харьцуулаад үзэхээр зэрэг хүүхдийн өндөр эрэгтэй хүүхдүүдийнх 1см-ээр, эмэгтэй хүүхдүүдийнх 1.1см-ээр нэмэгдээд тэгэхдээ жин нэмэгдээгүй гэсэн үг.

Яагаад гэхээр тэр “Би Жи Ай” гэж байгаа биз. Body Mass Index энийг хэмжиж үзэхэд харин ч жоохон жингээ бууруулсан гэсэн асуудал. Одоо чинь нөгөө таргалалтын асуудал гараад байгаа учраас. Энэ судалгаа хэвлэгдсэний дараа бид хэд ээж нарыг нь судалж үзсэн юм. Ээж нарыг судлаад яг энэ судалгаанд хамрагдсан хүүхдүүд тэгээд ерөнхийдөө хотын бас л захдуу дүүрэг ихэвчлэн байсан. Эд нарыг үзэхэд ээж нарын түвшин, дундаж түвшин яг адилхан. Монгол хүүхдүүдтэйгээ адилхан дундаж нь түрүүн би хэлсэн 20 нанограмм миллилитр байх ёстой. Харьцангуй ээж нарынх болохоор дөнгөж 8 нанограмм миллилитр байгаа байхгүй юу. Америкт бол шууд эмчилгээнд ордог түвшин. Тэгээд бас 99 хувь нь 20 нанограммаас доош буюу ерөөсөө бараг толгой дараалан Д амин дэмийн дутагдалтай энэ цусны хэмжээ шүү ахиад. Тэрний, энэний дараа бид нар энэ судалгааг бүүр томруулаад хүүхдүүдэд өндөр, жин, атгалт энэ тэр гээд нэлээн олон үзүүлэлтээр ингээд үзээд тэгээд үзэхэд энэ бид нар хэд хэдэн юмыг харьцуулж үзсэн юм.

1 дүгээрт Д-г supplement буюу дангаар нь өгсөн. Дангаар нь өдөр болгон 300 олон улсын нэгжээр. Тэгээд өдөр болгон хүүхдэд 300 олон улсын нэгжээр өгөөд байх нь хүний нөөцийн хувьд асуудалтай учраас хүйтэн улирал эхлэхээс өмнө буюу өвлийн 1 удаа өгч байгаа байхгүй юу тунг нь нэгтгээд. Өндөр тунтай гэсэн үг.

Нөгөө талд витамин Д-гээр баяжуулсан сүү, тэгээд 4 дэх нь Д-гээр баяжуулаагүй сүү өгсөн. Яагаад ингээд заавал хооронд нь ингээд баяжуулсан, баяжуулаагүйтэй, supplement-ийг supplement биш идэвхгүй бодисоор харьцуулж үздэг вэ гэхээр бүх бусад нөхцөл байдлыг нь ижил байлгаж байж тэгдэг байхгүй юу. Тэгж байж энэ чинь яг судалгааны үр дүн үнэн, зөв бодитой гардаг.

Ингээд харахаар зэрэг яг л адилхан. Баяжуулсан сүү уухаас өмнө юм уу, Д уухаас өмнө нөгөө л дундаж нь 8 нанограмм 99 хувь нь витамин Д-гийн дутагдалтай.

Гэтэл баяжуулсан сүүг уугаад эхлэхээр зэрэг энэ нөгөө дундаж нь хар аа 23 нанограмм миллилитр болоод нэмэгдчихэж байгаа байхгүй юу. Шууд хэвийн хэмжээ рүүгээ орчхож байгаа байхгүй юу. Тэгэхдээ 41 хувь нь бас л 20 нанограмм литртэй хүрэхгүй байна гэсэн үг. Тэгэхлээр энэ бид нар хэрвээ үнэхээр 100 хувь толгой дараалан Д-гийг хангалттай хэмжээнд ядаж 20 нанограммд хүргэе гэвэл хугацааг нь уртасгах юм уу supplement-ийнхээ нэгжээ нэмэх хэрэгтэй байгаа юм.

Тэгээд бас нэг их гоё судалгааны энэ үр дүн нь юу байсан бэ гэхээр Д-г баяжуулсан сүүтэй баяжуулаагүй сүүг харьцуулсан гэж би хэлсэн тээ? Ингээд харьцуулаад үзэхэд амьсгалын замын хурц халдвар 50 хувь буурч байгаа байхгүй юу. Нөгөө томуу, томуу төст халдвар, хатгаа. Юу гэсэн үг вэ гэхээр бид нар ор дүүргээд байдаг асуудлыг Д-гээр баяжуулсан сүү өгснөөрөө 50 хувь шийдэх боломжтой харагдаж байгаа юм. Яг Монгол хүүхдүүд дээр яг бусад кондицыг нь яг адилхнаар барьсан ийм судалгаа байхгүй юу. Clinical Trials 3, 2 гээд яг л golden стандарт гэж ярьдаг бусад судалгаатай харьцуулахад энэ хамгийн “the best” гэсэн үг design. Их үнэтэй байдаг учраас хүмүүс хийдэггүй.

Энэ тэгээд ганцхан Монголд тохиолддог асуудал биш юм байна лээ. Бусад баахан улс орны хүмүүс хар Америк, Англи, Афганистан, Шинэ Зеландын улс орнуудад яг хийгдсэн Д амин дэмийг амьсгалын замын цочмог халдвараас урьдчилан сэргийлэхэд хийсэн судалгааг нэгтгээд манай нөгөө судалгаа хийдэг Анагаахынхан бас мэдэж байгаа байх ийм нэгтгэсэн ийм судалгаанууд хийх ийм дизайн. Тэрүүгээр хийгээд үзэхээр яг адилхан. Ерөөсөө юу Монгол хүүхдүүдтэй адилхан Д-гийн дутагдалтай хүүхдүүдийг нөхөж өгсөн хувь тохиолдолд бид нар амьсгалын замын цочмог халдвараас хүүхдүүдээ хамгаалах, урьдчилан сэргийлэх боломжтой байна гээд статистикийн хувьд өндөр магадлалтай гарч байгаа байхгүй юу.

Энэ товчлоод ярьчихъя. Түрүүн би амьсгалын замын хурц халдварт ярилаа, өндөр жинг ярилаа биеийн. Ингээд ярихад бид нар тэгээд өөр олон судалгаанууд байсан юм. Сүрьеэгийн далд халдвар, идэвхтэй сүрьеэ, арьсны асуудал, харшил, аутоиммун өвчин. Тэрний жишээлбэл атопик дерматит гэдгийн нэг асуудал энэ дээр 1-18 насны хүүхдүүдийг яг өвлийн улирлаар энэ атопик дерматит буюу хүүхдүүддээ витамин Д өгөхөд өвлийн улиралд экзесорбэйшн буюу хүндрэл нь багасаад хичээл ном таслахаа больж байгаа. Антибиотик хэрэглэхэд нь бууруулж байгаа юм.

Ер нь ингээд дандаа энэ асуудлууд дандаа эергээр гарсан гэсэн үг. Бид нар тэгээд энэ дандаа Улаанбаатарт л хийгээд байдаг, хөдөө орон нутаг яадаг юм, малчид эрүүл саруул агаарт сайхан амьдардаг улсууд байхад энээ тэрээ гээд тийм бас асуудлууд их гарч байсан учраас ер нь 8 аймаг, тэгээд Улаанбаатар хотод ийм том хэмжээний судалгаа яг өвөл, зун, эрэгтэй, эмэгтэйгээр нь харьцуулж судалсан.

Товчхондоо хэлэхэд бас л хар аа эрэгтэй, эмэгтэйгүй, хот, хөдөөгүй ямар ажил хийж байгаагаасаа үл хамаараад vitamin-D-ийн дутагдал байгаа гэсэн үг. Энэ ягаан дотор байна шүү дээ. Vitamin-D-ийн дутагдал гэхихсэн. Улаан өнгөтэй. Дандаа Д-ийн дутагдалтай тэр ногоон бол бүүр оптимальный үе. Шар гэдэг нь нөгөө дундаж 20-оос дээш гэдэг үе нь. Ихэнх нь тэр ягаан дээрээ байгаад байгаа биз. Тэгээд аль аймагт, хэзээ эрэгтэй, эмэгтэй гэдгийг нь доор биччихсэн байгаа.

Ингээд үзэхээр бид нар өвлийн улиралд яах аргагүй Д амин дэмийн дутагдал 99 хувь, зуны улиралд 38 дутагдалтай байна аа. Ямар ажил хийж байгаа, хаана амьдарч байгаагаасаа үл хамаараад энэ байна гэдэг ийм дүгнэлт гаргаад тэгээд яагаад Витамин Д нарлаг Монгол улс гэж нэрлээд байгаа болохоор бас дутагдалтай байгаад байгаа юм бэ гэдгийг бас судалж үзэж байсан байхгүй юу. Тэгээд энийг яасан гэхээр зэрэг бид нар Улаанбаатар, Хөвсгөл, говьд витамин Д арьсандаа нийлэгжихийн тулд витамин Д-гийн Previtamin-ийн гэдэг бодисыг ампулд хийгээд өдөрт 1 удаа 1 цагаар харанхуй гадаргуу дээр ингэж байрлуулаад бүтэн жил Монголд судалсан юм.

Ингээд үзэхээр энэ 3 нанограмм уучлаарай нанограмм биш. 3-аас дээш гарч байж арьсанд бид нарын витамин Д наранд нийлэгжих боломжтой. 3-аас доош бол нийлэгжих боломжгүй. Ингээд Монголын нөхцөлд бол 4 сараас эхлээд бид нар наранд биеэ шараад байвал уул нь витамин Д нийлэгжих боломжтой юм байна лээ. Тэгэхдээ 4, 5, 6 сар стиль хүйтэн. Одоо бид нар бараг 6 сар болж байна гадаа биеэ усны хувцастай наранд яваад байх боломжгүй тийм үү хүйтэнд.

Тэгэхээр бид нарт ерөөсөө л 7 сар бараг үлддэг. Ингээд энэ бол 2 7 хоног энэ айлын хоол, хүнс хэрэглээний хоол хүнс. Эндээс харахаар бид нар хүнснээсээ Д авах боломж байна уу, үгүй юу гэдгийг харахад.../минут дуусав./

О.Номинчимэг: Баярлалаа Ганмаа гишүүндээ бас өөрийн хийсэн судалгаа, баяжуулсан хоол, хүнсний ач холбогдол. Бид ч гэсэн шим тэжээлийн дутагдал ерөнхий боловсролын сургууль дээр ярьж байгаа үед бас ийм судалгааныхаа үр дүнг танилцаж, бодлогын чиглэлийн зөвлөмжүүдийг гаргасан байна.

Өнөөдөр энэ Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан эхний асуудал байна. Тэгэхээр энэтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Өнөөдөр яригдсан.

3 гишүүнээр тасаллаа. Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асууя.

Х.Баасанжаргал: Би маш товчхон асуучихна. Энэ хуулийн хэрэгжилт дээр, Боловсролын яамны танилцуулсан хуулийн хэрэгжилт дээр яамнуудын хэрэгжилт аягүй өндөр гарсан байгаа байхгүй юу. 60-аас 70 хувь гээд. Гэсэн хэр нь бодит яг энэ хэрэгжилт өөрөө үнэхээр хангалтгүй байгааг нь мэдэж байгаа. Гэтэл яг ингээд яаман дээр болохоор яагаад ийм өндөр, төрийн байгууллагууд дээр яагаад ийм өндөр гараад байгаа юм бэ гэдэг нэг асуулт байна.

2 дугаарт орон нутгийн 2 дахь Хуульчдын холбооноос гэсэн үг. Энэ хуулийн хэрэгжилтийг судалж байх явцад тухайн орон нутгийн хоол хүнсний ханган нийлүүлэлтийн сүлжээнд орон нутгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих бодлого байсан уу, түүнтэй холбоотой зохицуулалт, заалт хэрэгжилттэй холбоотой ер нь зохицуулалт байсан уу, тэрний хэрэгжилт ер нь ямар байсан юм бэ гэдэг ийм 2 дахь асуулт асууя.

Гуравт нь тэр Хяналтын зөвлөлийн тухай Боловсролын яамнаас асуучихъя даа. Энэ Хуульчдын холбооны тайлан дээр гарсан Хяналтын зөвлөлийн тухай гарсан. Хяналтын зөвлөл гэж байдаг юм байна гэж гарсан. Хууль дээрээ ч гэсэн байгаад байгаа юм. Ер нь энэ Хяналтын зөвлөл яаж тайлагнадаг юм? Хяналтын зөвлөлийн тайланг та нар ямар түвшинд авч үздэг юм, тайлан ирлээ гэхэд түүнийгээ эргэж ингэж нөгөө хуулийнхаа хэрэгжилттэй яаж уядаг юм бэ гэсэн ийм 3 асуулт.

1 номер Түмээ дарга уу Түмэнжаргал дарга уу? 1 номерын микрофон хариулъя.

Т.Түмэнжаргал: Боловсролын яамны Хоол үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Түмэнжаргал. Гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр яг зөв. Түрүүн миний мэдээллээ хийж байхдаа хэлсэн нөгөө хууль дагаж гарах бүх дүрэм, журмууд батлагдсан гээд. Тэгэхээр энэ дээр нөгөө яамнуудын хэрэгжилт жишээлбэл Хөдөө аж ахуйн яаман дээр 66 хувь, Эрүүл мэндийн яаман дээр 70 хувь гээд гарчихсан байгаа биз. Тэгэхээр энэ 2 шалтгаантай.

Яагаад гэвэл 1 дүгээрт энэ 2 яаман дээр бол манай сургуулийн хоолны хууль дээр бол заалт маш бага байгаа. Заалт маш бага байгаа.

2 дугаарт нөгөө батлагдах ёстой дүрэм, журам маань батлагдчихсан. Өөрөөр хэлбэл Хүнс, хөдөө аж ахуйн яаман дээр сургуулийн хоол үйлдвэр үйлчилгээнд хэрэглэгдэх хүнсний бүтээгдэхүүний жагсаалтыг батална гээд заачихсан байгаа байхгүй юу. Баталчихсан. Тэгээд баталчихсан учраас нөгөө яг судалгаа, үнэлгээ хийж байгаа хүмүүс маань бэлэн материал дээр ингээд ажиллаж байгаа учраас харьцангуй хууль, эрх зүйн орчин нь батлагдсан учраас хувь нь жоохон өндөр гарсан.

Нөгөө талдаа бол яг тэр жагсаалт нь батлагдсан боловч яг тэрнийхээ дагуу хүнс ханган нийлүүлж байна уу гэвэл үгүй. Тэгэхээр энэ дээр бол үнэлгээ хийж байгаа баг маань бол бас яг бичиг баримтын хувьд, тайлангийн түвшинд үнэлсэн учраас би түрүүн тэр мэдээлэлдээ их өндөр байгаа. Энэ нь тэгэхдээ хэрэгжилт дээр бол бас өөр байгаа шүү гэдгийг бас ингэж хэлээд байгаа юм. Тийм учраас батлагдсан эрх зүйн баримт бичгийн түвшинд л тийм өндөр гарч байгаа.

Түүнээс хэрэгжилтийн хувьд бол бага байгаа. 2 дугаар асуултын хувьд бол тэр Хяналтын зөвлөл гээд энэ бол хууль дээр бол Хяналтын зөвлөл байна гээд. Эцэг эх, сурагч, тэгээд багшийн төлөөлөл орсон хяналтын зөвлөл ажиллана гэсэн ийм журамтай. Энэ журам батлагдчихсан. Энэ журмынхаа дагуу бол сургууль дээр бол энэ хөндлөнгийн хяналтаа бол хийгээд явж байгаа.

Дээр нь сая бас нэмээд хэлэхэд сургуулийн дотоод хяналт хийх боломжгүй юм байна гээд бас сая энэ тайлан дээр гарчих шиг боллоо. Энэ бол үгүй. Сургуулийн дотоод хяналтын журам байгаа. Энэ журмынхаа дагуу сургууль өөрөө хяналтаа хийгээд явж байгаа.

Мэдээж хэрэгжилт дээр алдаатай, оноотой бас дутуу хяналтаа тавьдаг ийм юмнууд бол байгаа.

О.Номинчимэг: 2 номер Хуульчдын холбоо.

О.Энххүслэн: Баасанжаргал гишүүний асуултад хариулъя. Манай судалгааны хэмжээнд бол ерөнхийдөө авч үзэхдээ ер нь аймаг, Нийслэлийн Засаг дарга нар руу энэ хуулийн дагуу нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хоол үйлдвэрлэл, үйлчилгээг жигд, тогтвортой зохион байгуулах арга хэмжээг авах, сургуулийн хоол үйлдвэрлэх үйлчилгээг мэргэжлийн бүтэц, орон тоогоор хангахад дэмжлэг үзүүлэх, сургуулийн дэргэдэх туслах аж ахуйг хөгжүүлэх, орон нутгаас нийлүүлэх түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг тогтвортой явуулах арга хэмжээ ав гээд. Энэ хүрээнд болохлоор энэ хяналт тавих журмын дагуу энэ Хүүхдийн хоолны зөвлөл гэдэг байгууллага ерөнхийдөө байгуулагдаад ажиллаж байгаа юм байна лээ. Гэхдээ энэ хүүхдийн хоолны зөвлөл гэдэг нь яг судалгааны тэр дүгнэлтээр гарахдаа хууль дээр ерөөсөө огт тусгагдаагүй байгууллага. Тэгсэн хэр нь үйл ажиллагаа явуулж байгаа. Тэгэхээр энэ хууль тогтоомждоо яг энэ хуульдаа энэ зөвлөлийн үйл ажиллагааг илүү нарийвчилж зохицуулах нь зүйтэй юм болов уу гээд.

Яг тэр хэрэгжилтийн тухайд болохлоороо холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцлага хийгээд үзэхэд тухайн аймгийн Засаг дарга нар ингээд янз бүр байдаг гэсэн. Өвөрхангай болон Орхон.../минут дуусав./

О.Номинчимэг: Товч, тодорхой гүйцээж хариулъя. 1 минут 2 номерын микрофон дээр.

О.Энххүслэн: Яг тэр тухайн тэр орон нутгийн Засаг дарга нараасаа ер нь их хамааралтай байдаг гэсэн ерөнхийдөө ...-ийн ярилцлага хийхэд тийм дүгнэлтийг өгсөн. Тийм байна.

О.Номинчимэг: Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Товчхон асууна. Тэгэхээр энэ сургуулийн хүүхдийн хоолны үйлдвэр үйлчилгээний амин чухал 2 асуудал байна уу л гэж хараад байгаа юм.

1 дүгээрт бол баталгаатай хүнсний бүтээгдэхүүнээр хангах тухай асуудал.

2 дахь нь бол энэ сургуулийн гал тогоо гэж нэг юм байгаа юм. Тэгэхээр энэ сургуулийн хоолны асуудал чинь бол үндсэндээ 2008 оноос л яригдаад байдаг. Үдийн цайг үдийн хоол болгоё. Ингээд бага ангийн хүүхдийн дунд анги болгож үдийн хоол өгье гэх мэтчилэнгээр яригдаад л ямар нэгэн саяын мэдээллээс харахад бол бас жил жилээрээ тодорхой ахиц дэвшил бол гарах нь гардаг л юм байна.

Тэгэхдээ зэрэг энэ юутай холбогдуулаад сургуулийн гал тогоо, сургуулийн хүүхдээ хоол хийдэг газартай холбогдуулж би энэ асуултыг тавьж байгаа юм. Одоо манай улсад инженерийн дэд бүтэцгүй сум хэд байдаг юм? Тэр сумд нь хэчнээн сургууль байдаг юм, тэр сургуулиуд нь хоолны гал тогооны газраа ер нь яаж зохицуулж авч явдаг юм, тэр худгаас саваар зөөж байгаа ус нь ундны усны хэрэгцээг хангах байдал ер нь ямархуу байдаг юм бол? Тэгээд энэ инженерийн дэд бүтэцгүй сумдад сургуульд сурч байгаа хүүхдүүд хэчнээн хүүхэд байна? Бага ангид хэд байдаг юм, дунддаа хэд, ахлахдаа хэд байдаг юм? Энэ асуулт, ганц асуулт байна.

О.Номинчимэг: Хэн хариулах вэ? Боловсролын яамнаас хариулах уу? Ням-Очир Төрийн нарийн бичгийн дарга. 1 номерын микрофон.

Т.Ням-Очир: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Тэгээд бид сая бүх сумдаа ариун цэврийн байгууламжаар холбоход яг нэгдсэн инженерийн дэд бүтцэд холбогдоогүй нэгдсэн ийм, дотоод бүтэцгүй 120 гаруй сум байгаа ийм тооцоо, судалгаа гаргаж байсан.

Тэгэхдээ сургууль болгон өөрийн гал тогоо, өөрийн халаалтын систем, өөрийн цэвэр усны хангамжтай. Тэгэхээр энэ хүрээндээ бол бид нар улсын зүгээс бол шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг сүүлийн 19 онд Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль батлагдаад, 21 оноос үдийн хоол хөтөлбөрт шилжсэнтэй холбогдуулаад бол үе шаттай ингээд хангаад явж байгаа.

Тэгээд 2019 онд Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хууль батлагдахад ер нь бол 158 сургууль түрээсийн гал тогоотой байсан. Энэ бол ихэвчлэн аймгийн төв, нийслэлийн сургуулиуд байсан.

Сумдын сургуулиуд бол эртнээсээ бол бие даагаад өөрийн туслах аж ахуй, өөрийн гал тогоондоо бол хоол үйлдвэрлэлээ явуулдаг харьцангуй суурь ийм сайтай байсан учраас яг энэ хоол үйлдвэрлэл, үйлчилгээ рүү шилжихэд бол сумдын сургуулиуд харьцангуй боломжтой жигд хүртээмжтэйгээр ингээд явдаг.

Тэр бүү хэл өөрийн туслах аж ахуйгаасаа хоолныхоо илчлэг, шим тэжээлийг бэлтгэх, хүнсний ногоо?, мал аж ахуйгаа бас энэ мах бэлтгэл юмнуудаа хангах ийм бол давуу талууд бол илүү сум талдаа илүү ийм боломжтой байсан гэдгийг хэлье.

Одоо яг ариун цэврийн байгууламжуудыг холбоод эхлэхээр ер нь нэгдсэн ийм системд холбогдохоор бэлтгэл ажил хангаж байгаа маш олон сумнууд бол байгаа юм байна лээ. Ингээд нэгдсэн ариун цэврийн байгууламжтай болоод хоол үйлдвэрлэл яваад эхлэхээр ер нь бол энэ асуудал илүү сайжрах ийм боломж үүсэх юм байна гэж харагдаж байгаа юм.

О.Номинчимэг: Рэгдэл гишүүн тодруулъя.

Д.Рэгдэл: Ер нь бол энэ инженерийн дэд бүтэцгүй сум дээр сургууль, цэцэрлэг, дотуур байрны ариун цэврийн байгууламж ажиллах үндсэндээ боломжгүй гэдгийг та бид 2 зөндөө явж үзсэн тийм ээ. Гэтэл манай засгаас тавьж байгаа бодлогод энэ сумдаа инженерийн дэд бүтэцтэй болгоё гэдэг дээр ерөөсөө 1 ч алхам хийхгүй байгаа юм. Тэгэхээр яамны зүгээс энэ асуудлыг энэ төсөв, төсвөө төлөвлөж байгаа эндээ тусгаж орж ирж, энэ инженерийн дэд бүтэцгүй 120 гаруй сум байгаа юм байна шүү дээ. Эд нарыгаа нэг яаралтайхан шиг дэд бүтэцтэй болгоод авах хэрэгтэй байгаа юм.

Энд ер нь ойролцоогоор бодоход 600, 650 тэрбум төгрөгийн л ажил шүү дээ 110 сумд. Энэ бол ойролцоогоор 250км зам тавих л хэмжээний мөнгийг танай яам сайн хөөцөлдөөд батлуулж чадвал инженерийн дэд бүтэцтэй сумууд бол ингээд 100 хувь болчихно. Би сая таны ярианаас нэг зүйл сайн ойлгосонгүй.../минут дуусав./

О.Номинчимэг: Рэгдэл гишүүн нэмэлт 1 минут.

Д.Рэгдэл: Энэ инженерийн дэд бүтэцгүй суманд сургуулиуд өөрийн бие даасан цэвэр усны хангамжтай гэх юм. Тэр ямар юмаар яаж хангадаг юм бол?

О.Номинчимэг: 1 номерын микрофон.

Т.Ням-Очир: Рэгдэл гишүүний асуултад хариулъя. Энэ бид нар анх. ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар хангах энэ төслийг эхлүүлэхдээ яг тухайн сургууль, сургууль дээр нь, цэцэрлэг дээр нь, дотуур байр дээр нь өөрийнх нь онцлогтойгоор зураг төсвийг нь хийлгэсэн юм.

Тэгэхээр мэдээж цэвэр ус гарахгүй, худаг ухаад цэвэр ус гарахгүй газарт нь зөөврийн усаар асуудлыг нь шийдэж өгдөг ч юм уу иймэрхүү байдлуудаар ингээд яг өөр өөрийнх нь онцлогт тохирсон зураг төсвийг нь хийгээд яг энэ зураг төсөв хийж байх явцад манай сум 2 жилийн дараа нэгдсэн ийм дэд бүтцээр хангагдах юм, тэрийг хүлээж байгаад жишээлбэл та бүхэн энэ төслөө эхлүүлээч ээ гэдэг ийм хүсэлтүүд зарим аймаг юмнууд бас ирж байсан.

Богино хугацаанд энэ дэд бүтцэд холбогдох үгүйг нь бид нар хүлээж байгаад зураг төсвөө хийлгэж байсан. Ийм төсөл, мөнгө шийдэгдээгүй, зураг төсөв хийгдээгүй нь яг өөрийнх нь онцлогтой газар дээр нь шийдэж өгч ингэж ажилласан гэсэн үг.

О.Номинчимэг: Цэвэр усных нь систем нь тэр дэд бүтэцгүй газар цэвэр ус хангамжийн өөрийнх нь системтэй гээд байгаа нь тэр нь ямар учиртай юм бэ гэдгийг сургууль дээрээ, гал тогоондоо гэж. Тэрийг тодруулаад хариулаад өгчих. 1 номер.

Т.Ням-Очир: Би яг зөв ойлгож хариулж байна уу үгүй юу Рэгдэл гишүүн та бас яагаарай. Одоо яг нэгдсэн дэд бүтэцгүй бол сургууль дээр нь яг тэр зураг төсвийг нь хийхдээ гүний худгийг нь гаргаад гүний худгаасаа цэвэр усны хангамжийг нь шийдэж байгаа.

Бүр ингээд гүний худаг ухаад гарах боломжгүй дээр нь бид нар зөөврийн усаар буюу тэр цэвэр усных нь хангамжийг шийдэхээр ингээд зураг төсвийг нь хийгээд, тэгээд цэвэр усны машин, бохирын машиныг нь сум дундын байдлаар ч юм уу, сургууль, цэцэрлэг дундын байдлаар ингээд шийдлээ явж байгаа.

Одоо бид нар ойролцоогоор 62 сургууль, цэцэрлэг дээр нэмэлтээр бохир, цэвэр усны машин шийдэх асуудлыг бас ингээд яг энэ төслийнхөө хүрээнд нэмэлтээр шийдээд явахаар ингээд юу яасан гэсэн үг.

О.Номинчимэг: Баярлалаа. Отгоны Саранчулуун гишүүн асуулт асууя.

О.Саранчулуун: Сайн байцгаана уу? Би тайлан дээр л харж байгаа юм. 2020 онд Боловсрол, шинжлэх ухааны яам, НҮБ-ын Хүүхдийн сан хамтран ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоолны жор, технологи гэж гарын авлага гаргаад тэр үеэр бас судалгаанууд хийж байсан юм байна.

Тэрний өмнө болохоор дотуур байрны тухайд Эрүүл мэндийн яамнаас хоол тэжээлийн норматив гаргасан байна. Нэлээн хэдэн ийм юунууд гаргасан л юм байна л даа. 20 онд жишээлбэл 12 дугаар сарын 2-нд Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд хамтарсан тушаал гаргасан гэж байгаа. 7-10 насны хүүхдийн өдрийн авах илчлэгийг 1735 килокалори гэхихсэн байна. Тэрнийхээ 35 хувийг үдийн хоолноос авна гэсэн байгаа. Энэ чинь бол 5, 6 жилийн өмнөх гэсэн үг шүү дээ. Энэ тайлан бол харагдаж байна.

Сая бол Ганмаа гишүүний танилцуулсан илтгэл дээр бол харахад бид нар илчлэг, бичил шим тэжээлийн тухай ярьж байна шүү дээ. Бичил шим тэжээлийн тухай ярьж байна. Энэ бид нарт ирсэн тайлан болохоор макро шим тэжээлийн тухай яриад байгаа юм. Нүүрс ус, өөх тос, уураг гурваа л яриад байгаа байхгүй юу. Энэ дээр дүгнээд асууя л даа. Бид нар өмнө нь ингээд, одоо бид нарт ирж байгаа материалууд ч гэсэн Монгол хүний хооллолтын гэр зөвлөмж гэдгээрээ л яваад байгаа. Тэгээд би өмнө нь асуусан шүү дээ нарны тусгалаас хамаараад байдаг санжуу, орчноос хамаараад аль бүсийн хүүхдүүд ямар хэмжээний хоол идэх ёстой. юм бэ, эрүүл мэндийн нөхцөл дээр тулгуурлаад ямар хоол идэх ёстой юм гэдэг тэр зөвлөмж юм гарсан уу, стандарт гарсан уу?

Жишээлбэл, энэ зөвлөмжөө энэ илчлэг тооцож байгаа энэ макро шим тэжээлээсээ ахисан түвшинд тэдэн грамм витамин ч юм уу бичил шим тэжээлтэй нь тайлбарлаж гаргасан ийм юм шинэчлэгдсэн үү 1 дүгээр асуулт.

2 дугаарт нь Нэгдсэн Үндэстний Байгууллага билүү би санаж байна “Сүү” хөтөлбөр гээд явж байсан байх. Ер нь бол сүү, цагаан идээгээ ид, хэрэглэ гэж бид нар бол дандаа сонсдог. Гэхдээ орон нутагт энэ сүү цагаан идээг ингээд

хэрэглэхээр тэр лабораторийн асуудал нь яадаг юм бол? Эрүүл ахуйн асуудлуудыг яадаг вэ? Ер нь хүүхэд хэдэн настай хүүхэд хэчнээн хэмжээний сүү, сүүн бүтээгдэхүүн идэх ёстой юм гэдэг зөвлөмж байгаа юу? Хэрвээ бид нар орон нутгийн нөөцийг ярих гэж байгаа бол цагаан идээн дээрээ тулгуурлах хэрэгтэй. Макробиотик онолоор цагаан идээгээ хэрэглэе гээд ярьдаг шүү дээ.

Тэгэхээр энэ дээр ер нь энэ хүүхдийн хоолны стандарт энэ зүйлд чинь энэ сүүн цагаан идээ эзлэх тэр орц байр нь ямаршуу хэмжээтэй тусгасан байдаг юм бол?

Гурав дахь асуулт нь Хяналтын зөвлөл гэж ярьж байна. Хүүхдийн хоолны зөвлөл гэж ярьж байна. Одоо хэчнээн сургуульд яг Хяналтын зөвлөл эсвэл Хүүхдийн хоолны зөвлөл ажиллаж байгаа юм бэ? Тэрний яг дагнасан тайлан, мэдээлэл байна уу?

Дөрөвд нь эцэг эхчүүдийн оролцоо огт байхгүй тухай өмнөх тайлан дээр байгаад байгаа. Одоо ер нь Монголд ийм эцэг эхчүүдийн оролцоог сайжруулчихсан сургуулийн жишиг байгаа юу энэ талаар мэдээлэл өгөөч ээ?

О.Номинчимэг: Дөрвөн тодорхой асуулт байна. Эхлээд Боловсролын яам хариулах уу? 1 номер.

Т.Түмэнжаргал: Гишүүний асуултад хариулъя. Энэ дээр бас Эрүүл мэндийн яам, Хөдөө аж ахуйн яам 2 эхний асуулт дээр бас нэмэх байх гэж ингэж бодож байна.

Ер нь бол энэ сургуулийн хүүхдийн хоолны шим тэжээлийн нормативыг барихдаа Эрүүл мэндийн яамны гаргасан сайдын тушаалын дагуу тэндээсээ сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолныхоо нормын дагуу ингээд гаргадаг байгаа.

Тэгэхээр Эрүүл мэндийн яам 2024 онд сая хүн амын хоол, тэжээлийн судалгааг хийсэн. Энэ дээрээ бол сургуулийн хоолны энэ шим тэжээлийн асуудлыг нэлээн оновчтой ийм үр дүнгүүд гарсан байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ 2 яам бид нар хамтраад яг энэ нормативаа шинэчлэх гэж байгаа. Энэ дээр яг таны хэлсэнчлэн тэр уураг, нүүрс ус, шим тэжээлээс гадна амин дэмийн хэмжээг бол бас нарийвчлан оруулах шаардлагатай гээд.

Тэгээд энэ дээр бас манай яамны зүгээс хэрэгжүүлсэн нөгөө “ЖАЙКА” олон улсын байгууллагын төсөл дээр бас яг энэ асуудлыг бид нарт зөвлөмжөөр өгсөн. Энэ нормативдаа та нар зөвхөн шим тэжээл гэхгүй эрдэс, амин дэмийнхээ хэмжээг бас нарийвчилж оруулж өгөөч гээд. Тэгэхээр энэ дээр бол 2 яам ингээд судалгааныхаа үндсэн дээр бол хамтраад ажиллах гээд ингээд явж байгаа.

Сүүний хэмжээ гээд. Энэ дээр бас мөн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт 24-28 онд хүүхэд бүрд сүү өгнө гэсэн боловч би бас энэ дээр нэг юмыг бас дахин дахин ажлын хэсэг дээр хэлээ гээд байгаа. Улсын төсвөөр уг нь энэ “Сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ёстой боловч өнөөдрийг болтол улсын төсөвт ерөөсөө мөнгө суугаагүй. Тийм учраас бид нар “ЖАЙКА” олон улсын байгууллагын төслөөрөө 2 аймагт эцэг эх, орон нутгаас хамтарсан ийм төсвийн хүрээнд энэ “Сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлээд одоогийн байдлаар 16 аймагт бол энэ “Сүү” хөтөлбөр бол хэрэгжээд явж байгаа.

Гэхдээ аймгийн түвшинд бол зарим алдаг, алаг цоог л ингээд хэрэгжээд явж байгаа. Энэ дээр бол бас яг таны хэлсэнчлэн түрүүний миний хэлээд байгаа хүнсний бүтээгдэхүүний хангамж гэдэгтэй адилхан сүүний хангамж орон нутагт маш хүнд байгаа.

Одоо манай нийслэл дээр нийлүүлж байгаа сүүн дээр бол “АПУ,” “Сүү” гэсэн 2 том компани л нийлүүлж байгаа. Орон нутагт бас бас яг энэ нийслэлээс аваачиж нийлүүлэх ийм асуудал гарч байгаа. Тийм учраас тэр бүтээгдэхүүний өртөг нэмэгдэж байгаа. Тийм. Энэ дээр бас Хөдөө аж ахуйн яам бас яг энэ хангамжийн, энэ сүү болон түрүүний хүнсний бүтээгдэхүүний хангамж дээр бас тодорхой хариултуудыг хэлэх байх гэж ингэж бодож байна.

Хяналтын зөвлөл гэдэг бол ер нь бол хуулиараа би түрүүн хэлсэн журамтай байгуулагдах ёстой. Байгуулагдсан байгаа бүх сургууль дээр. Харин үйл ажиллагааны хувьд бол бас хэрэгжилт дээр доголдолтой асуудлууд бол байж байгаа.

Тэгэхээр энэ дээр энэ Хяналтын зөвлөлөөрөө бид нар бол эцэг эхийн оролцоог тэнд бол эцэг эхийн төлөөлөл байдаг учраас эцэг эхийн оролцоог ингээд хангаад явж байгаа.

Энэ дээр би нэмээд хэлэхэд бол “KOICA” олон улсын байгууллагаар хэрэгжүүлсэн төслийн хүрээнд Шинжлэх ухаан, технологийн их сургууль дээр яг энэ хүүхдийн хоолны сургалтын ийм шим тэжээлийн төв байгуулагдсан байгаа. Энэ төвөөр дамжуулаад бид нар зөвхөн хоол үйлдвэрлэлийн ажилчид гэхгүй эцэг эх, сурагчдыг бид нар яг энэ хоол шим тэжээлийн боловсрол олгох, сургуулийн хоол үйлдвэр, үйлчилгээнд оролцох, ойлголт мэдлэгийг дээшлүүлэх энэ чиглэлээр сургалтуудыг үе шаттай ингээд хийгээд явж байгаа. Тэгэхээр энэ төв маань цаашдаа бол улсын хэмжээнд үйл ажиллагаагаа хийгээд явна.

О.Номинчимэг: Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас хариултыг нь авчихъя. Ер нь бол ийм шүү дээ. Бид нар ч гэсэн урьд нь энэ асуудлыг хэлэлцсэн. Энэ асуудлыг ярихаар ер нь Боловсролын яамны асуудал юм шиг ерөөсөө ингээд хаячихдаг. Тэгтэл та бүхэн энэ хуулиараа хүнсний бодлогоо, энэ хүнсний аюулгүй хүнсний хангамжийн бодлогыг зангидаж байх нөхдүүд нь та хэд байдаг. Тэгээд та хэдийн оролцоо ерөөсөө байхгүй.

Тэгэхээр саяын тэр юу гэдэг юм хүнсний шим тэжээлийн хангалтын энэ систем эд нар тэр хүнсний яам ер нь юу хийж байгаа юм? Хуулийн хэрэгжилт дээр нь яаж оролцож байгаа юм? Жамбалцэрэн Төрийн нарийн бичгийн дарга ирчихсэн байна наашаа суу. Аль нь хариулах юм? 9 номерын микрофон.

Т.Жамбалцэрэн: Гишүүний асуултад нэмэлт хариулт өгье өө. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны зүгээс бол хүнсний хангамж, нийлүүлэлтийн асуудал дээр илүү голчлон ажиллаж байгаа. Ялангуяа энэ сургуулийн хүүхдийн хүнсний хангамж, нийлүүлэлтийг нэмэгдүүлэхтэй холбоотой энэ нийлүүлэлт оролцож байгаа аж ахуйн нэгжүүдэд нь урт хугацаатай санхүүгийн зээлийн дэмжлэгүүд олгож байгаа.

Яг энэ хоолон дээр үүсэж байгаа асуудал дээр ажлын хэсэгтэй холбоотой, Боловсролын яамтай ажиллаж байгаагийн хүрээнд зохион байгуулалтын бол нэлээдгүй асуудлууд байгаа. Түрүүн хэлсэнчлэн яг энэ хүүхдэд, 1 хүүхдэд өгөх энэ

шим тэжээл, норм норматив шинэчлэн тогтоогоод гараад ирсний дараа аймаг, сумынх нь хэмжээнд, нийслэлийнх нь хэмжээнд, бүсийнх нь хэмжээнд хүнсний хангамжийнх нь нөөцийн судалгааг нь нэгтгэж гаргаад тухайн нийлүүлэлтийг нь бид нар бодлогын хэмжээнд зохион байгуулаад явах бүрэн бололцоотой байгаа. Энэ хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн.../минут дуусав./

О.Номинчимэг: Шим тэжээлийн стандарт нь гарсны дараа бид нар хийнэ гэж байхгүй шүү дээ. Та нар энийг угаасаа хийж байх ёстой байхгүй юу. Ийм нэг үлгэр шиг юм яриад байх юм. Саранчулуун гишүүн Эрүүл мэндийн яамнаас микро шим тэжээлээр асуул уу, эсвэл та тодруулах уу? Саранчулуун гишүүн тодруулъя.

О.Саранчулуун: Шим тэжээлээ макро, микрогоор нь гаргаад, хүүхдийнхээ эрүүл мэнд, нас хүйсээр нь гаргаж нарийн анхаардаггүй ийм байгаа болохлоор л тэр үдийн хоолны зураг чинь энд тэнд сэвэгдээд байгаа шүү дээ. Нэг бол дүүрэн төмс, эсвэл будаа. Тэгээд тэр чинь нуль калори бол байгаад байгаа. Дотроос нь юу ч байхгүй. Хүүхдийн эрүүл мэндэд хэрэгтэй юм юу ч байхгүй.

Тэгэхээр би энэ дээр дахиад тодруулчихъя. Одоо улсын төсөв дээр жишээлбэл энэ 2 яамны хамтран гарах тэр шим тэжээлтийн агууламжийг тусгасан тэр сайжруулсан нормативын чинь дагуу шинэчилсэн зардалд тусгагдах юм уу, тусгагдахгүй юм уу, амжих юм уу, амжихгүй юм уу? Одоо энийг чинь ингээд яригдаад зөндөө удаж байна шүү дээ. Хэзээ гарах юм Эрүүл мэндийн яамнаас?

О.Номинчимэг: Эрүүл мэндийн яам Төрийн нарийн ирсэн байна. Бодлогын газрын дарга хаана? Тийшээ очоод микрофон дээр очоорой. Ажлын хэсгийн микрофон дээр. 2 номерын микрофон Цэцэгсайхан дарга.

Б.Цэцэгсайхан: Тэгэхээр Саранчулуун гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр ер нь сургуулийн хүүхдүүдийн дунд бичил тэжээлийн дутал, амин дэм, эрдэс бодисын дутагдал бол ер нь бол өндөр байгаа. 2023-аас 24 онд хийсэн хоол тэжээлийн 6 дугаар судалгаагаар цус багадалт өндөр байгаа. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 7.6 хувьд нь цус багадалттай. Хангайн бүсэд бол цус багадалт хамгийн өндөр буюу 10.3 хувьтай байна. Түүнээс гадна Д амин дэмийн дутагдал бол сурагчдын 89 хувьд нь байна. Энэ дотроо баруун бүсэд ер нь бол бүсийн ялгаа бол Д амин дэмийн дутагдлын хувьд байхгүй. Гэсэн хэдий ч ахлах ангийн хүүхдүүдийн хувьд 10-12 дугаар ангийн хүүхдүүдийн хувьд бол 72 хувь нь Д амин дэмийн дутагдалтай байна.

Түүнээс гадна иодын дутагдал бас нэлээн өндөр байгаа. Сүүлийн жилүүдэд иоджуулсан давсны хэрэглээ буурсантай холбоо.../минут дуусав./

О.Номинчимэг: Гүйцээж хариулъя 2 номер.

Б.Цэцэгсайхан: Иодын дутагдал бол өндөр байгаа. 2017 оны судалгааны дүнгээсээ бол буурсан үзүүлэлттэй байгаа. Иодын дутагдлын хувьд аваад үзэх юм бол баруун бүсэд иодын дутагдал хамгийн өндөр байгаа нь харагдаж байгаа.

О.Номинчимэг: Саранчулуун гишүүн тодруулж асууя. Нэмэлт 1 минут.

О.Саранчулуун: Би одоо тэгээд асуугаад байна шүү дээ. Хэзээ манай улс хүүхдүүддээ эрүүл мэндийн байдалд нь тохирсон, амьдарч байгаа орчин нөхцөлд нь тохирсон шим тэжээлийн нормативыг нь хангасан үдийн хоолыг улсын төсөвтөө

тооцож оруулдаг болох юм бэ? Хэзээ Гэр бүлийн яам, Боловсролын яам, Хүнсний яам гурвуулаа нийлээд энэ юмаа гаргах юм бэ гэж би асуугаад байна шүү дээ. Хэзээ хүүхдүүд үдийн, өдрийн нийт авах ёстой тэр илчлэгийг бол энэ дээр бол илчлэг л ярьсан байна л даа. 100 хувь гэж бодоход үдийн хоолноос 30 хувь авах ёстой юм шиг байна анхны баримжаагаар. Тэгээд тэр 30 хувиа хэзээ бүрэн дүүрэн өгдөг болох юм бэ гэж асуугаад байна. Орон нутагт өгч байгаа сүү, цагаан идээ хэр хэмжээнд идэх ёстой. юм бэ? Ааруулаа идэх ёстой юм уу, ёсгүй юм уу? Хэлээд өгчих л дөө иргэдэд бас мэдээлэл л болно шүү дээ. Хэзээ улсын төсөвт зөв үдийн хоол чинь тусгагдах юм бэ? Хэдэн сургууль үдийн уртасгасан цагтай болох вэ?

О.Номинчимэг: Улсын төсөв дээр угаасаа 12 дугаар анги хүртэл ер нь хоол үе шаттайгаар оруулна гэдэг энэ хууль бол батлагдсан. Тэгэхдээ тогтоолоор хэрэгжилтийг нь хойшлуулсан. Гэхдээ хэрэгжих хугацаа нь болчхоод байхад хэрэгжихгүй байгаад байгаа энэ хэрэгжилтийн тайлан байгаад байгаа тээ? Тэгээд бид нар бас яг энэ дээр бол ажлын хэсэг гарч, санал, дүгнэлтээ гаргаж ажилласан. Дараагийн санал, дүгнэлтээр нэлээн гарах байх. Хэзээ гэдгийг цөмөөрөө хамтдаа шийдье. Төсвийн төсвийг хааш нь чиглүүлэх бол Улсын Их Хурлын бараг бүрэн мэдэл, бодлогын асуудал байгаа. Тэр дээр бол Баасанжаргал гишүүний угаасаа ажлын хэсэг дээр бас нэлээн нарийн мэдээлэл өгөх байх.

Цагаан идээтэй холбоотой асуулт асуусан уу Саранчулуун гишүүн? Сүү, цагаан идээний хэрэглээ энэнтэй холбоотой ер нь юу юм уу Саранчулуун гишүүний асуугаад байгаа тэр килокалориор нь биш микро шим тэжээлээр нь бид нар стандарт тогтоох асуудал ер нь их явагдаж байгаа юм уу? Нарийн судалгаатай хамтарсан тэр журмаараа батлах гээд байгаа юм уу? Монгол хүүхдэд өдөртөө ийм микро шим тэжээл хэрэгтэй байгаад байна. Энийг нь бид нар гүйцээж өгдөг байя гэдэг нөгөө очих газрынхаа юмыг тогтоох гээд байна шүү дээ нарийвчилж килокалориор нь биш тийм юм хийгдэж байгаа юу гэсэн асуултад нь хариулаач тэгэх үү? Эрүүл мэндийн яам хариулах уу? 2 номерын микрофон.

Б.Цэцэгсайхан: Тэгэхээр 2020 оны 3 сайдын хамтарсан тушаалыг одоо бол шинэчлэх ажил бол хийгдэж байгаа. Энэ хүрээнд бол бид нар хүүхдүүдэд шаардлагатай килокалориос гадна ер нь ямар шим тэжээлийн дутагдал өндөр байгаа тэрэнд нь таарсан бас хоол, хүнсийг оруулах чиглэлээр бол ажиллаж байгаа.

О.Номинчимэг: Тодорхой юу байхгүй байгаад байх байх шиг байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя. Түрүүн нэр өгсөн микрофоныг нь нээе.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа та хэд маань хүүхэдтэй байх гэж найдаж байгаа. Төрийн албан тушаалтнууд ямар байдлаар ажил хийдэг вэ гэдэг нь бодит жишээ өнөөдөр яг энд танхимд явагдаж байгаа юм. Олон жил ярьж байна даа энийг. Тэгээд нөгөө гөлөг төөрүүлнэ гэдэг шиг хариулт нь яг ийм байдлаар явсаар байгаад л таарсан.

Төрийн байгууллагууд дээр нэг юм байна. Төрийн байгууллагыг унтуулдаг дарга нарын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудал байна. Стандарт, хэмжил зүйн газрын даргаар ажиллаж байсан Билгүүн гэж нөхөр Стандарт, хэмжил зүйн газрыг унтуулаад бүр сэхээнд оруулаад хаяад Монополын эсрэг газар дээр очсон. Одоо Монополын эсрэг газрыг унтуулж байгаа. Тэнд хэрэглэгчийн асуудал хөндөгддөг байхгүй юу. Тэнд хэрэглэгчийн асуудал хөндөгддөг. Та хэд өнөөдөр энэ дээр ингээд маш олон дүгнэлтүүд гаргаад ирчихсэн. Өнөөдөр жил болгон 100

гаруй мянган хүүхэд хоол боловсруулах тогтолцооны өвчлөлөөр өвдөж байгаа гэдгийг та нар ерөөсөө мэдрэхгүй байгаа байхгүй юу.

Яагаад гэвэл та нар зарим нь хүүхэдгүй магадгүй, зарим нь эсвэл хүүхдүүд чинь насанд хүрчихсэн, эсвэл бүгдээрээ Улаанбаатар хотод байдаг огт хүүхдүүддээ санаа зовдоггүй хүмүүс л өнөөдөр энд цуглачхаад байх шиг байгаа юм. Би бол тэгж дүгнэж байгаа юм. Буруу дүгнэсэн бол уучлаарай. Яагаад гэхээр өнгөрсөн 2 жил гарангын хугацаанд парламентаар хэлэлцэгдэж байгаа энэ асуудал дээр иймэрхүү асуудлууд дээр та бүхний өгч байгаа хариултууд яг ижил түвшинд 2 жил ямар ч update хийгдсэнгүй, ямар ч ахиц дэвшил байсангүй.

Төрийн албаны тухай хуулиар хамгаалагдсан ийм нэг бүлэглэл бий болчхоод байх шиг байгаа юм. Одоо та хэд өөрсдөө энэ дүгнэлтээ унш даа. Орон нутгийн нийлүүлэлтийн тогтолцоо, гарал үүслийн баталгаажуулалт сул байгаа нь хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлж байна. Үгүй ээ, тэгээд засаач ээ жил болгон ийм юм оруулж ирэх юм. Тусгай хоолны хэрэгцээтэй, харшилтай хүүхдийн зохицуулалт дутмаг, нийлүүлэлтийн тогтолцоо тогтворгүй байгаа. Ханган нийлүүлэлтийн тогтолцооны сул тал, тендерийн чадамж, нийлүүлэлтийн тогтвортой байдал, чанарын баталгаажуулалт асуудалтай.

Монгол Улсын стандарт харьцангуй доогуур, насны бүлэг хүйсээр ялгаагүй нэгдмэл стандарттай. Энэ дутагдалтай асуудалд орж байгаа юм. Хэн засах вэ? Тэгээд бид нар засах уу? Хэрэгжүүлэгч байгууллагууд дээр л алдаа гараад байна гэдгийгээ зоригтой хэлээд зоригтой Байнгын хороон дээр асуудлуудыг нь яриад, дүгнэлт дотроо холбогдох төрийн байгууллагын ажлаа хийхгүй байгаа арчаагүй дарга нартаа хариуцлага тооцох асуудлыг та нар давхар энэ дүгнэлт дотроо оруулж бай л даа. Энэ чинь хүүхдүүд үхээд байна шүү дээ тэнд. Хүүхдүүд ходоодны хорт хавдартай болоод байна. Хүүхдүүд бүгд хоол боловсруулах тогтолцооны өвчлөлтэй болчхоод байна шүү дээ.

О.Номинчимэг: Их ерөнхий асуулт байна шүү дээ. Хэнээс нь асуух юм та? 9 номерын микрофон. Жамбалцэрэн Төрийн нарийн бичгийн дарга.

Т.Жамбалцэрэн: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн. Энэ яг таны хэлж байгаатай адил асуудал салбар салбар дээр байна Салбар хоорондын уялдаатай холбоотой гэдэг юм уу. Бид нарын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны барьж байгаа бодлого бол энэ хүнсний хангамжийн тогтвортой байдал, нийлүүлэлтийг л хариуцаж ажиллаад байгаа.

Ялангуяа тэр Эрүүл мэндийн сайдын 2017 онд баталсан хоногийн хоол хүнсээр авах цохих илчлэг тэжээл, шимт тэжээлийн тооцсон тэр зөвлөмж байдаг. Энэний дагуу хүнсний хангамж, нийлүүлэлтийг бодлогын хүрээнд тооцож авч явдаг. Энэ хүрээндээ хангамж багатай хүнсний дотоодоосоо хангалтыг нийлүүлэх, импортын хамаарлыг багасгах энэ чиглэлийн бодлого, зохицуулалтуудыг авч байгаа.

Ялангуяа Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хүрээнд аж ахуйн нэгжүүдэд урт хугацаатай хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн бодлогоор дэмжих энэ ажлуудыг хийж байгаа.

Яг Хүнсний тухай хуулиараа тэр хүнсний хангамж, нөөц бүрдүүлэлтийн ажил бол бүх шатын Засаг дарга нар дээр байдаг. Тэгээд энэ ажлыг зохион байгуулахад энэ орон нутгийн уялдаа холбоо, орон нутгийн захиалга, мэдээллүүд бас их дутмаг байгаад байгаа юм. Юу гэдэг юм нэг аймаг дээр аймгийн төвийн 4 сургууль гээд тэгэхэд 10 мянган хүүхэд үдийн хоолонд хамрагдаж байгаа гээд 10 мянган хүүхдэд хэрэгцээтэй хүнсний хангамж, аюулгүй байдлын тогтвортой нийлүүлэх хүнсний сүлжээ, тогтолцоо нь орон нутгийнхаа хэмжээнд бий болж чадаагүй байгаа.

Нөгөө талдаа дэмжлэгийн хэлбэрүүд нь манай салбар дээр яваад байдаг. Зохион байгуулаад аж ахуйн нэгжүүдийг нь зохион байгуулаад өгье бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг нь бий болгоод өгье, аж ахуйн нэгжүүд урт хугацаатай хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлийн дэмжлэгийг нь гаргаад өгье гэдэг. Яг энэ дээр Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан дээр ч санхүүжилтийн эх үүсвэрүүд байдаг. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам сайдын багц дээр энэ хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөний хүрээнд санхүүжилт олгочих боломжтой дэд бүтцүүд байгаад байдаг. Барьцаа хөрөнгийн дутагдалтай иргэн, аж ахуйн нэгжүүд дээр нь Зээлийн батлан даалтын сангаар дамжуулаад баталгаа гаргах бололцоонууд нь байгаад байдаг. Тэгээд энэний ашиглалт маань өөрөө учир дутагдалтай байна.

Орон нутаг дээр тодорхой санал санаачилгуудаа гаргаад ирэхэд энэ чиглэлээр хүнсний хангамж нийлүүлэлтэд оролцож байгаа дотоодын үндэсний хэмжээний компаниудыг бид нар бүсчлээд зохион байгуулаад өгөх бололцоонууд нь байгаад байгаа юм. Харамсалтай нь улсын төсөв дээр ч тодорхой асуудлууд салбарын яаман дээрээс гаргасан саналууд маань улсын төсөв дээр яг тухай чиглэл бүрээрээ бас тусаж чаддаггүй асуудлууд байгаа. Орон нутаг дээр ирсэн саналууд нь бас энэ чиглэлээрээ тусаж чаддаггүй. Зохион байгуулалтын уялдаа, энэ засаг захиргааны нэгжийн хуваарилалтаасаа болоод бас нэг түвшинд нэг цонхоор асуудлуудаа шийдвэрлэж чадахгүй асуудлууд байгаад байна гэдэг ийм асуудал байдаг.

Өнгөрсөн хугацааны яг энэ сургуулийн хүүхдийн үдийн хоолтой холбоотой хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын хүрээнд ирсэн зээлийн хүсэлтүүд дээр тодорхой шийдвэрүүд гараад үйлдвэрлэлүүд бүтээгдэхүүн, нэр төрлөө өргөтгөөд явж байгаа асуудлууд байгаа.

2026 оны тухайд улсын төсөв дээрээс хүнсний хангамж, аюулгүй байдлыг хөтөлбөрийн хүрээнд шинэ зээл гарах төсөв бол огт суугдаагүй. Одоо явж байгаа зээлүүд бол арилжааны зээл буюу 18 хувийн хүүтэй зээлүүд явж байгаа. Жижиг, дунд үйлдвэрийн сангаас олгож байгаа зээлүүдийн маань хүртээмжид төдий л хүрч чадахгүй байгаад байгаа. Ялангуяа энэ улирлын хамаарал ихтэй, энэ малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн, энэ төмс, хүнсний ногооны улирлын хамаарлыг бууруулахгүй бол энэ бид нарын үдийн хоолонд зарцуулж байгаа төсөв маань энэ зардалдаа хүрч чаддаггүй. Тодорхой бүс нутгууд нь газар тариалангийн бүс нутгуудад харилцан адилгүй, Улаанбаатар хотоос алслагдсан бүс нутгуудад энэ зардал нь харилцан адилгүй байдгаас шалтгаалаад шим тэжээлийнх нь тэр норм, норматив нь жигд хүртээмжтэй хүрч чадахгүй асуудал байгаад байгаа юм.

Түрүүн Байнгын хорооны даргын хэлсэнчлэн энэ асуудал дээр яг энэ сургуулийн хүүхдийн бага, дунд, ахлах ангиар нь гээд энэ ангилал заагтай шим тэжээлийнх нь нөөц нь гараад ирэхэд бид нар энэ дээр нь бас аргачлал боловсруулаад ажиллах бололцоо бол бид нарт бол байгаад байгаа юм.

О.Номинчимэг: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Амьдралаас л тасарчхаад байгаа юм л даа та хэд. 1 хүүхдийн авах килокалори, шим тэжээл гээд байдаг. Үхрийн мах нэмэгдсэнийг мэдэж байгаа юу? Өнөөдөр, өнгөрсөн 7 хоногт надад Хөвсгөл аймгийн сумыг нь хэлээд яах вэ сумын сургуулийн ерөнхий боловсролын сургуулийн захирал орж ирж уулзаад гарсан. Тендерээр дамжуулаад худалдан авалт хийхээр 1 үхэр 6 сая төгрөг, 6 сая төгрөг шүү. Өөрсдөө газар дээрээс нь худалдаад авах боломж нь байвал 1.5-2.2 сая төгрөг 1 дүгээрт.

Махны чинь үнэ хөдөө орон нутагт нэмэгдчихээд байна. Тэгэхээр үдийн чинь хоолны чинь зардал нэмэгдчихээд байна гэсэн үг. Энийг мэдэж байгаа хүн байгаа юу гэдгийг би 1 дүгээрт асууя.

2 дугаарт Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сум 250-аас бараг 300 метр газар -45 градусын хүйтэнд сургуулийнхаа байр руу хоолоо зөөж байгаа юм. Үдийн хоолоо. Энийг яаж шийдэх вэ хэдүүлээ? Хүйтэн хоол өгөөд байх уу хүүхдүүддээ? Энийг мэдэж байгаа.../минут дуусав./

О.Номинчимэг: Хөдөө аж ахуйн яам, Эрүүл мэндийн яамнаас асуусан уу? 9 номер уу? 9 номерын микрофон.

Т.Жамбалцэрэн: Махны үнийн асуудалтай холбоотой тайлбар хийе ээ. Энэ бас л түрүүний миний хэлсэнтэй холбоотой. Бид нар энэ улирлын хамаарлыг багасгахгүй бол махны үнэ энэ хэмжээнд л явна. Тэгэхээр энэ Хүнсний тухай хуулиараа үүрэг хүлээсэн энэ засаг захиргааны нэгжүүд нь өөрсдөө энэ улирлын хамаарлаа бууруулах, энэ махны нөөцөө бүрдүүлэх, үнийг тогтворжуулах ажлаа зохион байгуулах ёстой. Энэ чиглэл дээр салбарын яамнаас үнийг нь тогтворжуулах чиглэлээр бол тодорхой ажлуудыг бол зохион байгуулж ирсэн.

Одоо энэ өнөөдрийн үүсээд байгаа нөхцөл байдал дээр 21 аймаг, нийслэл дээр энэ хууль хэрэгжүүлэх чиглэлээр холбогдох чиглэлүүдийг нь өгсөн. Хүнс, хөдөө аж ахуйн.../минут дуусав./

О.Номинчимэг: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Лам нь байхаар хонх нь таг, хонх нь дагахаар дамар нь таг гэдэг шиг л юм болчих шиг байна Жамбалцэрэн даргаа. Би тендер 6 сая төгрөгөөр тендерт 6 сая төгрөгөөр үхрийг чинь аваад байна хөдөө наад үдийн хоол хөтөлбөртэй чинь холбоотойгоор. Тэгээд үнэ нь нэмэгдчихээд байна Та нарын өдрийн тавьсан 2500 байдаг юм уу? 1500 гэдэг төгрөг чинь нэмэгдчихээд байна, хэмжээ чинь багасчхаад байна л гэдгийг би хэлээд байна. Нийтийн мах би ерөөсөө яриагүй. Та хүний үг сайн сонсох хэрэгтэй.

Тендерт орохоор яахаараа 1.5-2.2 сая төгрөгийн үнэтэй байгаа үхэр 6 сая төгрөг болоод наад орон нутагт чинь хүүхдүүдийн үдийн хоолны үхрийн мах үнэ нэмэгдсэнээс болоод багасчхаад байгаа юм бэ? Энэ дээр хэн хяналт тавьж байгаа юм бэ? Та нарын яриад байгаа килокалори энэ тэр чинь энэ дотор асуудал чинь хөндөгдчихөөд байна Тэр зөөгөөд байгааг яаж шийдэх вэ? Зөөгөөд байгааг нь хэн хариуцах юм?

О.Номинчимэг: Тийм энэ Бат-Эрдэнэ гишүүний асуулт яг энэ яг хуулийн хэрэгжилттэй холбоотой байхгүй юу. Одоо энэ бид нарын өнөөдөр үр дүнгийн үнэлгээг энэ хэлэлцэж байгаа хуулийн чинь 10.1.1-д сургуулийн 1 хүүхдэд ноогдох хоолны зардлын нормативыг инфляцын түвшин болон сурагчдын шим тэжээлийг хэрэгцээг харгалзан жил тутам шинэчлэн батална гэдэг ийм үүрэг байгаа. Энэ бол Засгийн газрын үүрэг. Тэгээд Засгийн газар гээд орхичихсон энэ хууль дээр.

Тэгээд энэ Засгийн газар энэ үүргээ тэгвэл жил болгон нормативынх нь хэмжээ, одоо та бүхний нөгөө хэлээд байгаа энэ чинь нормативдаа хүрэхээ больчихлоо, шим тэжээлдээ хүрэхээ больчихлоо, инфляц нь ихсэж байна, махны үнэ ихсэж байна. Тэгтэл хоолных нь энэ хуваарилж байгаа төсөв дээр сууж байгаа мөнгө нь өөрчлөгдөхгүй байгаад байгаа жил болгон. Тэгээд Засгийн газар энэ чиг үүргийг уг нь жил болгон энийгээ батлаад нормативыг нь жил болгон шинэчилж инфляцтай холбогдуулан, шим тэжээлтэй холбогдуулан батлаад төсөвтөө суулгана гэсэн ийм үүрэгтэй байхгүй юу хууль дээрээ. Тэгээд энийг ер нь хэн хэрэгжүүлж байна л гэдгийг асуугаад байна. Тэгтэл ингээд нөгөө Засгийн газар гээд хууль дээрээ очингуут энэ 3 яам нь мэдэхгүй, би бол хүнсээрээ, би бол эрүүл мэндээрээ, би бол боловсролоороо гээд ингээд л чиг үүрэг чиг үүрэг гэхээр дунд нь яг ийм бодлогын цогц юм нь алдагдаад байна уу л гэдэг асуулт асуугаад байх шиг байна. 1 номерын микрофон уу? 1 номерын микрофон хариулъя.

Т.Түмэнжаргал: Би энэ дээр бас нэмж хариулъя. Түрүүн би нөгөө мэдээлэлдээ бас товчлоод явчихсан. Ер нь бол яг энэ махны үнийн өсөлтөөс шалтгаалаад хүүхдийн авбал зохих илчлэг, шим тэжээл, тэр уураг, нүүрс усны агууламж бол 50-60 хувьд хүрчхээд байгаа. Тийм учраас бид нар 27 оны төсөвт 2500 төгрөгийг 3500 төгрөг болгож нэмэгдүүлээч ээ гэхэд зөвхөн 1-5 дугаар ангийн хүүхэд дээр 48 тэрбум төгрөгийн төгрөгийн нэмэлт гарч байгаа. Тэгээд энэ саналаа бид нар 27 оны улсын хөгжлийн төлөвлөгөө болон төсөвт өгчихсөн байгаа.

Ер нь бол 2024 онд л 2500 төгрөг, 1500-2500 төгрөг нэмэгдсэн. Сүүлийн 2 жил нэмэгдээгүй. Жил болгон бид нар энэ үнийн өсөлтөөс шалтгаалаад хүүхдийн хоолны шим тэжээлийн байдал ингээд алдагдаад байна гээд жил болгон төсөвт саналаа өгдөг. Нэмэгдэхгүй байгаа болохоор бид нарт бас хүрэлцэхгүй байгаа асуудал байгаа.

Мэдээж тэр махны үнэ бас яг энэ бид нарын сая энэ сүүлийн 3, 4 сард бүүр огцом бууруулсан. Одоо яг 2500 төгрөгийн бараг 60, 70 хувь нь зөвхөн махандаа явж байгаа. Зөвхөн махны худалдан авалтдаа. Тэгэхээр цаана нь бид нар 2500.../минут дуусав./

О.Номинчимэг: Би энэ дээр бас өнөөдөр олон хүний оролцоотой энэ хэлэлцүүлгийг хийж байгаа. Нэмэлт бас асуултыг асуугаад дараагийн 2 асуудал ч гэсэн ажлын хэсэг адилхан бас асуудлууд байгаа болохоор юутай ч юу яая гэж бодож байна. Ер нь бол ингээд хуулийн хэрэгжилтийн үнэлгээ бид нар бас хэлэлцэж байгаа яг энэ асуудал дээр. Тэгэхээр хууль дээрээ баахан юм биччихдэг. Гэхдээ хэзээ ч хэрэгжүүлдэггүй л ийм хууль болчихоод байна шүү дээ. Тэгээд бид нар хууль баахан л үйлдвэрлэдэг. Уялдаа холбоо байхгүй. Энэ 2019 онд гарч байсан хууль.

Тэгээд ингээд нөгөө яамнуудынх нь чиг үүргийг харахаар ялт ч үгүй чиг үүрэг нь бүрэн эрх гээд нэг баахан 3, 4 юм хийчихсэн. Тэгээд тэр нь аягүй тийм

өнгөцхөн, ерөөсөө энэ нөгөө хоол үйлдвэрлэл ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд шим тэжээлтэй аюулгүй хоол, хүнсийг яаж зөв зохион байгуулалт тай хангах вэ гэдэг систем ерөөсөө энэ хуулиар угсрагдаагүй.

Ийм болохоор ерөөсөө ингээд яамнууд нь энэ чиг үүргийнхээ хүрээнд бол бид нар ийм юм хийчихсэн гээд байдаг. Гэхдээ бодит байдал дээр ерөөсөө үр дүнд хүрч чадахгүй байгаа юм харагдаад байгаа байхгүй юу. Эндээс би 2 юм асуумаар байна.

1 дүгээрт Сангийн яамны төлөөлөл байгаа тийм үү? Сангийн яам энэ хуулийн 10.1.1-д заасны дагуу энэ төсвийг бол жил болгон энэ инфляцтай уялдуулаад, гаргаад тэгээд тухайн жилийн энэ зардлын төсвийг нь заавал төсөлд суулгаж ингээд хэрэгжүүлнэ гэдэг Засгийн газрын ийм үүрэгтэй. Хуулиараа үүрэгтэй. Бид нар чинь тэтгэвэр, тэтгэмжийг бол яг инфляцтай жил болгон уяна гээд. Энийгээ ингээд яс төсөв дээрээ суулгаад явдаг. Яагаад тэгвэл энэ ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн хоолны энэ асуудлын хууль нь байгаад байдаг инфляцтай жил болгон уялдуулна гээд хэрэгждэггүй юм бэ? Яагаад төсөвт суудаггүй юм бэ? Ямар учир шалтгаанаас төсвөөс энэ дандаа хасагдаж ирдэг юм бэ? Энэ дээр нэг тайлбар өгчих.

Өнөөдрийн манай бас энэ хэлэлцүүлэг дээр яг энэ бодит амьдрал дээр нь ажилладаг бас албан хаагчид хүмүүс маань ирсэн байгаа. 3 дугаар сургуулийн захирал байна, Баянгол дүүргийн Боловсролын хэлтсийн хоол зүйч байна. Энэ ялангуяа энэ багш нараас маань би асуумаар байгаа юм. Та бүхэн яг одоогийн системээр хүүхдүүддээ энэ шим тэжээлтэй хоолыг өгье, зохион байгуулъя гэхээр яг бодит байдал дээрээ тулгамдаж байгаа асуудал чинь юу байна. Захирлуудын хувьд энэ нөгөө хоол шим тэжээл гээд л ингээд л хоолтой зууралдахаар худалдан авалтаасаа эхлүүлээд маш их ийм ачаалал ирдэг гэдэг ийм гомдлууд бол ирдэг. Энэ зохион байгуулалтын хувьд та нарт тулгамдаж байгаа хүндрэл байна уу? Юуг хийвэл шийдчих боломжтой байна? Таны хувьд яаж энийгээ шийдэж ирсэн гэдгийг бас өнөөдөр энд нээлттэй бид нар хэлэлцүүлж байгаа. Олон хүнд энийг бас бодит байдал дээр ийм байдаг шүү гэдгийг хэлээсэй гэж хүсэж байна. Тэгэхээр энэ 2 асуултад хариулъя. Сангийн яам болон манай өнөөдөр хэлэлцүүлэгт оролцож байгаа хоол зүйч болон сургуулийн захирал нарыг микрофон дээр суухыг хүсэж байна.

Эхлээд 1 номер Сангийн яам.

Б.Дэнсмаа: Сангийн яам, Төсвийн бодлогын газрын Төсвийн зарлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Дэнсмаа байна. Асуултад хариулъя. Бид нар бол ирэх жилийн төсвийг боловсруулахдаа маш олон үзүүлэлтүүдийг харгалзаж үздэг ээ. Тухайн жилийн ирэх жилийнхээ хөгжлийн төлөвлөгөө, дээрээс нь урт хугацааны хөгжлийн бодлого, макро эдийн засгийн нөгөө үндсэн үзүүлэлтүүд, төсвийн орлогын бүрдэл зэрэг маш олон зүйлийг харгалзаж үздэг.

Одоо бид нар бол жишээлбэл хүүхдийн хоолны нормативыг бол Засгийн газрын тогтоолоороо хүүхдийн хоолны түүхий эд материалын зардлыг л бид нар хүүхдийн тоонд нь үндэслээд ингээд өргөн барьдаг. Гэтэл бол сүүлийн 24 оноос хойш бол норматив маань бол батлагдааг шинэчилж батлагдаагүй. Энэ норматив шинэчлээд батлагдсан нөхцөлд бид нар 27 оныхоо төсвийн төсөлд бол нэмээд оруулах боломжтой.

О.Номинчимэг: Манай сургуулийн төлөөлөл байна уу? 6 номер. 6 номер.

Б.Хоролгарав: Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Сүхбаатар дүүргийн 3 дугаар сургуулийн захирал Хоролгарав гэж хүн байна.

3 дахь жилдээ сургуульд хоол үйлдвэрлэлээ бие даан хэрэгжүүлж байгаа. Ингээд түрээслэгчээс өөрөө өөрт сургуульд шилжихээр бас давуу талууд бол гарч байгаа. Хоолны нэр төрөл, илчлэг хэмжээ бол нэмэгдсэн. Түрээслэгчийн үед бол 200 килокалори хүрэхгүй хоол өгдөг байсан бол өдөр сарын дунджийг аваад үзэхээр багадаа 358, ихдээ 495 килокалоритой ийм хоол өгч байгаа.

Өдрийн мөнгөн дүн бол 2100-2700 төгрөгийн хооронд хэлбэлзэж сард бол 30 дунджаар 34 сая төгрөг үдийн хоолонд бол зарцуулж байгаа. Манай сургууль бол 2800 хүүхэдтэй. 1058 хүүхэд өнөөдрийн байдлаар үдийн хоол хөтөлбөрт бол хамрагдаж байгаа юм. Ингээд бие даан үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл явагдахад сургууль дээр хүндрэл.../минут дуусав./

О.Номинчимэг: 6 номер гүйцээж хариулъя.

Б.Хоролгарав: Боловсон хүчний асуудал байгаа юм. Манай сургууль өөрөө зориулалтын байртай. 450м² заалтай, 2000-аад метр квадрат хоол бэлтгэдэг танхимтай учраас байр савны хувьд бол 1000-аад хүүхдэд хоол үйлдвэрлэл өгөхөд бол асуудал байхгүй. Гол нь тэнд ажиллах боловсон хүчний асуудал өнөөдөр сургуулийн захирлуудад хүндрэлтэй. Тогооч олдохгүй, угаагч олдохгүй, үйлчлэгч олдохгүй байна.

Тэгээд ингээд өөрийнхөө бас эрх мэдлийн хүрээнд бас бид нар үндсэндээ өнөөдөр энэ үйлчилгээний ажилчдыг аргадаж л байлгаж байна. Шаардлага тавихаар ингээд бараг явчихдаг. Тогтвортой байж чадахгүй. Тэгээд тогтвортой байлгахын тулд цалин хөлс бол үнэндээ бага. Энэ жил л сая 578 мянган төгрөгийн цалинтай боллоо тогооч, Үйлчлэгч, угаагч, бэлтгэгч бол үүнээс ч цалин багатай байгаа. Ингээд тогтвортой байлгахын тулд бас өөрсдийн нөхцөл бололцоогоо дайчлаад илүү цагийн мөнгийг нь өгөхөөр сарын 16 цагаас илүү цаг өгч болохгүй гээд тэрийг Төрийн сан гаргадаггүй.../минут дуусав./

О.Номинчимэг: Хугацаа яасан учраас Батсуурь гишүүн, дараа нь Сайнзориг гишүүн асуулт нэмж асуухаар явъя. Батсуурь гишүүн асуулт асууя.

Ж.Батсуурь: Би энэ тогтоол гараад бол асуудлыг шийднэ гэж бодохгүй байна 1 дүгээрт.

2 дугаарт, энэ 3 яамны 20, 30 хүнийг авчирч загнаад бас асуудал шийдэгдэнэ гэж бодохгүй байна. Системийн шинэчлэл хийх ёстой. Би энэ эх барьж байгаа намыг Байнгын хорооны дарга энэ том дарга нар байна та нар. Та нар ер нь намынхаа мөрийн хөтөлбөрийг нэг олж хараач ээ. Тэгээд Байнгын хорооны дарга нарын түвшинд байдаг юм уу бүр сайд нарын түвшинд байдаг юм уу ийм том асуудлыг бүтцээр нь авч ярихгүй бол суурь асуудлуудаа яриагүй байж байж ингээд энд тэндээс нь тастаж авч яриад байна.

Өнөөдөр хөдөөгийн 21 аймаг 300 гаруй суманд усаа шийдчихсэн сургууль гэж үндсэндээ цөөхөн байгаа. Дулаанаа шийдчихсэн сургууль цөөхөн байгаа. Цэвэр, бохироо шийдсэн сургууль цөөхөн байгаа. Тэгээд энэ бүх асуудлуудыг

шийдэгдээгүй байхад энэ тогтоолоор хоол зүйчийн, тогоочийн бэлтгэл мэргэжлийг дээшлүүлээд яах юм. Хөдөөд байгаа усыг энд хөдөө явдаг хүмүүс бараг байхгүй байна л даа. Хөдөө яваад ус нь тэнцэж байгаа газар гэж байхгүй шүү дээ говийн газруудад. Үгүй бол кали ихтэй, магни ихтэй, хлор ихтэй, зөөврийн устай. Тэр нь өвөл ажиллахгүй. Тэгээд тэрийг саванд хадгална. Тэгээд бүр анхдагч болсон усны асуудлаа бүрэн шийдээгүй, нойл, бохирын асуудлаа шийдэгдээгүй өнөөдөр кали, иод калори яриад яах юм. Анх тэрийг чинь хольж ууж байгаа юм нь болохгүй байгаа юмыг.

Тэгэхлээр миний бодлоор өдийд 16 оноос хойш 3 сонгууль дамжаад ярьснаараа юм уу, амласнаараа бол өнөөдөр чинь Улаанбаатар биш хөдөөгийнх нь бүүр гадаадын сургуулиудаас илүү болчихсон байх ёстой шүү дээ бүх асуудлуудыг чинь шийдчихсэн. Нэг нь ч шийдэгдээгүй байгаа. Тэгээд энэ одоо ингээд Засгийн газарт чиглэл өгөөд энэ тогтоол гаргаж хүмүүсийг шилний цаанаас чихэр долоолгодгоо боль оо. Энэ хүмүүсийг мянга загнаад нэмэргүй. Аль ч яам нь өмнөө байгаа хэдэн цаасаар нүүрээ тахлаад л гарахаас өөр арга байхгүй шүү дээ. Системийн шинэчлэл хийгээч.

Одоо яаж байна вэ гэхлээр та бүхэн одоо шүүмжлэхээс ч өөр аргагүй. Үнэхээр хүүхдийнхээ асуудлыг бүрэн шийдье гэж байгаа бол үндэсний хөтөлбөр гаргаж, бүх юмаа зэрэг яриач ээ. Танайх удирдах зөвлөл нь байдаг юм уу, бага хурал нь байдаг юм уу танай мөрийн хөтөлбөрийг авч хэлэлцдэг газар хаана байдаг юм? Энэ тэгэхгүй бол тастаж авчраад чихийг нь юм уу, нүдийг нь ухаж гаргаж ирээд тэгээд энэ нь харж байна, харахгүй байна гээд яриад байх юм.

Байшин ямар ч fondement байхгүй, агаар, дотоод орчны агаарын чанар байхгүй юман дээр дээвэр яриад яах юм. Бодлогын шинэчлэлээ хийгээч. Тийм учраас энэ өмнөх тогтоолуудад байж байна.../минут дуусав./

О.Номинчимэг: Батсуурь гишүүн ээ мэдээж гишүүд өөрсдийнхөө өнцгөөс харсан үг, асуулт асууж болно. Тэгээд энэ асуудал өнөөдөр анх удаагаа бид нарт хэлэлцэгдээгүй. Бид нар эхлээд бол мэдээж энэ хууль чинь яаж хэрэгжиж байна гэдгийг хэлэлцэж байгаа. Энэтэй холбоотой асуудал. Тогтоол бол дараагийн асуудал байгаа. 3 дахь асуудал байгаа.

2 дугаарт, энэ бол Улсын Их Хурлын Байнгын хороо. Байнгын хороо. Нэг намын хурал бол биш тийм ээ. Таныг Улсын Их Хурлын гишүүн байх үед одоо энэ хэлэлцэж байгаа хууль хэрэгжиж эхэлсэн. Энэ дээрээ тодорхой энэ хууль чинь яаж хэрэгжиж ирсэн байна, юун дээрээ алдаа байна гэдгийг л бид нар өнөөдөр эхний асуудлаараа хэлэлцэж байгаа. Тэгээд үнэхээр таны хэлж байгаатай бол санал нэгдэж байгаа. Яагаад гэвэл энэ хуулиар бид нар тэр системийг нь зөв угсарч чадаагүй. Чадаагүй. Та яах вэ мэдээж намын хөтөлбөр дурдсан учраас Байнгын хорооны түвшиндээ дарга нараа яриач ээ гэсэн учраас, надад хандсан учраас би бас хэлсэн нь зөв байх гэж бодож байна.

Тэгээд бид нар энэ системийг зөв болгохын тулд одоо тэгээд л хэлэлцээд л явна шүү дээ. Тэгээд энэ л хүрээнд байж байгаа юм. Тогтоолтой холбоотой асуудлыг та бол ажлын хэсэг гарсан байгаа 3 дахь асуудал дээр бас тодруулж асууж болно гэдгийг хэлмээр байна.

Та тодруулах уу? Батсуурь гишүүний микрофон тодруулга 1 минут.

Ж.Батсуурь: Үгүй та нар ингээд өөрөөс чинь асуугаагүй юмыг хариулчихъя нэгт гэвэл.

Хоёрт гэвэл оношоо буруу тавиад байна. Бодит юм ярьж байна шүү дээ. Тэгээд ингээд оролцоод хэлээд явахлаар та нар ойлгоё, мэдэрье. Энэ нийгмийг шинэчилье гэж огтоосоо бодохгүй тэгээд л нэг атираад л биеэ хамгаалаад л, арьсаа хамгаалаад ингээд. Энэ хүмүүсийг загнаад яах юм бэ? Наад хүмүүсийн чинь хөтөлбөр нь очоогүй шүү дээ. Цогц арга хэмжээ авах ямар ч боломжийг нь танайх гаргаж өгөөгүй шүү дээ. Тэгээд тэр бодлогын шийдэл эх барьж байгаа нам юм байгаа биз дээ. Засаг барьж байгаа юм байгаа биз дээ. Тэр юмаа гаргаж өгөөгүй байж байж нэг ширхэг үс гаргаж ирээд л хүмүүсийг загнаад л, нэг ширхэг хумс гаргаж ирээд л загнаад байх юм. Тэгээд сошиал дагаж. Хүмүүс бид нарын хүүхдийн авч байгаа илчлэг муу байна гэсэн асуултыг тавьж тэрний суурийн үндэс нь юу юм бэ, эх үүсвэр нь юу юм бэ гэдэг оношоо тавихгүй байгаа байхгүй юу. Оношоо тавихгүйгээр шууд ингээд сугалж гаргаж ирээд асуудалд хандаад.../минут дуусав./

О.Номинчимэг: Батсуурь гишүүн 1 минут.

Ж.Батсуурь: Бүүр амьдралын эх үүсвэр чинь ус. Одоо энэ хүүхдэдээ хайртай хүүхдээ өндөр болгоё яаж байна ийж байна 6 сард яаж байна гэж байна вэ гээд зөндөө л тайланд нь байж байна.

1 дүгээрт усны асуудлаа бүрэн шийдэх хэрэгтэй эх үүсвэрийнх нь асуудлыг нь.

2 дугаарт усныхаа чанарын асуудлыг шийдэх ёстой. Дараа нь дулааныхаа асуудлыг шийдэх ёстой. Цэвэр, бохирынхоо асуудлыг шийдэх ёстой. Дотоод орчны чанарын асуудлыг шийдэх ёстой. Ингэж байж цаашаа явахгүй юм бол энэ асуудлуудыг мянган тогтоол гараад, мянган яамны мянган мэргэжилтнүүдийг энд авчирч нүдийг нь ухаад бол асуудал шийдэгдэхгүй. Тийм учраас би энийг юу гэж хэлэх гээд байна вэ гэхлээр та хэд ерөөсөө урваж урваганаад байлгүйгээр энэ хүүхдийнхээ асуудлыг, эрүүл мэндийнхээ асуудлыг нэг тэр бага хурлаараа байдаг юм уу, удирдах зөвлөлөөрөө байдаг юм уу цогцоор нь яриач дээ. Би 3 сонгууль дараалсан мөрийн хөтөлбөрт чинь бол энэ бүгдийг хийсэн гээд байгаа байхгүй юу. Аль нь ч хийгдээгүй байгаа байхгүй юу. Тэгэхлээр хийгдээгүй юм чинь.../минут дуусав./

О.Номинчимэг: Тийм тогтоол дээр сайжруулах саналаа та хэлж болно. Асуулт асууя гэххээд үг хэлсэн учраас би одоо харин тийм зөвөө зөв том түвшинд нь ярина. Гэхдээ усаа бүгдийг нь шийдэж чадсаны дараа хүүхдүүдийнхээ хоолыг шийдье гэдэг бол бас санал нийлэхгүй байр суурь байна. Тэгэхдээ та тодруулж асуусангүй. Үг хэлсэн учраас дараагийн Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Би өрөөндөө бас танай Байнгын хорооны хурлыг сонсож байгаад боловсруулж байгаа хуультайгаа уялдуулаад бас орж бас нэг асуултаа асууя гэж бодсон юм. Ер нь зүгээр нэг зохион байгуулалтын хувьд хэдүүлээ нэг бодмоор байна. Төсөв хүрч байна хүрэхгүй, 1 хүүхдэд 2500 төгрөг өдөрт. Ингээд 3500 болох саналыг авлаа. Сангийн яам дэмжихгүй байна. Зөв зөв болдог бол энийг нэмэх ёстой. Бүгд өнөөдөр хүүхдийн эрх ярьж байна. Өчигдөр бас Засгийн газар Хүүхдийн эрхийн Үндэсний хороогоо хуралдуулсан байна лээ. Чухал чухал

юм яриад байна лээ. Нийгмийн эрүүл мэндийн асуудлаар Эрүүл мэндийн яам яриад байгаа. Манай гишүүд Гэр бүлийн хөгжлийг дэмжих тухай хууль, Хүүхдийн хөгжлийг дэмжих тухай хууль гээд их гоё гоё нэртэй баахан хуулиуд өргөн барьж байна

Тэгэхдээ асуудал яг байндаа орохгүй байна. Хүн эрүүл энэ хоол тэжээлээс бас яг өөрийнхөө энерги гэдэг юм уу энэ ажиллах, суралцах, хөгжих тэр шим тэжээлээ олж авч байгаа. Тэгээд энийг сайн хэрэгжүүлэх нь бид нарын бас маш олон зүйлийг шийднэ. Эрүүл мэндийн салбар дээр хэмнэнэ, хүүхдүүд өсөлт өгч дээр давуу тал авчирна. Сурах, хөгжих чадвар нь нэмэгдэнэ. Бүгд мэдээд байгаа. Тэгэхээр энийг нөгөө зохион байгуулалтын хувьд жижиг жижиг аж ахуйн нэгж байгууллагуудад хариуцуулаад.

Одоо сүүлдээ ингээд сургуулиуд нь өөрсдөө хийж байгаа юм. Энийг Боловсролын яам нэгдсэн байдалд оруулах хэрэгтэй. Энэ заал, тоног төхөөрөмжтэй газруудыг нь шууд хувийн хэвшил, мэргэжлийн этгээдээр хий. Гэрээгээ сайн байгуул. Үнэхээр тэр килокалоритой хүрэхгүй байгаа бол энэ гэрээгээ дүгнэ, санхүүжилтээр нь ярь. Ийм асуудал байна уу гэхээс биш бид нар авснаар хоол тэжээлийг нэмэгдүүлж байгаа гээд манай захирал ярьж байна шүү дээ.

Үгүй ээ захирал маань бол сургуулийнхаа жинхэнэ хөтөлбөр рүү орж баймаар байна. Одоо аягүй л бол захирал сүүлдээ Дэнжийн мянга дээр л явж байх юм байна л даа. Махаа татах гээд. Барс дээр ногоогоо татах гээд. Тэгээд хүүхдүүдийн нөгөө үндсэн нөгөө сурч боловсрох асуудлыг зохион байгуулалтыг бас хаях нь нэг талдаа. Ийм нөхцөл байдал угаасаа битүү байгаа юм байна лээ. Би бас СХД-ийнхээ сургуулиудын удирдлагуудтай уулзсан.

Тэгэхээр энийг зүгээр хувийн хэвшилд нь өгнө. Хувийн хэвшил харин хэд хэдэн сургуулиудын хоол, хүнсийг хангах энэ байдал руу зохион байгуулалтыг, боломж энэ тэрийг нь өгч болдоггүй юм уу? Наад энэ их хотод байгаа маш олон тооны энэ ресторанууд чинь өглөөгүүр ерөөсөө ажиллахгүй байж байгаа шүү дээ. Тэгээд 2, 3 юм уу 2-3 сургуулиудын хоол, хүнс үйлдвэрлэлийг томоохон ресторанууд тэр орчинд нь ойрхон байгаа хэсэгтэй нь ингээд эвтэйхэн шиг зохион байгуулалтыг боломжийг олгомоор байна.

Тэгээд 1 захирал ингээд дангаараа бүх юмыг шийдэх гээд байдаг. Энийгээ ингээд захирлууд эсвэл байгаа нөөцүүдээ хамтраад дундаасаа тэр тендерийнхээ ажлын хэсгийг гаргадаг ч юм уу ийм байдлаар ингээд нэг жоохон хорших бололцоо бий юу ядаж дүүрэг дүүргээрээ?

Дараагийнх нь худалдан авах ажиллагаа дээр.../минут дуусав./

О.Номинчимэг: Сайнзориг гишүүнд нэмэлт 1 минут.

П.Сайнзориг: Худалдан авах ажиллагаа дээр энэ ялангуяа өрхийн гэж яримааргүй байгаа юм бас ер нь бас боломжийн дундаж хэмжээнд юу гэдэг юм ногоо цагаа тарьж байна, мал аж ахуй эрхэлж байна, эрчимжсэн аж ахуй эрхэлж байна. Энэ этгээдүүдээс ядаж орон нутгийн сургуулиуд худалдаж авах тэр бололцоог нь бүрдүүлж өгмөөр байна. Энэ Тендерийн хуулиар. Би ерөөсөө энийг хийх гээд л яваад байгаа юм.

Энэ дээр нэг их Дэлхийн худалдааны дүрэм зөрчөөд л, өрсөлдөөнийг ялгаварлан гадуурхсан юм үүсэхгүй байх. Би одоо Сангийн яамыг жоохон уужуухан хандаасай гэж бодож байгаа бас энэ тендерийн Доржханд сайдын тэр агентлаг. Тэгээд юм болгон дээр ингээд л худлаа нэг ийм зарчим яриад байдаг. Тэгээд энэ дээр олон хүмүүс чинь бас ажлын байртай болно. Энэ дотооддоо болон яг тэр орон нутагтаа тарьсан, ургуулсан ядаж тээврийн зардал нь хэмнэгдээд очих байхгүй юу даа. Тэгэхээр энэ чинь хүүхдүүд чинь алив бас 1 ч гэсэн, 100гр ч гэсэн хоол илүү идэх гээд байна шүү дээ. Тэгэхээр энэ байдлууд дээр ер нь ямар байр суурьтай байгаа вэ? Бас албаны хүн.../минут дуусав./

О.Номинчимэг: Худалдан авалттай холбоотой үр дүнтэй болгох аргын талаар 1 номер уу? 1 номер.

Т.Ням-Очир: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Яг энэ төвлөрсөн төв суурин газар, ялангуяа аймгийн төв, нийслэл дээр захиалгын нэгдсэн систем, түгээлтийн нэгдсэн системийг бид нар цаашдаа бол нэвтрүүлэх гарцаагүй хэрэгцээ шаардлага байгаад байгаа юм. Сургууль дээр бол гарцаа байхгүй зөвхөн халуун боловсруулах үйл ажиллагаа нь л явдаг. Тэгэхээр төмсөө бол яг арилгачихсан, ямар хоолныхоор нь магадгүй хэрччихсэн, махаа бол яг тухайн хоолныхоор нь жижиглээд яг сургууль дээр зөвхөн халуун үйлдвэрлэл явахад л бэлэн болгочихсон байдлаар.

Ингээд захиалгын нэгдсэн систем хийчих юм бол сараар захиалгын нэгдсэн систем гарчихдаг. Нийслэлийн хэмжээний захиалгын нэгдсэн ирчихдэг. Тэгэхээр хэдий хэмжээний махны хэрэглээ, хэдий хэмжээний ногооны хэрэглээ байхыг нь шалтгаалаад сонгон шалгаруулалтад шалгарсан компаниуд нь тэрийгээ нийлүүлэх захиалгаа авчихдаг. Ингээд бас яг саяын таны хэлдгээр СУ ч байдаг юм уу, GS25 ч байдаг юм уу ресторануудын түгээлтийн системийг ашиглаад өглөөд нь жишээлбэл ногоог бол өглөө болгон байдаг юм уу махыг 3 өдөрт 1 удаа байдаг юм уу ингээд түгээлтийн нэгдсэн системийг ингээд хийгээд явах юм бол төрийн байгууллага буюу сургуулиудын оролцоо багасаад энд нь аж ахуйн нэгжүүд яг захиалгынхаа системийн дагуу ордог ийм боломж нь бол байгаа гэж харж байгаа.

Тийм учраас ер нь бол цаашдаа сургуулийн хоол үйлдвэрлэл дээр энэ хүнсний хангамжийг бол ийм нэгдсэн тогтолцоо, хяналтын тогтолцоо руу шилжүүлэх ёстой гэдэг байдлаар бид нар тооцоо судалгаа хийгээд нийслэлийн зарим дүүргүүд дээр бол энийг бол яг ингээд худалдан авах ажиллагааг нь ийм байдлаар зарлая гэдэг байдлаар бол яриа хэлэлцээрүүд хийгээд ингээд явж байгаа.

Тэгэхээр төр бол ер нь зөвхөн хувийн хэвшлийн оролцох боломжийг нь л бүтэн хангаж явдаг. Тэгээд саяын яах вэ Хоролгарав захирлын хэлж байгаагаар хуучин бол ногоо хальстайгаа ирдэг, тэрийг арилгах гэж тогоочийн бэлтгэгчийн хэрэгцээ гардаг, мах ястайгаа ирдэг, тэрийг шулах гэж ингээд хэрэгцээ гардаг учраас сургууль дээр асар их үйл ажиллагаа явагдаад байгаа юм. Одоо бол тэрийг нь үгүй зөвхөн бид нар хагас бэлэн халуун үйлдвэрлэл явах боломжтой бүтээгдэхүүнүүдээ л захиалга явъя. Энийгээ магадгүй орон нутагт бол орон нутгийн байгууллагууд нь Жижиг, дунд үйлдвэрлэлд нь давуу эрхтэй байх боломжийг нь Худалдан авах ажиллагааны хууль, бусад зүйлээрээ бас нээж өгье. гэдэг ийм байдлаар бас судалгаа тооцоонууд хийгдээд бүүр тодорхой дурдвал бид нар БГД-тээ бас энийг эхлүүлчхэж болох юм байна гэдэг байдлаар яриа хэлэлцээрүүд бол хийгдээд ингээд явж байгаа.

Тэгэхээр цаашдаа бол энэ хөгжихийн хэрээр ийм зөв механизмыг нь хийх, төрийн оролцоо нь бол зөвхөн менежмент хийх байдлаар оролцдог байдлаар л ингэж явах нь зүйтэй юм байна гэж харж байгаа.

О.Номинчимэг: Сайнзориг гишүүн тодруулъя.

П.Сайнзориг: Ням-Очир дарга яг энийг хийгээрэй. Би одоо ингээд сүүлдээ сургуулиудын захирал, менежерүүд чинь ерөөсөө Дэнжийн мянга дээр явж байна гэдгийг сонссон шүү. Барс дээр ногоо татах гээд явж байна. Тэгээд захирлын хэлж байгаа үнэн шүү дээ угаасаа тогооч олдохгүй. Наадах чинь одоо бараг тогооч гэдэг чинь маш үнэ цэнтэй мэргэжил болчихсон. Доод тал нь бараг 5 саяас эхэлж байна шүү дээ ур чадвартай тогооч нар. Энэ хэмжээгээрээ л нөгөө хүүхдүүдэд очих хоолны материал чинь хорогдоод л эхэлнэ. Энэ зардлууд өсөөд ирвэл. Тэгэхээр энэ зүйлүүдийг анхаараад өгөөч ээ.

2 дугаарт, энэ шим тэжээлийн байдал дээр шинэ ногооны гэдэг юм уу бид нар бол энэ махны хэрэгцээг бас зохистой түвшинд эрүүл хооллолтын талаас нь бодлогын түвшинд оруулж өгмөөр байна. Өнөөдөр 3 улирлын хүлэмжийг дэмжиж байгаа бол энийг худалдан авалтаар дэмжээд өгвөл энэ чинь дороо сэл хийгээд босоод ирнэ. Өнөөдөр 300-400 сая долларыг бид нар Эрээнд өгдөг байхгүй юу жилд. Энэ мөнгийг дотооддоо авч үлдмээр байна. Хэрэв энэ сургуулийн хоол үйлдвэрлэлийн шугамаар дэмжээд өгвөл энэ мөнгө чинь дотооддоо үлдэнэ, энэ худалдан авалтаа дагаад энэ аж ахуйнууд чинь тогтвортой хөгжөөд эхэлнэ.

О.Номинчимэг: Дараагийн асуудал бас холбогдох асуудал байгаа учраас үргэлжлүүлээд явж болно.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо хуулийн хэрэгжилт бид нар эхлээд жоохон ялгаж салгах хэрэгтэй шүү. Энэ бол хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайлангийн хэлэлцүүлэг эхний асуудал. Хуулийн хэрэгжилттэй холбоотой энэ асуудал дээр үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

6 гишүүнээр тасаллаа. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгээд яах вэ бид нар хэрэгжилтийн үнэлгээ гээд тэгэхээр юмаа зөв л оруулж ирдэг баймаар байгаа юм. Бүх юмыг ингээд хууль, эрх зүй рүү чихмээргүй байгаа юм. Тогтолцоо руу чихмээргүй байгаа юм. Наана нь байгаа нэг асуудал нь холбогдох албан тушаалтнууд төрөөс цалин аваад 24 цаг гээд зарим нь сүүлд нь тэгж ярьдаг болсон шүү дээ. Чөмгөө дундартал нойр хоолгүй гэж ярьдаг болчихоод байгаа юм. Тэгээд энэ ажлаа хийцгээхтэй холбоотой асуудлыг л би хөндөөд байгаа юм. Аль нэг нам руу чихээд хэрэггүй л дээ Батсуурь гишүүн ээ. Та бас өөрөө сайд байсан хүн таны ч бас цэгцэлж явж байх ёстой л байсан ажлуудын нэг.

Хэрэгжилтийн үнэлгээ дээр яагаад энэ асуудлууд орж ирэхгүй байгаа юм бэ л гэдгийг би асуугаад байгаа юм. Бас юмыг бас ингэж гуйвуулж болохгүй, албан тушаалтнуудыг ингэж хамгаалж болохгүй. Ажлаа хийж чадахгүй байгаа нь үнэн шүү дээ. Тэгээд энэ нь яагаад энэ дотор орж ирэхгүй байгаа вэ л гэж би асуугаад байгаа юм? Хууль тогтоомж нь болохгүй байна, тэр нь болохгүй байна, салбар хоорондын уялдаа хангагдахгүй байна гээд байгаа байхгүй юу. Үгүй тэгээд хэн хангах юм? Тэр суман дээр байгаа үхэр хангах юм уу, эсвэл сургуулийн барилга

өөрөө хангах юм уу? Үгүй энэ чинь хүн хангана биз дээ? Албан тушаалтнууд хангаж байгаа биз дээ салбар хоорондын уялдаа холбоог? Тэгээд ямар албан тушаалтан дээр яагаад, ямар төрийн захиргааны юм уу, байгууллагаас улбаатай энэ асуудал үүсээд байгаа вэ гэдэг дүгнэлт яагаад гарахгүй байгаа юм бэ гэдгийг л би хэлээд байгаа байхгүй юу.

Эрх зүйн орчин өнөөдөр бид нар хангалттай л хууль байна. Одоо бараг Улсын Их Хурлын гишүүд шинээр хууль санаачлахаас илүүтэй байгаа 900 гаруй хуулийнхаа хэрэгжилтийг хангуулах дээр бараг ажиллахаас, ажлаа эхэлмээр ч юм шиг. Хангалттай их хууль байна. Хууль хаана очоод зогсчихоод байна гэхээр ажлаа хийдэггүй, хэрэгжүүлдэггүй албан тушаалтнууд дээр очоод зогсчихоод байгаа байхгүй юу. Би Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөөх даргаар ажиллаж байсан учраас тэр байгууллага өнөөдрийн яг хэлэлцэж байгаа асуудал дээр ямар их өндөр ач холбогдолтой вэ гэдгийг би мэдээд байгаа учраас хэлээд байгаа юм. Би өөрөө энд оролцож байсан. Энэ чинь тендер сонгон шалгаруулалтаас авхуулаад хүүхдэд очиж байгаа килокалорийг чинь аваад байгаа хүмүүс чинь тэн дотор яваад байгаа юм. Нэг талдаа.

Тэр байгууллагыг өнөөдөр удирдаж ажиллаж байгаа би зүгээр нэг албан тушаалтныг хэлээд байгаа болохоор та хэд маань бас субъектив хандаад байна гэж ойлгоод байж магадгүй. Тэр хүн өнөөдөр энд удирдаж байгаа учраас тэр асуудал нь тэр агентлаг хөдлөхгүй байгаад байгаа учраас асуудал байна байна. Батсуурь гишүүнийхтэй зарим зүйлтэй би санал нийлнэ. Суурь юмнууд нь шийдэгдээгүй байна. Сая Хөвсгөл аймгийн Рэнчинлхүмбэ сум гээд жишээ татсан чинь одоо бид нар шийдэж байгаа гээд тэгж байгаа юм. Ханхыг яах вэ, Цагаан нуурыг яах вэ, Улаан уулыг яах вэ, Баянзүрхийг яах вэ? Ганцхан Хөвсгөл аймгийн хэмжээнд шүү дээ.

Өнөөдөр тэр -45 градусын хүйтэнд 300 метр газар хоолыг нь зөөгөөд хөрөөд орж байгаа шүү дээ тэр хоол. Хүйтэн орж байгаа шүү дээ төмөр тавагт. Тэнд шаазан аяга байхгүй шүү дээ. Та хэд маань өөрсдөө мэдэж байгаа. Энэ чинь өөрөө давхар энэ хүүхдүүдийн хоол боловсруулах тогтолцооны өвчлөлд нөлөөлөөд байна гэдгийг л би хэлээд байгаа юм. Махны чинь үнэ нэмэгдэх нь тэнд авч байгаа тогтоочихсон байгаа тариф чинь инфляцтай холбогдохгүй учраас л асуудал үүсээд байна гэдгийг л уул нь хэлээд байгаа л санаа л байгаа юм. Тэгээд та хэд маань бас ухамсартай хүмүүс хүлээж аваасай гэж би хүсэж байна. Болохгүй байгаа асуудлыг байнгын хороон дээр яг болохгүйгээр нь оруулаад ирдэг байгаасай л гэж хүсээд байгаа юм. Тэгвэл бид нар шийдэхийн төлөө хамтдаа явна шүү дээ. Баярлалаа.

О.Номинчимэг: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн үг хэлье.

Х.Баасанжаргал: Сая яг Сайнзориг гишүүний ярьсан асуудлыг хөндөөд бид нар ажлын хэсэг дээрээ ярьсан юм. Яриад Хүнс, хөдөө аж ахуйн яаманд 2 удаа даалгавар өгөөд, чиглэл өгөөд юм бэлдээд ирээч ээ гээд 2 удаа буцаасан, явуулсан. Одоогоороо юм ирээгүй байгаа.

1 дүгээрт, юу гэсэн бэ гэвэл энэ ханган нийлүүлэлтийн сүлжээн дотор чинь хүүхдүүдэд үдийн хоол өгөх гэдэг чинь маш том зах зээл бий болж байна Энэ зах зээлийг орон нутгийнхаа жижиг, дунд бизнес эрхлэгч нарт нээж өгье. Ямар боломж байх вэ гэсэн эхний ажлын хэсгийн хурал дээр юу ярьж орж ирсэн бэ гэвэл орон нутгийн өмчит компани байгуулъя гэж ярьж орж ирсэн. Тэгэхээр энийг нь бол би

бол яг зүгээр хувь гишүүнийхээ хувьд би бол наадхыг чинь дэмжихгүй. Мэдээж ажлын хэсгээрээ ярьж шийднэ. Гэхдээ та нар орон нутгийнх нь тэнд ногоо тариад болж байхад тэнд компани байгуулах ямар хэрэгтэй юм. Орон нутаг тэнд иргэд өөрсдөө малаа, мал аж ахуйгаа эрхлээд болж байхад тэнд компани байгуулах ямар хэрэгтэй юм. Хэн нэгэн зоорь гээд зээл аваад зоорь тарааж өгч байхад тэрийг авчихсан хүн өнөөдөр тэнд дахиад тэр зээлээ зориулалтын дагуу ашиглаад энэ сүлжээнд оролцох боломжийг нь нээгээд өгөөч ээ.

Хоёр дахь даалгавар нь юу гэсэн бэ гэвэл танайх яг аль аль аймаг дээр ямар ямар зээл олгосон түүнтэйгээ холбоотой ямар ямар аж ахуйн нэгж энэ ханган нийлүүлэлтийн сүлжээнд орж болох вэ тэр зураглалыг 21 аймгаараа гаргаад ирээч ээ. Жишээ нь Дорноговь аймагт өндөгний үйлдвэр яг энэ үдийн хоолонд өндгөө ханган нийлүүлээд ингээд энэ сүлжээнд чинь орох боломжтой юу, гурилын зээл авсан компаниуд чинь энд баяжуулсан гурилаараа энэ ханган сүлжээнд орох боломжтой юу гээд ингээд өөрсдийнхөө энэ байгаа дата, мэдээлэл энэ бүх зүйлүүд дээрээ үндэслээд энэ сүлжээг ингээд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд энэ зураглалыг гаргаад ирээч ээ гэсэн. Ерөөсөө гаргаж ирээгүй.

Тэгээд ингээд одоо яг нэг тийм эзэнгүй юм яриад байгаа байхгүй юу. Бүүр ингээд эхний ярьж байсан юмнуудыг нь сүүл рүүгээ ч бараг мартах ч хэмжээний. Тэгэхээр ийм байдлаар энэ ажилд хандмааргүй байна Хүнс, хөдөө аж ахуйн яаманд би бол онцгойлон анхааруулж хэлье. Жамбалсүрэн дарга 2 удаа ажлын хэсгийн хуралд өөрөө бол оролцоогүй. Бусад газрын дарга нар, бусад хүмүүс нь бол оролцсон. Тэгээд нэгэнт ийм байдалд хүрсэн учраас энийг нь бол ил тод нээлттэй бол хэлэх нь зүйтэй байх. Тэгээд энийгээ цаашид анхаарч ажиллана биз.

Бид нар энэ удаа манай Их Хурал, Байнгын хорооны зүгээс энэ тогтоолыг баталсан ч бид нар хаяхгүй араас нь явна манай Байнгын хороо. Нэг бүрчлэн явна. Хойноос чинь нэг бүрчлэн шахна, шаардана, нэхнэ. Урьд өмнөх шиг бид нар нэг тогтоол баталсан гээд ингээд орхидог ийм парламент энэ удаагийн парламент биш.

2 дугаар нэг зүйл нь юу вэ гэвэл яг энэ тогтоолын төслийн ард манай Их Хурлын Хууль тогтоомжийн хэрэгжилтийн газрынхан ажиллаад нэг бүрчлэн шалгуур үзүүлэлтүүдийг оруулж ирсэн 5 жилээр нь. Яг энэ сургуулийн хоолны ханган нийлүүлэлт тэр дундаа гал тогооны хүртээмжийг энэ жил хэд болгох юм, дараа жил хэд болгох юм, түүний дараа жил хэд болгох юм гэдэг бүх тоонуудыг нь гаргаад шалгуур үзүүлэлттэй нь энэ тогтоолын төслийг бид нар оруулж ирж байгаа юм.

Тэгэхээр Сангийн яам энэ төсвийг нь баталж өгөх үүрэгтэй. Сангийн яам элдэв 7 шалтаг хэлээд энэ нийт хүүхдүүдийн эрүүл мэндийн асуудлыг дараагийн 5 жил, 10 жилийн Монголын хүн амын аюулгүй байдлын асуудлыг хойш нь тавихгүй ээ. 27 оны төсвийн төсөөлөл дээр энэ төсөв үндсэндээ 6-9 дүгээр ангийнхны хүүхдүүдийг үдийн хоолоор хангана гэдэг бол орж ирж байгаа. Тэгээд 4 дэх, 5 дахь өдөр чуулганаар хэлэлцэнэ. Байнгын хорооны гишүүд үүнд анхааралтай хандаад энэ үдийн хоолны асуудлыг бас дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна. Хэдүүлээ маш сайн энэ ажлын хэсэг цаашаа үргэлжлээд тулж ажиллая гэдэг ийм уриалга гэх юм уу, шаардлага гэх юм уу аль алийг нь хэлчихье.

О.Номинчимэг: Отгоны Саранчулуун гишүүн үг хэлье.

О.Саранчулуун: Баярлалаа. Юуны өмнө сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн хүнсний хэрэгцээ, шаардлагыг урьдчилан төлөвлөхдөө түрүүчийн хэлсэнчлэн макро болон бичил шим тэжээлийн норматив тэн дээрээ тулгуурлаад орон нутгийн онцлогт тохируулаад гаргах хэрэгтэй байна. Тэр нормативаа яаралтай батлах хэрэгтэй.

2 дугаарт, тэрэнтэйгээ уялдуулаад бас аймаг, нийслэл, сумын онцлогт тохирсон ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгоод өгөөч ээ. Хүнс үйлдвэрлэж байгаа Жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоод, аж ахуйн нэгжүүдийг энэ хүнс нийлүүлэх боломжийг хангах энэ бололцоог энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас энэ дээр нэг ажил гаргаач ээ гээд байгаа байхгүй юу. Хүнсний хувьсгал гээд хөтөлбөр яваад л байгаа шүү дээ тээ эрүүл Монгол хүн энэ тэр гээд үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байгаа хөтөлбөр эд нар энэнтэй ер нь ямар уялдаатай байх боломжтой юм бэ? Энэ дээр нэг шийдэлтэй уялдуулан шийдвэрлэх гаргалгаа хэрэгтэй байгаа.

2 дугаарт нь би тогтоолын төсөлд оруулах зүйлүүдээ бас хэлж байгаа. 2 дугаарт нь, улсын хэмжээнд ер нь энэ аймаг, нийслэл, орон нутгийн бодлого, энэ хэрэгжилтийг энэ түвшинд авч үзэх хэрэгтэй. Хүүхдийн зөвлөл, Хүүхдийн хоолны зөвлөл гэж албан бусаар хэрэгжиж байгаа энийгээ илүү албажуулъя гэсэн ийм саналыг бас бодож байна. Одоо байгаа зөвлөл болохоор хоол, хүнсний тээвэрлэлт илүү логистик талыг нь хариуцсан л чиглэл рүүгээ яваад байгаа болохоос биш хүүхэд хоол идэх хоолны танхим, дадал зуршил, нөгөө бичил макро шим тэжээлийн асуудал руу орох асуудал ерөөсөө тэр зөвлөлийн хяналт шалгалт руу ордоггүй юм шиг тайлан харагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг бас оруулна гэж ингэж бодож байна. Тэгэхээр энэ дээр та бүхэн минь бас ажиллах хэрэгтэй байна.

3 дугаарт нь энэ сүү цагаан идээний талаар нэг тоймтой юм ерөөсөө би түрүүнээс хойш асуугаад ерөөсөө хариулж чадаагүй. Ер нь энэ шим тэжээлийн бодлого өөрөө ямар парадигмаар явах юм Монгол улс? Бид нар ямар хоолоор хүүхдүүдээ тэжээх вэ, өсгөх вэ? Улс орон болгон өөрийн гэсэн хоол ундны, ходоодны, эрүүл мэндийн, биеийн анатомийн онцлогтой. Тэгэхээр ер нь Монгол Улсад хүүхдүүдээ яаж хооллож өсгөх вэ гэдэг бодлогоо нэгмөсөн гаргаад энэ дотор энэ цагаан идээ чинь хэр хэрэгцээтэй юм бэ гэдгийг нэг орон зайг нь тодорхойлсон юм ерөөсөө олж харсангүй л дээ тайлан дээр.

Тийм болохоор ер нь бид нар сүү, сүүн бүтээгдэхүүнээ хэрэглэх юм уу хэрэглэхгүй юм уу? Хэрэглэх юм бол яаж өргөжүүлэх юм? Тэгвэл энэ чинь малчдын хөдөлмөртэй холбоотой жоохон уялдаа холбоо гарч ирэх юм болов уу гэж ингэж бодоод байх юм. Тэгэхээр энэтэй холбоотой хариулт байхгүй байгаад байна. Энэ дээр бас нэг шийдлүүдийг гаргах хэрэгтэй юм болов уу гэж бодож байна. Энэ дээр тогтоол дээр оруулах саналын дагуу би хэлээд байгаа. Хамгийн чухал зүйлийг бас хэлье. Хүүхдүүд хэдэн сургууль үдийн хоолны, би үдийн хоолны цагийг сунга гэж яриагүй зохистой болгооч ээ гээд байгаа юм. Хүүхдийн тоо болон ээлжээс хамаараад сургуульд хүүхдүүд хоолоо идэх, гараа угаах, бие засах хангалттай цагийг зохицуулж өгөөч ээ. Энэ дээр ялт ч үгүй урьдчилсан байдлаар 130 сургууль гэж би тоо өмнөх хэлэлцүүлэгт сонссон.

Тэгээд одоо яг тэр яг ямар ямар сургууль, аль аймаг, сум юм, ямар ээлжтэй сургуульд боломжтой байна уу гэдэг тоймтой ийм ажлуудыг хийх хэрэгтэй. Энэ нь өөрөө үдийн хоолыг идэх дадал зуршлыг зан үйлийг дэмжихээс гадна энэ чинь

өөрөө Монгол хүний нөгөө өсгөж байгаа эрүүл мэндэд хэрэгтэй байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бол бас энэ тогтоолын төсөлд оруулж байгаа энэ дадал зуршил, зан үйлтэй холбоотой асуудал байгаа юм. Энийг бас мэдээлээд хэлье гэж бодож байна.

Хамгийн сүүлд нь хоолны энэ гэр зөвлөмж гэдэг шиг хүүхдэд чиглэсэн энэ нормативаа тун яаралтай батлахгүй бол энэ улсын төсөв, төлөвлөгөөтэй уялдахгүй бол бид нар бараг жил, дараагийн жил өнжих гээд байна. Тэгэхээр энэ дээр нэг яаравчлаад нэг арга хэмжээ авах хэрэгтэй юм болов уу гэж бодож байна. Баярлалаа.

О.Номинчимэг: Баярлалаа. Жамбалын Батсуурь гишүүн байхгүй байна. Манай Батсуурь гишүүн чинь Өргөдлийн байнгын хороон дээр ерөөсөө ирдэггүй. Тэгээд энэ асуудалд бас их ач холбогдол өгөөд орж ирэхээр нь их баярлаад саналыг нь ч бас сонсмоор байсан гараад явчих юм тийм ээ. Алга байна. Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлье.

П.Сайнзориг: Баярлалаа. Би танай Байнгын хорооны гишүүн биш тэгэхдээ ер нь байнга оролцож байгаа. Тендерийн хуулийг 6 сарын эхээр өргөн барихаар төлөвлөж байна шинэчилсэн найруулга хэлбэрээр. Тэгээд маш их олон жижиг бизнесийг дэмжих энэ юу гэдэг юм хүүхдийн хөгжлийг, өсөлт хөгжлийг дэмжих энэ бодлого, зорилтыг хэрэгжүүлэх замаар маш олон ажлын байр, жижиг аж ахуйн нэгжүүдийг дэмжиж гаргаж ирэх энэ бодлогыг уялдуулмаар байна. Одоо энэ бол боломжтой байна. Наад захын хэдүүлээ бас орон нутгийн ялангуяа орон нутагтаа тарьдаг, ургуулдаг, малаа өсгөж эрчимжсэн мал аж ахуй эрхэлж байгаа энэ хүмүүсээ дэмжье гэдэг энэ бодлогыг би Тендерийн хууль дээр оруулж өгнө. Энэ дээр Боловсролын яам бас анхаараад өгөөч. Бид нар бас хэд хэдэн хувилбараар боловсруулсан. Тэгэхдээ бас та хэд маань их албан ёсоор саналаа өгчихвөл бас болох гээд байна.

2 дугаарт, энэ шим тэжээлийн асуудал дээр би яг энэ ногоо гэдэг юм уу нарийн ногоо хэрэглэх энэ зүйлүүд нэгэнт бас Монголчуудаас бас салшгүй хэрэгцээ болсон. Тэгэхдээ энийг бас илүү их оруулж өгмөөр байна. Ялангуяа хоол, энэ ходоодны өвчлөл байдаг юм уу маш олон зүйлүүд дээр энэ ислэг ихтэй ногоо энэ тэрийг чинь хэрэглэж сурах нь бас зөв дадал байдаг юм байна лээ. Тэгэхээр энийг дамжаад бас 3 улирлын хүлэмж бас хөгжих байхгүй юу. Гадагшаа урсаад байгаа тэр олон зуун сая доллар чинь дотооддоо үлдэх энэ бололцоо байна. Яг тодорхой хэмжээний зах зээлийг худалдан авалтаар дэмжинэ гэвэл эд нар чинь хөрөнгө оруулалт хийгээд хөгжүүлнэ.

Дээрээс нь нийслэлийн энэ хэрэгжиж байгаа “Сүү” хөтөлбөрийг үнэхээр би дэмжиж байгаа шүү. Нийслэлд байж байхдаа бид нар бас ярьж байсан. Энийг дагаад “Сүү” хөтөлбөрийнхөө хажуугаар бас ааруул байдаг юм уу зарим энэ цагаан идээг бас хэрэглүүлэх тэр чиглэл рүү нь бас давхар хослуулж өгөөч. Магадгүй 5 өдрийн, 4 өдрийн сүү байж байхад 1 өдөр нь ааруул, эззгий, бяслаг ч байдаг юм уу. Энийг чинь бас жижиг савлагаатай хийдэг энэ аж ахуйн нэгжүүд бас байна. Энийг ингээд дэмжээд өгмөөр байгаа байхгүй юу. Тэгээд бид хэд энэ өв соёл болсон энэ цагаан идээ боловсруулах энэ ажлыг бас жоохон коммершиал талдаа оруулаад хэрэглэж сурах хэрэгтэй байна. Хэрэглэж сурах хэрэгтэй байна. Энийгээ дагаад маш олон жижиг ажлын байрууд бий болно. Тэгэхээр энэ дээр бас бас нийслэлийг ч гэсэн энэ санаа шийдлээ бас өргөжүүлээд 4 өдөр нь сүү байдаг юм уу 1 өдөр нь арай хатуу төлөвт байгаа тэр ааруул, эззгий, бяслаг өөр юу байж

болох вэ? Энийг ингээд хэрэглүүлэх чиглэлд нь бас ингээд бас нэг бодлогыг, энэ хөтөлбөрүүдийг өргөжүүлмээр байна гэдэг зүйлийг би бас хэлмээр байгаа юм. Энэ дээр шаардлагатай бол хамтарч ажилламаар байна гэдэг зүйлийг бас хэлье.

Дараагийн зүгээр нэг асуудал байна. Тэр зохион байгуулалтын асуудлаа анхаарчхаарай. Захирлыг яг үндсэн чиг үүрэгт нь үлдээж хайрла. Менежерийг ч гэсэн. Тэгээд одоо тогоочийн эрэлд гарна, угаагчийн эрэлд гарна. Энэ дээрээсээ болоод олон мянган хүүхдүүд хордож янз бүр болдог. Энэ захирал чинь сурган хүмүүжүүлэх ажлаа биш энэнээсээ болон хариуцлагын асуудал ярина.

Тийм учраас төр ийм юман дээр ороод орон тоо нэмнэ энэ тэр гээд дараагийн төсөв мөнгө нэхээд эхэлнэ. Тэгээд хэрэггүй байх. Хувийн хэвшлээс анхнаас нь хийдэг энийг юу гэдэг юм ойролцоо 2-3 сургуулиуд юм уу 3, 4 сургуулиудыг хамтад нь захиалгыг нь авдаг тэгээд энэ түгээлтээ хийчихдэг энэ байдал энэ тэр рүү ороод ингээд жоохон шинэлэг байдлаар нэг туршмаар байна. Тэгээд жоохон бодлогын өөрчлөлт креатив баймаар байна. Аймаар удаан байна. Юмнууд ерөөсөө ингээд нэг ийм маш олон жил энэ дарга хийж байгаа хүмүүс өөрөө өөрсдөө дүгнэлт хийгээрэй. Залхдаггүй юм уу? Салбар чинь ерөөсөө өөрчлөлт гарахгүй байна шүү дээ.

Тэгээд би энийг эцэст нь хэлмээр байна. Одоо ингээд хэдүүлээ ингээд л гишүүд бие биеэ зэмлээд л танай, манай гээд байх юм. Яг эцсийн дүндээ энэ бодлогын хэрэгжилтийг хангаж байгаа хүмүүс чинь энэ төр энэ яам, Тамгын газар сууж байгаа хүмүүс чинь мөн биз дээ? Тэгээд та нар ерөөсөө ахисан ийм үр дүн гаргахгүй байна шүү дээ. Тэгээд энэ улс төрчид нь явж л байдаг ирж л байдаг гээд цаанаа бараг ингээд л байж байгаа шүү дээ. Жоохон сэтгэлтэй байя.

О.Номинчимэг: Пүрэвбаатарын Мөнхтулга гишүүн үг хэлье ээ.

П.Мөнхтулга: Монгол Улс хүүхдийнхээ төлөө хүүхдийн мөнгө гээд 1.6 их наяд төгрөг. Үдийн хоолны хөтөлбөр гээд цэцэрлэгт 140 тэрбум энэ жилийн байдлаар, бага сургуулиудад 120 тэрбум, дотуур байранд 60 тэрбум гээд 324 тэрбум төгрөгийн төсөв гаргадаг. Өнгөрсөн жил 260 орчим байсан байх. Ингээд бодохлоор бид нар 2 их наяд төгрөгийг хүүхдүүдийнхээ хоол унданд зарцуулж байна.

Энэ 2 их наяд төгрөгөөс бид нар үр дүнг нь харахлаар өмнөх Бүгд Найрамдах Хятад Ард Улс чинь хүүхдүүдийнх нь 19 настных нь дундаж өндөр өсөлт нь хэдхэн жилийн өмнө манайхаас доор байсан бол одоо түрүүлээд явчихлаа. Оросын Холбооны Улстай яриад байх юм байхгүй. Хажуу талын хөрш Казахстан улс маань бас даваад явчихлаа. Монгол хүүхдүүд ерөөсөө гэдсээ л дүүргээд байна. Ерөөсөө хэрэгтэй минерал, эрдэс бодис, витамин байхгүй юм байна. Энэ бодит үзүүлэлт нь энэ тоогоороо илэрхийлэгдээд байна.

Тэгэхээр энэ бид нар энэ Тендерийн хууль гэж яриад байгаа. Хүүхдүүддээ бид нар ямар машины дугуй авах гэж байгаа юу, эсвэл будаг багс авах гэж байгаа юу, эндээс бол яг ингээд хэмнэлт гаргана, хамгийн хямдыг нь авна, зөвхөн дүүргэх материал авна гэж ийм хандлагаар явах ёсгүй.

Олон улсын жишиг бол бид нар ирээдүйгээ бэлдэж байгаа, ирээдүйн Монгол хүнээ бэлдэж байгаагийн хувьд Тендерийн хуулиас шал өөрөөр явмаар байгаа юм. Энийг сонгон шалгаруулдаг бүтэц, бүрэлдэхүүн нь шал өөр газар

баймаар байна. Сургуулийн захирал дээр биш. Төсөв нь бол хуваарилагдаад тодорхой хэмжээгээр батлагдах байх. Гэхдээ тэр төсвийг зарцуулахдаа эцэг эхийн төлөөлөл тендерийнх нь үнэлгээг өгдөг баймаар байна. Тэрнээс биш сургуулийн захирал биш. Хэн нэгний ашиг сонирхол, хэн нэгний түрийвчийг түнтийлгэх тийм бүрэлдэхүүн энэ хоолны сонгон шалгаруулалтыг хиймээргүй байгаа байхгүй юу.

Энэ бүрэлдэхүүн нь хэн байх вэ гэхээр тэр хүүхдийн эцэг эх, орон нутгийн үйлдвэрлэгч, шал хөндлөнгийн энэ хоолны нутришн энэ агууламж энийг шалгадаг мэргэжлийн хөндлөнгийн шинжээч ийм ашиг сонирхлын зөрчилгүй бүрэлдэхүүнээр энэ хоолыг орон нутагт нь сонгон шалгаруулдаг баймаар байгаа юм.

Тэгэхээр энэ иргэдийн оролцоог нь хангаж энэ эцсийн хэрэглэгчдийн эцэг эх хүүхдүүдийн эцэг эх өөрөө энэ хоолны сонгон шалгаруулалт тэр орон нутгийн цэвэр сүүн, сүүн бүтээгдэхүүн хамаг нөгөө өсөлт, кальци ясных нь бэхжүүлэлтэд сайн байдаг манай хөдөөгийн сумуудын энэ үйлдвэрлэгч нар малчид маань өөрсдөө энэ хүүхдэд зориулж байгаа төсвөөс бас орон нутагтаа авч үлддэг баймаар.

Хөдөөд хөдөөгийн сумдад хүүхдүүдэд өндөг бол тансаг хэрэглээ хэвээрээ байгаа шүү. Өндөг тансаг хэрэглээ хэвээрээ байгаа. Ерөнхий сайд өндөг тансаг хэрэглээ гээд олон жилийн өмнө хэлчихсэн чинь нэлээн шүүмжлүүлж байсан. Одоогоороо хэвээрээ л байгаа шүү дээ. Хөдөөгийн хүүхдүүдэд сард иддэг өндөгнийх нь тоог та нар хараад үзээрэй. Тийм болохлоор өнөөдөр тархи толгой юугаар тэжээгддэг юм. Уураг тархи чинь уургаар л тэжээгдэж байгаа. Тэр гол тэжээл, бензинийг нь бид нар өнөөдөр хангаж өгч чадахгүй байж байж зүгээр гэдсийг нь дүүргэснээрээ ирээдүйн Монгол, ирээдүйн Монголчуудыг, энэ үндэстнийг авч явна гэвэл бид нар буруу замаар явж байна.

Тийм болохлоор энэ Тендерийн хууль болон энэ энэнээс бүүр шал өөр зохион байгуулалтаар авч үзэх хэрэгтэй байгаа юм. Энэ дээр манай байгууллагынхан бодлого гаргаж ажиллаарай гэж л.

О.Номинчимэг: Баярлалаа. Санал нэг байна Мөнхтулга гишүүнтэй. Тэр хөдөө орон нутагт өөрсдөө энэ органик шим тэжээлтэй бүтээгдэхүүнээ нийлүүлж хүүхдүүдийнхээ эрүүл энэ хоолыг нийлүүлдэг энэ тогтолцоо, схемийг нь бид нар бас зөв бүрдүүлж өгөх ёстой. Тэгж байж хаа хаанаа энэ маань өөрөө зөв явах ийм болж байгаа. Тэгээд хуулийн хэрэгжилтийг харах юм бол ийм тоон дүнгээр харахаар сая бол хангалтгүй юм зөндөө байгаа. Бодит амьдрал дээр ч гэсэн бидний хүсэж хүлээж байгаа зүйлээс дутуу зүйлүүд их байгаа.

Гэхдээ энэ хуулийн хэрэгжилтийн үнэлгээ хийгээд Боловсролын яам энэ хуулиа тэгвэл өшөө сайжруулъя гэдэг дээр ажиллаж байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд Засгийн газрын түвшиндээ энийгээ олон яамдынхаа уялдааг хангуулаад энэ яг нөгөө схемээ зөв гаргах дээр маш анхаарах ёстой байгаад байна. Тэгж байж энэ олон талын оролцоотой зөв систем бүрдэхгүй бол бид нар мэдээж төсөв мөнгийг нь нэмэх шаардлагатай инфляц хүүхдүүддээ. Гэхдээ энэ нь очоод яг хүүхдүүддээ шим тэжээл болж сайн үр дүн хүрэх үү гэдэг дээр бол ялт ч үгүй тэр зохион байгуулалт схем, тогтолцооных нь асуудлыг бид бүхлээр нь бас харахаас өөр аргагүй байгаа гэдгийг бас хэлмээр байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг хэлэлцүүлж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

16.38 цаг

Дараагийн асуудал хоёр дахь асуудалд Ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах хүрээнд суралцагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх, хооллох зөв дадал төлөвшүүлэх, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг бид хэлэлцэж эхэлнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан оролцож байгаа албан тушаалтнууд өмнөхтэйгөө ижил байна.

Улсын Их Хурлын гишүүн ажлын хэсгийн ахлагч Хүрэлбаатарын Баасанжаргал таныг санал, дүгнэлтээ танилцуулахыг хүсэж байна. Энэ горимын санал гаргах уу? Тэгэх үү? хоёр дахь асуудал болон гурав дахь асуудлыг нэгтгээд явах уу? Нэг л танилцуулагчтай. Яг энэ санал, дүгнэлтийн дагуу яг энэ туссан тогтоол гарч байгаа учраас болох уу? Ингээд Баасанжаргал гишүүн танилцуулгаа хийнэ үү гэж урьж байна. Гишүүдээ дуудах уу? Хажуу талд санал хураалт дээр байгаад байна гэсэн. Тэгээд гялс ярилцаад энэ тогтоолынхоо төсөл дээр яачихмаар байх юм. Гишүүдээ түр дуудаадах уу тэгвэл? Тэгье гишүүдээ дуудаадах.

О.Номинчимэг: Хуралдаанаа үргэлжлүүлье.

Хоёр дахь, гурав дахь асуудал буюу энэ санал, дүгнэлт гаргасан ажлын хэсэг түүнээс орж ирж байгаа тогтоолыг нэгтгэн хэлэлцье гэсэн горимын саналаар санал хураалт явах гэж байна. Санал хураалтдаа бэлдье. Горимын санал буюу хэлэлцэх асуудлын хоёр, гурвыг нэгтгэн хэлэлцье гэсэн асуудлаар санал хураалт.

17 гишүүнээс 9 гишүүн дэмжсэн 52.9 хувь дэмжсэн тул горимын санал дэмжигдлээ. Тэгэхээр хоёр дахь, гурав дахь асуудлыг нэгтгэн хэлэлцье.

Ингээд ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал таныг санал, дүгнэлт болон “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулна уу гэж урьж байна.

Баасанжаргал гишүүний микрофон.

Х.Баасанжаргал: Баярлалаа. Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт тусгагдсан хүүхдийн хоол, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хэрхэн хангаж байгаа талаар мэдээлэл сонсох арга хэмжээний хүрээнд Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанаар ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсролын яам, Хөдөө аж

ахуй, хөнгөн үлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мэдээллийг сонслоо.

Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах хүрээнд суралцагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх, хооллох зөв дадал төлөвшүүлэх, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 1 дүгээр тогтоолоор байгуулсан бөгөөд ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал ахалж, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Ганмаа, Мөнхтуяа, Саранчулуун, Сарнай, Ундрам нар ажиллалаа.

Ажлын хэсэг энэ хугацаанд 2 удаа хуралдаж Боловсролын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтнуудыг хуралдаанд оролцуулан шаардлагатай тайлбар, мэдээллийг авч гаргасан судалгаатай танилцлаа.

Ажлын хэсгийн хуралдаанаар гишүүд холбогдох албан тушаалтнуудын Байнгын хорооны хуралдаанд танилцуулсан мэдээллийн хүрээнд Монгол Улсын нэгдсэн төсвийн 2027 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2028-2029 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл хэлэлцэж байгаа энэ хугацаанд Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал тусгагдаж байгаа эсэх асуудлыг хөндөн төсөвт тусгагдсан тохиолдолд хуулийн хүрээнд асуудал хариуцсан салбарын яамд урьдчилсан бэлтгэлээ хангасан эсэх, хүүхдийн эрүүл мэнд, өсөлт, шим тэжээлийн дутагдлын судалгааны үр дүн, сургуулийн хүнсний ханган нийлүүлэлт, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчин, эрүүл ахуй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал зэрэг тулгамдаж байгаа асуудлын талаар асуулт асууж, хариулт авч, санал солилцов.

Мөн ажлын хэсгийн хуралдаанд ажлын хэсгийн гишүүдийн хүсэлтээр Эрүүл мэндийн яамны хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлт өсвөр үеийнхний хоол тэжээлийн байдалд тулгамдаж буй асуудал, Боловсролын яамны хийлгэсэн Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны боловсруулсан хүнс бэлтгэлийн зураглалтай тус тус танилцаж, эдгээр мэдээлэл нь тулгамдаж буй асуудлыг тодорхойлох санал, дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулахад үндэслэл болсон.

2019 онд Ерөнхий боловсролын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль батлагдсантай холбогдуулан "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2019 оны 53 дугаар тогтоол тус тус батлагдсан бөгөөд Монгол Улсын Засгийн газрын тогтоолын хавсралтаар ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлсэн байна.

"Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2019 оны 53 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтад дунд ангийн сурагчдыг 2022-оос 23 онд, ахлах ангийн сурагчдыг 2023-аас 24 оны хичээлийн жилээс эхлүүлэн хамруулах гэж тусгагдсаныг Улсын Их Хурлын 2020 оны 70 дугаар

тогтоолоор дунд, ахлах ангийн суралцагчдыг зохих бэлтгэл хангасны үндсэн дээр үе шаттайгаар тус хамруулах гэж өөрчлөлт оруулан өнөөдрийг хүртэл гал тогооны орчин нөхцөл, хүний нөөц, төсөв санхүүжилт, хүнсний хангамжийн тогтолцоо бүрдээгүй шалтгаанаар ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн суралцагчид үдийн хоол үйлчилгээнд хамрагдаагүй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д заасны дагуу сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд суралцагчдыг тэгш хамруулах зарчмын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн дунд болон ахлах ангийн суралцагчдыг үе шаттай бүрэн хамруулах асуудлыг зайлшгүй шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна.

Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д сургуулийн 1 хүүхдэд оногдох хоолны зардлын нормативыг инфляцын түвшин болон суралцагчийн шим тэжээлийн хэрэгцээг харгалзан жил тутам шинэчлэн батлах гэж заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор хүүхдийн хоолны түүхий эдийн зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон байна.

Хүнс, импортын бараа, түлш, эрчим хүчний үнийн өсөлтөөс шалтгаалан инфляцын түвшин өссөн тул хоолны зардлын нормативыг өсөлттэй уялдуулан нэмэгдүүлэн шинэчлэн батлах шаардлагатай.

Сургуулийн хоолны үйлчилгээ нь хүүхдийн эрүүл мэнд, өсөлт хөгжилт, суралцах чадварт эерэг нөлөө үзүүлэх тул сургуулийн хоолны үйлчилгээнд баяжуулсан хүнсийг үе шаттайгаар хамруулж, эрүүл мэндийн боловсролыг дэмжих, хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмжийг стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагад нийцүүлж ундны цэвэр усаар хангах, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангах, тогтолцоо, хяналтыг сайжруулах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Ерөнхий боловсролын сургуулийн Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль нь ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн оюуны болон бие бялдрын өсөлт, хөгжлийг дэмжих, хооллох зөв дадал төлөвшүүлэхэд чиглэсэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тогтолцоо, удирдлага зохион байгуулалт, оролцогчийн эрх, үүрэг, хариуцлага, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан 5 бүлэг 14 зүйлтэй батлагдсан бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланд 34.6 хувь гэж гарсан байна нэгдсэн үнэлгээгээр.

Иймд ажлын хэсгээс Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй талаар санал, дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулах нь зүйтэй гэж үзлээ.

1 дүгээрт ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдыг үдийн хоолны үйлчилгээнд үе шаттай бүрэн хамруулж 1 хүүхдэд оногдох хоолны норматив зардлыг инфляцын түвшин, шим тэжээлийн хэрэгцээг харгалзан нэмэгдүүлэх;

2.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний байр, тоног төхөөрөмжийг эрүүл ахуй, стандартын шаардлагад нийцүүлж, шаардлагатай зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

3.Хүүхдийн өвчлөлт эрүүл мэндийн байдал, хоол, шим тэжээлийн судалгаанд тулгуурлан зохистой эрүүл хооллолтын дадал хэвшүүлэх, сургуулийн хоол, хүнсний бүтээгдэхүүнийг эрдэс, амин дэмээр баяжуулж, баяжуулсан болон органик хүнсээр ханган нийлүүлэх арга хэмжээ авах;

4.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоог нэмэгдүүлэх үр дүнтэй механизмыг бүрдүүлэх;

5.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бодлого, зохицуулалт, хэрэгжилтийн уялдааг хангах.;

6.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагаа, холбогдох судалгааг олон нийтэд нээлттэй мэдээлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах;

7.Хүнсний ханган нийлүүлэлтийн сүлжээ, дэд бүтцийг бий болгож орон нутгийн хувийн хэвшил, нөхөрлөл, хоршоодыг дэмжих бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээ авах зэрэг саналыг танилцуулж байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Өргөдлийн байнгын хорооны 2026 оны 1 дүгээр тогтоолоор байгуулагдсан Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн биелэлтийг хангуулах хүрээнд суралцагчдад чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан шим тэжээллэг хоол хүнсээр үйлчлэх, хооллох зөв дадал төлөвшүүлэх, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд эрүүл ахуйн нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судлан санал, дүгнэлт гаргах шаардлагатай бол шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн санал дүгнэлтийг хэлэлцээд “Засгийн газарт чиглэл өгөх” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулан нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал гаргасныг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хийг та бүхнээсээ хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

О.Номинчимэг: Баасанжаргал гишүүнд баярлалаа. Санал, дүгнэлт болон тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу?

Рэгдэл гишүүнээр тасаллаа. Дүгэрийн Рэгдэл гишүүн асуулт асууя.

Д.Рэгдэл: Ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлтийг сонслоо. Харьцангуй богино хугацаанд бас их хүрэлцээтэй, хүртээмжтэй сайн ажилласан гэсэн сэтгэгдэл төрж байна. Үнэхээр энэ ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдийн үдийн хоол, дотуур байрны хүүхдүүдийн хоолны асуудал бол хурц асуудлын нэг. Түрүүчийн анхны танилцуулгын үеэр бид нарт дотуур байрны хүүхдүүдийн хоолны хангамж, хүүхдүүдийн шаардагдах энергийн 70 хувийг хангадаг энэ тэр гээд л танилцуулж л байсан. Одоо тэрнээсээ нэмэгдсэн юм бол байхгүй гэдэг нь тодорхой. Ийм үед бол чухал асуудлыг бол ингээд тодорхой саналтай оруулж ирж яагаад бол баярлаж байна.

Юуны хувьд бол энэ ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэр, үйлчилгээний хуулийн хүрээнд бид нар энэ Байнгын хорооны тогтоолын төслийг бас авч хэлэлцэх гэж байгаа нь бас их зүйтэй санагдлаа.

Тэгэхдээ энд бас нэг л анхаармаар юмнууд байна. Энэ тогтоол дотор. Санал, дүгнэлтэд бол ер нь хангалттай тусгагдсан тогтоолын төсөлд жишээлбэл ингээд л 5 дугаар заалтыг аваад л үзэхэд ерөөсөө ингээд л нэг баахан асуудал сургалтын ... , хооллох соёл, зөв дадал, тэнцвэртэй хооллолт, шим бодисын суурь ойлголт, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг тусгаж ,эрүүл хооллох дадал зуршил эзэмшүүлэх, эрүүл мэндийг дэмжих зан үйлийг төлөвшүүлж, орчин бүрдүүлэх зорилгоор үдийн хоолны цагийг нэмэгдүүлэх гэж байгаа юм. Энэ олон асуудлыг үдийн хоолны цагаар хэдэн минутаар сунгаад энэ дээр ингээд шийдээд явчихна гэхэд жаахан эргэлзээтэй. Томьёоллын хувьд бол өөрчилмөөр байгаа юм.

2 дугаарт энэ 7 дугаар заалт гээд л тэгж байгаа. Уул нь их сайхан заалт. Баяжуулсан болон органик хүнсээр хангах асуудлыг үе шаттай шийдвэрлэх асуудал. Гэтэл энэ органик хүнс үйлдвэрлэдэг нөхдүүд маань ер нь органик хүнсээ одоо яаж үнэлж байгааг та бүхэн мэдэж байгаа шүү дээ. Тэгээд энэ хүүхдийн хоолны мөнгөөр 100гр органик тараг авч чадахгүй. Тэгэхээр энэ органик хүнс гэдгийг бид нар энэ рүү оруулчихвал ер нь бүтэхгүй юм болчих болов уу л гэж, бүтэл муутай заалт болчих болов уу гэж бас бодож байна.

Юуны хувьд бол энэ тогтоолыг дагуулаад нэг шалгуур үзүүлэлтүүдээ гаргаж байна. Тэгэхээр би бол энэ тогтоолыг шалгуур үзүүлэлтгүй баталчихмаар саналтай байна. Яагаад гэвэл энэ шалгуур үзүүлэлт дотор хэцүү хэцүү юмнууд байна хийхийн аргагүй. Ингээд л 100 хувь хүргэнэ. Сэтгэл ханамжийн түвшнийг 100 хувь хүргэнэ 2030 онд. Эрүүл ахуй, аюулгүй байдлын, орчны эрүүл ахуйн аюулгүй байдлын 100 хувь хүргэнэ. Энэ чинь угаасаа 100 хувь хүрэх үндэсгүй үзүүлэлт шүү дээ. Нэг хүн асуудал гаргахад л 100 хувь хүрэхгүй. Энэ тал дээрээ.

Нөгөө тал дээрээ энэ Монгол Улсын Засгийн газар бас төсөв хийх, төсвөө төлөвлөх, боловсруулах бүрэн эрхтэй. Энэ бүрэн эрхийн хэмжээ рүү нь орж ирээд л одоо.../минут дуусав./

О.Номинчимэг: Рэгдэл гишүүн тодруулъя.

Д.Рэгдэл: Судалгаа хийхэд шаардагдах 950 сая төгрөгийг тавь гээд л оруулчхаж байна. Энэ чинь бас л жаахан зохимж муутай. Тэрнээс гадна энэ тогтоол дээр бас түүнтэй төсөөтэй суралцагчдын өсөлт хөгжилт, эрүүл мэнд, хоол, шим тэжээлийн байдал, зан үйлийн судалгаа хийхэд шаардагдах төсвийг баталгаажуул гэхихсэн л байгаа юм.

Тэгэхээр энэ улсад энэ судалгаа хөгжүүлэлтийн ажлын зарлах, сонгон шалгаруулах энэ тэр чинь бүгд өөрөө хууль журмаар зохицуулагдчихсан. Тэгэхээр зэрэг ганцхан ийм төслийг аваачаад л энийг заавал төсвийг нь тавьж өг энэ тэр гэдэг бол их зохимж муутай. Тэр судалгаа хөгжүүлэлтийн ажил явдаг замаар нь явуулах тэр рүү нь оруулж өгөхөд зүйтэй ингэж санагдаад байгаа юм. Энэ дээр чинь улсын хэмжээнд жилд дунджаар дотоод, гадаадын нийлсэн 120, 30 төсөл сонгон шалгаруулж өгч байгаа юм. Тэрүүнд нь багтааж оруулахгүй ганцхан юмыг таслаад энд оруулах. Тэгээд энэ бүхэнтэй холбогдуулаад би бол.../минут дуусав./

О.Номинчимэг: Тодорхой саналууд дээр хариу тайлбар өгөх үү? Ажлын хэсгийн ахлагч Баасанжаргал гишүүн.

Х.Баасанжаргал: Энэ тогтоолын төслийн 5 дугаар заалт дээр 2 агуулга байгаа юм.

1 дүгээрт, сургалтын хөтөлбөрт ямар ямар агуулгыг тусгах ёстой юм бэ гээд Саранчулуун гишүүний гаргасан гол санал байгаа. Заавал энэ сургалтын хөтөлбөр гэдэг нь тэгэхдээ бие даасан хөтөлбөр гэхээсээ илүүтэй биологийн хичээл, химийн хичээл ч гэдэг юм уу, нийгмийн хичээл ч гэдэг юм уу эдгээр хөтөлбөрүүдэд ер нь энэ нөгөө хооллох зөв соёл, дадал, тэнцвэртэй хоол, шим тэжээлийн тухай, хүнсний аюулгүй байдлын тухай ийм ойлголтуудыг шингээж энэ сургалтын хөтөлбөрт оруулъя гэсэн үг. 1 дэх.

2 дугаарт, хүүхдүүд өнөөдөр үдийн хоол идэх гэж байгаа гээд яг завсарлагааны цаг үнэндээ ямар ч хангалтгүй байгаа юм. Тэгэхээр яг энэ 2 агуулгыг хоёуланг нь оруулаад хүүхэд наад зах нь гараа угаачих боломжтой. Гараа угааж дуусаад хоолоо идэх боломжтой, яаралгүй ийм цаг хугацаа менежментийн хувьд бол хийгээч ээ гэсэн 2 агуулга байгаа учраас 5 дугаар заалт дээр бас ингэж нэг ийм нуршсан юм шиг уншигдаад байж магадгүй. Тэгэхдээ ийм 2 өөр тусдаа агуулга байгаа шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

2 дугаарт, энэ нөгөө шалгуур үзүүлэлтийн тухайд бид хэд бүх энэ салбар яамнуудтай нь хамтарч ажиллаж байгаад та нар хамгийн гаргаж болох бөгөөд хамгийн боломжтой суурь үзүүлэлтүүд нь байгаа, цаашид яг энийгээ мониторинг хийгээд явчих боломжтой үзүүлэлтүүдээ өг өө гэдэг ийм шаардлага тавиад үүний дагуу энэ яг нөгөө шалгуур үзүүлэлтүүдийг оруулсан юм.

Тэгээд шалгуур үзүүлэлтгүй баталчихлаар яах вэ гэхээр яг нөгөө өмнөх үеийн тогтоол шиг энэ тогтоолын хэрэгжилтийг дараа нь яаж үнэлэх юм яасан бол ингээд салбарын уялдааг хангасан гэдгийг юугаар үнэлэх юм, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжсэн гэдгийг юугаар үнэлэх юм, одоо хэчнээн бизнес эрхлэгчид энд хамрагдаж байгаа юм, дараагийн жил хэд болгох юм, аль аймаг дээр хэдээр нэмэгдүүлэх юм бэ гэдэг тооцоо, судалгаа тэр зүйлүүдээр нь бид нар үнэлгээгээ хийдэг болъё. Бид нар ерөөсөө эргээд энийг хойтон өдийд дахиад үнэлээд яг манай Байнгын хороо хэрэгжихэд энэ хэрэгжилтийгээ ярихад шууд энэ тоонууд дээрээ үндэслээд бид нар ярихад маш хялбар болох болов уу гээд тэгээд ер нь бол энийг шалгуур үзүүлэлтээ баталъя гэсэн. Тэгээд бусад энд энд энд ажлын хэсэгт байгаа бүх яамнууд өөрсдөө саналаа өгөөд ингэж оруулж ирж байгаа үзүүлэлт юм.

Тэр 950 сая төгрөгийн тухайд ямар учиртай вэ гэвэл манайх ерөөсөө Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн зүгээс энэ сургуулийн хүүхдүүдийн үдийн хоол болоод өсөлт хөгжилтэй холбоотой яг ийм цогц судалгааг улсын төсвөөр хэзээ ч хийж байгаагүй юм байна лээ. Дандаа олон улсын байгууллагын тусламжаар хийж байсан. Дандаа өөр өөр зорилготой хийж байсан судалгаануудаас бид нар нэг энэ хэрэгтэй тоо байна, энэ хэрэгтэй тоо байна гэж бараг 4, 5 судалгаанаас ингэж түүвэрлэж авч байгаад яг үндсэн суурь тоонууд энэ танилцуулгууд гарсан юм.

Тэгээд Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн дээр юу яригдсан бэ гэвэл үндэсний хэмжээний судалгааг хууль дээрээ 5 жил тутамд 1 удаа судалгаа хийх ёстой юм байна лээ. Үндэсний хэмжээний судалгаа. Энийг ерөөсөө урьд өмнө хийж байгаагүй. Ийм хэмжээний судалгаа хийхэд 950 сая төгрөг боломжтой гэдэг

ийм дүн хэлсэн учраас үндэсний хэмжээний судалгааг 1 удаа хийнэ. Жил болгон түүвэр судалгаанууд хийе гэдэг байдлаар энийг оруулж ирсэн.

Ингэж судалгаатай явахгүй бол бид нар манай гишүүдийн яриад байгаа үнэхээр шим тэжээлтэй хоол хүнс өгч чадаж байна уу, үдийн хоол өгөөд хүүхдийн өсөлт, хөгжилтөд өөрчлөлт гарч чадаж байна уу, хий гэдсийг нь дүүргээд яваад байна уу, яагаад байна гэдгээ бид нар яг ийм контролтой, хяналттай явдаг баймаар байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг хийхийн тулд зайлшгүй энэ судалгааны үзүүлэлтүүд бол энэ дотор орж ирэх ёстой юм байна гээд ингээд төсөвтэй нь, түүврийн судалгаатай нь, үндэсний судалгаатай нь оруулж ирсэн.

Энэ сэтгэл ханамжийн судалгаа яг үнэн тантай бол санал нэг. 100 хувь болоход мэдээж хэцүү байх. Гэхдээ яамны зүгээс Боловсролын яамны зүгээс энэ сэтгэл ханамжийн судалгааг бол хийдэг юм байна лээ. Түүнээс гадна Саранчулуун гишүүн бас сая энэ дээр санал хэлээд сэтгэл ханамжийн судалгаанаас гадна өөр бас ганц, хоёр үзүүлэлт бол нэмье гэсэн ийм редакцын ийм засвар саналууд хэлчихсэн байгаа,

Тэгээд энэ дээр нь бид нар эргэж редакцын засвартаа явахад бол болох байх гэж бодож байгаа юм. Тэгэхээр ийм зорилготой орж ирж байгаа төсөл.

О.Номинчимэг: Рэгдэл гишүүн тодруулъя.

Д.Рэгдэл: Их ойлгомжтой хариулт өглөө. Баярлалаа. Тэгэхээр зэрэг бид нар бас энэ жишээлбэл Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн чинь одоо бүтэц, бүрэлдэхүүнийг нь аваад үзэхээр судалгааны газраас илүү нэг агентлаг шиг юм болчихоод байгаа юм шүү дээ. Ажиллагсдын 60, 70 хувь нь бол захиргааны ажил хийдэг. 20, 30, 40 хувь нь судалгаа хийдэг ийм байгууллага болчихсон байгаа. Тэгэхээр энэ судалгаа хийхэд хийх нь зөв байж мэднэ. Тэгэхээр эднийх хийнэ гэдэг бол бас эргэлзээтэй 1 дүгээрт.

2 дугаарт, хүүхдийн өгч байгаа хоол шингэж байна уу, өсөлтөд нөлөөлж байна уу гэдгээ судлахаасаа өмнө хоолоо судлаад тогтоочиход л хангалттай. Шим тэжээлийн хэрэгцээ шаардлага хангаж байна уу, амин хүчил, усны хүчлээ тэнд өгөх хэрэгцээнд нь таартал өгч байна уу, илчлэгийн хувьд Баасанжаргал гишүүнээ би танд хариулж байна шүү дээ. Танд асуулт тавьж байгаа юм. Шаардлагыг нь хангаж байна уу үгүй юү гэдгийг хоол хүнс дээр нь судалчих юмыг хүүхэд болгоныг барьж.../минут дуусав./

О.Номинчимэг: НЭМҮТ байна уу? НЭМҮТ биш юм уу. Гэхдээ Баасанжаргал гишүүн эхлээд хариулъя. Тодруулах бол.

Х.Баасанжаргал: Бид нар энэ нөгөө хариуцагч байгууллага хэн судалгаа хийх вэ гэдэг дээр тодорхой байгууллага бол бичээгүй юм. Эрүүл мэндийн яам, Сангийн яам гэдэг ийм төсвийн ерөнхийлөн захирагчаар нь бол биччихсэн байгаа юм. Зүгээр яг хэн чадавхтай хэн хийх вэ гэдэг нь мэдээж тухайн үедээ Тендерийн тухай хуулиараа, өөр бусад хууль, дүрэм, журмаараа зарлагдаад хийх байх.

Гэхдээ үндэсний хэмжээнд 1 ч удаа хийж байгаагүй энэ судалгааг бид нар хийх ёстой. 1 удаа хийе. Төсөв, мөнгийг нь бид нар энэ удаа тавиад өгье л гэдэг ийм гол зорилготой байгаа юм. Яг чадавхын асуудал дээр бол мэдээж тэр бол

дараагийн яг гүйцэтгэлийн түвшний асуудал учраас тэр үедээ бол яригдах байх гэж бодож байна.

О.Номинчимэг: Би энэ юутай Рэгдэл гишүүн 5 дугаар асуулт 5 дугаар зүйлийг хөндсөн шүү дээ тээ? Энэ эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрт хооллох зөв соёл, зөв дадал, тэнцвэртэй хоол, шимт бодисын суурь ойлголт, хүнсний бүтээгдэхүүн аюулгүй байдлын агуулгыг тусгаж, эрүүл хооллох дадал зуршил эзэмшүүлэх, эрүүл мэндийг дэмжих, зан үйлийг төлөвшүүлэх орчин бүрдүүлэх зорилгоор үдийн хоолны цагийг нэмэгдүүлэх гээд орчихсон байгаа байхгүй юу. Яах вэ энэ нөгөө ажлын хэсгийг бол бид нар байгуулахдаа юуны өмнө түрүүн хэлсэн энэ Хоол үйлдвэрлэлийн хуулиар 10.1.1-д заасан энэ хууль хэрэгжихгүй байгаа, жил болгон төсөв нэмэгдэхгүй ингээд яадаг. Би 25 оны төсвийн тодотголын ажлын хэсэг дээр байхад хүртэл хөөрхий 40-хөн тэрбум төгрөг л нэмээд өгөөч, дотуур байрныхан юуныхан гээд явж байсан. 40-хөн тэрбум төгрөг харамлаад төсөвтөө суулгүй оруулж ирэхээр энэ хүүхдүүдээсээ бид нар ерөөсөө хоол харамлаж энэ чинь цаашаа ямар эерэг үр дагавар гарах билээ гэдгээ яахгүй байгаа дээр энэ Байнгын хороо бас нэг ийм төсөв бодлогын асуудалд шахалт үзүүлье. Ингээд энэ дээр нь мэдээж үр дүнтэй байх арга хэрэгслүүдийг нь бид нар тогтолцоог нь бас нөгөө зөв тийш нь чиглүүлэх юман дээр арга хэмжээ хэрэгжүүлжээ гэсэн.

Тэгээд энэ дээр бол 5.5 дугаар асуудал бол нэлээн тийм өвөрмөц асуудал орж ирээд байгаа юм. Анхны бодож байснаас өөр. Хоолны цагийг нэмэгдүүлэх гэхээр. Тэгэхээр Боловсролын яамнаас хариулмаар байна. Яг энэ ийм зорилт Засгийн газарт бид нар үүрэг даалгавар өгөөд сургалтын хөтөлбөр болон цагийг уртасгах арга хэмжээг та нар авахад хэрэгжих боломж нь байгаа юм уу? Хэрэгжилт нь хангагдана гэж үзэж байна уу? Хүндрэлүүд гарах уу? Хэр бодитой байх вэ гэдэг дээр би нэг хариулт авчихъя тэгэх үү? 1 номер Ням-Очир дарга.

Т.Ням-Очир: Монгол улсын ерөнхий боловсролын сургуулиудыг аваад үзэхээр ялангуяа сумын сургуулиудын ачаалал буюу 1 сургуульд ноогдох хүүхдийн тоо яг сумын сургуулиудын байршлаар нь аваад үзэхээр 420 гаруй хүүхэд сумын сургуульд. Нийслэлийн сургуулиудыг аваад үзэхээр 1 сургуульд ноогдох хүүхдийн тоо 1900 болчихоод байгаа юм.

Тэгэхээр 2 ээлжтэй яг бүтэн хоолны ээлжийн коэффициент өндөр байгаа сургуулиудын хувьд бол бид нар цагаа завсарлагааны цаг буюу үдийн хоолны цагийг нэмэхэд орой тарах цаг нь оройтох, дээрээс нь ялангуяа өвөл эрт харанхуй болдог учраас бидний хувьд бол яг энэ завсарлагааны цагийг нэмэгдүүлэх бол яг хотын сургуулиудын хувьд хүнд. Хөдөөгийн сургуулиудын хувьд харьцангуйгаар 1 ээлжээр хичээллэх боломжууд нь байгаа.

Тийм учраас сумын сургуулиудыг 1 ээлжээр хичээллэх боломжтой сургуулиудыг 1 ээлжээр хичээллүүлэх, энд нь тохирсон сургалтын төлөвлөгөөнүүдийг гаргах, ялангуяа хичээлээс гадуурх үйл ажиллагаа, зөв дадал эзэмшүүлэх энэ цагуудыг сургалтын төлөвлөгөөнд нь оруулж энэтэй нь холбоотой бас санхүүжилт, бусад холбогдох шийдлүүдийг нь гаргаж өгөх ийм тооцоо, судалгааг бол бид нар Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн дээр хийж байгаа.

Тэгэхээр 1 ээлжтэй сургуулиуд 2 ээлжтэй сургууль шигээ өглөө 8-д ороод л ижилхэн 12.30-д тардаг биш бид нар хичээлээс гадуурх үйл ажиллагаа, бусад дадал, төлөвлөлийн цагуудыг үндсэн сургалтын цагт нь оруулж өгөөд энд нь

тохирох санхүүжилт, хүний нөөц юмнуудыг нь бас ингээд үе шаттай шийдээд явах юм бол энэ дээр бол цаашдаа бас Монголын боловсрол зөв шийдлүүд гарч ирнэ гэж ингэж харж байгаа.

Ер нь сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотой бид нар академик цагуудаасаа илүүтэйгээр зөв дадал эзэмшүүлэх буюу гоо зүйн цагуудыг, эрүүл мэндийн цаг, иргэний боловсрол цаг гээд энэ цагуудыг бол аль болох бууруулахгүй байх юм сан. Энэ цагуудаар хүүхдүүдэд олгож байгаа зөв дадал, төлөвшлүүдийг зөвхөн сургалтын агуулгаар биш тухайн хөтөлбөр дээр ч заасан сургалтын агуулгаар биш жишээлбэл эрүүл мэндийн цаг дээр эмчийн оролцоо, хоол зүйчийн оролцоо гэдэг ч юм уу, иргэний боловсрол цаг дээр номын санчийн оролцоотой ч юм уу ийм байдлаар агуулгуудыг тэлж хичээлээс гадуурх үйл ажиллагааг нь танхимын сургалтаар орсон мэдэл, дадлуудыг нь хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагуудаар баталгаажуулах дадал хэвшил болгох тал руу нь бас анхаарах ийм бодлого барьж байгаа. Тэгэхээр энэтэй уялдаад бас бид нар яг энэ тогтоолтын төсөлтэй холбоотой магадгүй Ки Пи Ай-аа бас илүү тодорхой болгоод ингээд явах гарц, гаргалгаанууд гарах болов уу гэсэн ийм саналтай байна.

О.Номинчимэг: Асуулт юм уу? Судалгааны асуудал уу? Судалгааны. Асуулт асууж асуух гишүүд дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү.

Саранчулуун гишүүн тасаллаа. Отгоны Саранчулуун гишүүн.

О.Саранчулуун: Одоо жишээлбэл энгийн амьдрал дээр аваад үзье л дээ. Бид нарын хамгийн их өвчлөл бол хоол боловсруулах эрхтний тогтолцооны хавдрууд байгаа. Дандаа амьдралын хэв маягтай өвчнөөс болж хүмүүс маш их нас барж байгаа. Ухраагаад үзэхээр бид нар Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хуультай болоод 3-хан жил болж байгаа. Тэр хууль дотор боловсролын байгууллага бол тэр хуулийг хэрэгжүүлэгч бас нэг үүрэгтэй. Хэдийгээр өнөөдрийн ажлын хэсгийн тогтоолтой шууд уялдаатай зүйл, заалт биш хэдий ч ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, СӨБ өөрөө Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэх үүрэг нь байгаа байхгүй юу хуулиараа. Яах вэ хүмүүс ингээд өдрийн хоолны цаг ийм эрүүл мэндийн дадал зуршлын юм ярихлаар ойлгодоггүй юм л даа. Яагаад гэхлээр өөрсдийнх нь амьдралд тэр бас сайн тусгагдаагүй байдаг учраас тийм байх гэж би бодож байна.

Гэхдээ өнөөдөр та нар бодоод үз дээ Монголд ер нь идэх юм байгаа юу? Бүх л хүмүүс өөрсдийгөө хоол зүйч, шим тэжээл судлаач гэдэг баахан их мэдэгчдийн дундуур бид нар юу идэж болох, болохгүйн дунд төөрөлдчихсөн байгаа шүү дээ улс орноороо. Тэгэхээр одоогоос бид нар хүүхдүүддээ багаас нь Монгол хүний бие анатомийн онцлогт тохироод ийм хоол идэх ёстой гэдэг юмыг багаас нь хүүхдүүддээ хоолны соёлыг төлөвшүүлэх хэрэгтэй байна. Хоолны дадал хэрэгтэй байна. Өдрийн цагт хоолыг нь идүүлж, өглөөний цайг нь уулгаж өсгөмөөр байгаа байхгүй юу. Тэгээд тэр дадал зуршлын сургууль өөрөө дэмжих ёстой. Байгууллага өөрөө тэр эрүүл мэндийг дэмжих үүрэгтэй шүү дээ. Энэ чинь байгууллагынх нь үүрэг байхгүй юу.

Тэгэхээр хуульд бай байхгүй зүйлийг, тусгаагүй зүйлийг оруулж ирэх их зовлонтой юм байна. Аргаа бараад энэ тогтоол дотор нь шингээгээд нэг эрүүл мэндийн дадал, зуршлыг оруулаад өгөөч гэдэг ийм манай тогтоолоор гаргаж байгаа ийм л асуудал байгаа.

Дээрээс нь энэ 5 дээр байгаа судалгааг дахиж харъя. Одоо эрүүл мэндийн судалгаа бол бид нар хийчихсэн. Хооллолтын байдлын судалгаа хийчихсэн. Энэ 2 судалгаа чинь хоорондоо уулзахгүй байгаа байхгүй юу. Хоолноос болж эрүүл мэнд нь ингээд байгаа гэдэг судалгаа хийж чадахгүй байна шүү дээ. Хийхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр тэрийгээ хийх хэрэгтэй байгаа байхгүй юу. Ямар хоол идээд яаж өвдөөд байгаа юм. Улс орноороо л болсон болоогүй юм идээд л, болсон болоогүй юм нь хордоод л ингээд л явж байгаа. Одоо ч гэсэн тэр үе нь байж л байгаа шүү дээ.

Тэгэхээр хүүхдүүддээ багаас нь сайн тогоочтой, сайн махтай, сайн лабораторитой, сайн сургууль мөртөө хоол идэх цаг, дадал зуршлыг дэмжихгүйгээр ер нь яаж эрүүл хүн бий болох гээд байгаа юм. Тэгээд энийгээ сургуулийн менежментээр хийгээд зохицуул л даа. Бид нар ингээд сургуулийн нөөц бололцоо гээд байх юм. Тэгвэл тэгээд л өвчтэй хүмүүсийнхээ эмнэлгийг нэмж бариад л яваад байгаа байхгүй юу. Ямар нэгэн аргаар дадал зуршлыг дэмжсэн агуулга бүх юманд орох хэрэгтэй байна угаасаа. Энэ чинь нийгмийн эрүүл мэнд, нийтийн эрүүл мэнд байхгүй юу угаасаа. Бүх хүмүүсийн нийтийн эрүүл мэнд мөн шүү дээ.

Өнөөдөр бид нар өөрсдийгөө харъя л даа. Өвчингүй хүн ер нь Монголд байгаа юм уу? Эрүүл мэндийн даатгал нь ачааллаа дийлэхгүй энэ чинь бид нарын энэ олон жил юу ч хамаагүй идэж уусан, болсон, болоогүй зөвлөгөө дагаж дэглэм барьсны л үр нөлөө шүү дээ. Тэгэхээр одоогоос хүүхдүүддээ зориулж байгаа өдөр 24 цагийн хоолыг нь бид нар зохицуулж чадахгүй байж болно. Өөрсдөөсөө хамаарах өдрийн хоолоо зөв дадалтай агуулгатайгаар заавал зохицуулах хэрэгтэй. Энэ дээр тэр төсөв байдаг юм уу, зохицуулах менежментийг нь хийх хэрэгтэй. Дэлхийн өчнөөн орон болоод байхад яагаад бид нар болдоггүй юм. Энийг бол ингэж хасах ч юм уу энэ дээр өөр тайлбартай энэ ямар шаардлагатай юм гэж харахгүй байхыг хүсэж байна.

Дараа нь би энэ тогтоолын төсөл дээр найруулгын саналууд бас нэлээн бэлдсэн байгаа. Жишээлбэл, хүнсний аюулгүй байдал гэхээсээ илүү хүнсний баталгаатай байдал, эрүүл ахуйн стандарт, усны цэвэр ус гэдгийн оронд усыг уух төхөөрөмжийн асуудлыг тусгах хэрэгтэй. Эрүүл ахуй, суралцагчдын тоотой уялдуулж энэ тооцооллыг гаргах хэрэгтэй гэх мэтээр ийм засварын шинжтэй 10 хэдэн санал байгаа. Тэрийгээ угаасаа өгөөд тэгээд энэ агуулгаа бол өөрчлөхгүйгээр батлуулах саналтай байна.

О.Номинчимэг: Агуулгын өөрчлөлт орохгүйгээр үг, үсгийн зөв томьёолол, нэр томьёоны өөрчлөлтийг редакцын засвартайгаар оруулъя гэсэн ийм саналыг Саранчулуун гишүүн гаргаж байгаа. Гишүүд үг хэлж дууслаа.

Тэгэхээр гишүүд тогтоолын төсөл дээрээ санал хураая. Санал хураалтад бэлдье. Тэгье тэгье бид нар. Ингэсэн юм байна одоо бид нар чинь дэгээрээ санал гарсан тийм үү? Рэгдэл гишүүнээс горимын биш зүгээр санал тийм үү? Яг тогтоолын төсөлд өөрчлөх санал буюу тогтоолын төслийг хавсралтгүйгээр баталъя гэсэн ийм санал гарч байгаа. Тэгэхээр бид нар гишүүнээс гарч байгаа санал дээр санал хураалтаараа л шийдээд явчихъя. Саранчулуун гишүүнийх бол редакцын асуудал учраас яг тогтоол батлах дээрээ хэлчихье.

Тэгэхээр эхлээд цөмөөрөө санал хураалтдаа бэлдье. Мөнхтуяа гишүүн, Мөнхтулга гишүүн. Тэгэхээр эхний Рэгдэл гишүүний санал буюу уг тогтоолын

төслийг хавсралтгүйгээр буюу шалгуур үзүүлэлтгүйгээр дан тогтоолын төслөөр нь баталъя гэсэн санал гарсан. Энэ Рэгдэл гишүүний саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

17 гишүүнээс 2 гишүүн буюу 11.8 гишүүн хувь нь дэмжсэн байна. Тэгэхээр санал дэмжигдсэнгүй ээ. Хэлэлцэх асуудал нь адилхан учраас шууд явчихад болно тийм ээ.

Ингээд “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар редакцын утга, агуулга өөрчлөхгүй, нэр томьёоллыг илүү тодорхой болгох редакцын засвартайгаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

10 гишүүн дэмжиж, 58.8 хувиар санал дэмжигдлээ.

“Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Баасанжаргал танилцуулна. Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Өргөдлийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул өнөөдрийн хуралдаанд өндөрлөснийг мэдэгдье.

Өнөөдөр энэ хуралдаанд оролцсон нийт ажлын хэсгийн гишүүддээ, Тамгын газрын ажилтнууддаа, гишүүддээ баярлалаа. Хуралдаан өндөрлөлөө.

17.23 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР